

Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө болон шилжин суурьшигчдын эмзэг байдлын судалгаа



Энэхүү хэвлэлд илэрхийлсэн үзэл бодол нь зохиогчийнх бөгөөд Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ)-н бодлого, байр суурийг төлөөлөхгүй болно. Аливаа нэг улс орон эсвэл газар зүйн бүс нутгийг энэхүү хэвлэлд дурдсан буюу нэрлэснээр ОУШХБ тухайн улс орон, бүс нутгийн хууль эрх зүйн болон бусад байдлын тухайд ямар нэгэн дүгнэлт, байр суурь илэрхийлээгүй болно.

ОУШХБ нь хүнлэг энэрэнгүй, эмх журамтай шилжилт хөдөлгөөн нь шилжин суурьшигчид болон нийгэмд сайн сайхныг авчирна гэсэн зарчимд итгэдэг. Засгийн газар хоорондын байгууллагын хувьд ОУШХБ нь олон улс дахь түншлэгч талуудтайгаа хамтран, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хүндрэл бэрхшээлүүдийг даван туулахад туслах, шилжилт хөдөлгөөний асуудлын талаарх ойлголтоо дээшлүүлэх, шилжилт хөдөлгөөнөөр дамжуулан нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжих болон шилжин суурьшигчдын нэр хүнд, сайн сайхныг хамгаалан дэмжиж, туслахын төлөө ажилладаг.

Энэхүү тайланг “Монгол дахь дотоодын шилжилт хөдөлгөөнийг ойлгож, удирдах нь” төслийн хүрээнд Швейцарын Хөгжлийн Агентлаг (ШХА)-н тусламжтайгаар боловсруулсан болно. Тайланд дурдсан тоо мэдээлэл, үр дүнг тусгайлан эшлээгүй тохиолдолд ШХА болон өөр бусад байгууллага, бүлэг хүмүүс, хувь хүний албан ёсны үзэл бодлыг илэрхийлэхгүй болно.

Хэвлэсэн: Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Байр
Нэгдсэн үндэстний гудамж-14
Улаанбаатар 14201
Монгол улс
Утас: +976 70 14 31 00
Цахим шуудан: iomulanbator@iom.int
Цахим хуудас: www.iom.int

Нүүр зураг: Орон нутгаас шилжин ирэгсдийн дийлэнх нь оршин суудаг Улаанбаатар хотын гэр хороолол. © ИОМ 2020/Анхбаярын ОЮУНЖАРГАЛ

Эшлэл: Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ОУШХБ), 2021. Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө болон шилжин суурьшигчдын эмзэг байдлын судалгаа. ОУШХБ. Улаанбаатар хот.

ISBN 978-92-9268-043-5 (PDF)
ISBN 978-92-9268-044-2 (print)

© ИОМ 2021



Зарим эрхийг хуулиар хамгаалсан болсон. Энэхүү бүтээлийг [Creative Commons Attribution-NonCommercial-NoDerivs 3.0 IGO License](https://creativecommons.org/licenses/by-nc-nd/3.0/igo/) (CC BY-NC-ND 3.0 IGO)*.

[Илүү дэлгэрэнгүй мэдээллийг](#) “Зохиогчийн эрх ба ашиглалтын нөхцөл”-өөс үзнэ үү.

Энэхүү хэвлэлийг боловсролын зориулалт (сурах бичигт оруулах г.м)-аас бусад буюу арилжааны болон мөнгөн урамшуулал бий болгох зорилгоор ашиглах, хэвлэн нийтлэх, түгээхийг хориглоно.

Зөвшөөрөл: Арилжааны зориулалтаар ашиглах болон бусад эрх, лицензийн хүсэлт гаргах бол publications@iom.int хаягаар ирүүлнэ үү.

* <https://creativecommons.org/licenses/by-nc-nd/3.0/igo/legalcode>

Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө болон шилжин суурьшигчдын эмзэг байдлын судалгаа



Төслийн бүхий л явцад үнэ цэнэтэй зөвлөгөө өгч дэмжлэг үзүүлсэн Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ) болон судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүн, тоо баримтын дүн шинжилгээ, тайлан бичих ажилд удирдан чиглүүлсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Маастрихтын Их Сургуулийн Инноваци ба Технологийн Эдийн Засаг, Нийгмийн Судалгааны Хүрээлэн(UNU–MERIT)-ийн зөвлөх, мөн Инноваци ба технологийн чиглэлээр мэдээлэл цуглуулах ажлын бэлтгэл үед хамтарч ажилласан Монгол Улсын Их Сургуулийн Хүн амын сургалт судалгааны төвийн мэргэжилтнүүдэд төсөл хэрэгжүүлсэн багийн хамт олны өмнөөс гүн талархал илэрхийлье.

Холбогдох албан тоотыг гаргаж өгсөн Улаанбаатар хотын Улсын бүртгэлийн газар, хотын захиргааны албан хаагчид, судалгааны 40 зорилтот хороо, 6 зорилтот дүүргийн захиргааны ажилтнуудад шилжигч өрхийг олж тогтооход чин сэтгэлээсээ тусалсан явдалд талархал илэрхийлж байна. Түүнчлэн, судалгааны мэдээлэл цуглуулах, мэдээллийг нэгтгэж оруулах, шүүж боловсруулахад тусалсан мэдээлэл цуглуулалтын багийнханд талархаж байна.

Санал бодол, туршлагаа хуваалцаж, цаг заваа зарцуулан өрхийн судалгаанд хамрагдаж, зорилтот бүлгийн хэлэлцүүлэгт оролцсон шилжигч болон шилжигч бус өрхийн төлөөлөлд онцгойлон талархал илэрхийлье. Энэхүү төслийн үр дүн нь дотоодын шилжилт хөдөлгөөнийг ойлгох, зохицуулах, эерэг хандлагыг нэвтрүүлэхэд хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна.

Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө болон шилжин суурьшигчдын эмзэг байдлын судалгааны баг нь ОУШХБ болон Хараат бус судалгааны хүрээлэн (ХБСХ)-ийн дараах төлөөллүүдээс бүрдсэн. Үүнд:

- Виктор Лютенко, Хөтөлбөрийн менежер (ОУШХБ)
- Цолмонбаатарын Эгиймаа, Бодлогын зөвлөх (ОУШХБ)
- Соня Франсен, Олон улсын зөвлөх (UNU–MERIT)
- Крейг Лошмен, Олон улсын зөвлөх (UNU–MERIT)
- Чүлтэмсүрэнгийн Тамир, Багийн удирдагч (ХБСХ)
- Дэлгэрсамбуугийн Мөнхцэцэг, Төслийн зөвлөх (ХБСХ)
- Загдбазарын Манлайбаатар, Төслийн зөвлөх (ХБСХ)
- Энх-Амгалангийн Рэнцэнханд, Төслийн зөвлөх (ХБСХ)
- Алдарын Долгион, Төслийн зөвлөх (ХБСХ)
- Лхагвын Цэлмэгсайхан, Зөвлөх (ХБСХ)
- Дэхчинжавын Түвшинтөгс, Төслийн зохицуулагч, судлаач (ХБСХ)



Талархал	iii
Хүснэгт болон зургийн жагсаалт	vi
Товчилсон үгсийн жагсаалт	vii
Хураангуй	ix
1. Удиртгал	1
1.1. Монгол улс дахь дотоодын шилжилт хөдөлгөөний нөхцөл байдал	2
1.2. Монгол улс дахь дотоодын шилжилт хөдөлгөөний нөхцөл байдалс	8
1.2.1. Хятадын “хукоу” систем	8
1.2.2. Нигери улсын нээлттэй бэлчээрийн хориг	9
2. Судалгааны арга зүй	13
2.1. Судалгааны зорилго, зорилтууд	13
2.2. Судалгааны загвар болон хэрэглэгдэхүүн	14
2.3. Тоон болон чанарын судалгааны хамрах хүрээ, түүврийн бүрдэл	15
2.3.1. Өрхийн судалгааны түүврийн хэмжээ, бүрдэл	15
2.3.2. Чанарын судалгааны бүрдэл	17
3. Судалгааны үр дүн	19
3.1. Хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний урсгалд шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үзүүлж буй үр нөлөө	19
3.1.1. Нийслэл хот дахь шилжигчдийн тооцоолол	19
3.1.2. Бусад хүчин зүйлийн нөлөө	22
3.2. Дотоодын шилжилт хөдөлгөөний хориг нь шилжин суурьшигчдын эмзэг байдалд нөлөөлж буй байдал	24
3.2.1. Дотоодын шилжин суурьшигчдын эмзэг байдлын тодорхойлолт	24
3.2.2. Эмзэг байдлын үнэлгээний шалгуур	25
3.2.3. Шилжин суурьшигчдын эмзэг байдлын түвшинг үнэлэх арга зүй	26
3.2.4. Олон талт эмзэг байдлын индексийн тооцоолол	27
3.2.5. Шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь шилжин суурьшигчдын эмзэг байдалд хэрхэн нөлөөлснийг үнэлэх арга зүй	35
3.2.6. Вариацийн шинжилгээ болон олон хувьсагчтай регрессийн үр дүн	36
3.3. Улаанбаатар хотын оршин суугчдад шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нөлөөлсөн байдал	40
3.3.1. Эдийн засгийн сайн сайхан байдал	41
3.3.2. Нийгмийн нөхцөл байдал	42
3.3.3. Эрүүл мэнд, боловсрол	43
3.3.4. Суурь үйлчилгээ	44
3.4. Шилжигч болон шилжигч бус иргэдэд КОВИД-19 цар тахал нөлөөлсөн байдал	45
4. Дүгнэлт	49
5. Бодлогын зөвлөмж	51
Нэр томьёоны тодорхойлолт	58
Хавсралт 1. Судалгааны хүрээ	60
Хавсралт 2. Судалгааны түүврийн хэмжээний тооцоолол	63
Хавсралт 3. Тоон судалгааны түүврийн бүрэлдэхүүн, зорилтот хороогоор	64
Хавсралт 4. Олон талт эмзэг байдлын индексийг тооцоолсон арга зүй	66
Ашигласан материал	67



ХҮСНЭГТ БОЛОН ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Нийгэм, эдийн засгийн шилжилтийн дараах дотоодын шилжилт хөдөлгөөний гадагш чиглэсэн урсгал, бүс нутгаар	3
Зураг 2.	Улаанбаатар хотод шилжин суурьшиж буй иргэд болон малын тоо толгойн талаар захиргааны тоо баримт, мянгаар	3
Зураг 3.	2017-2020 оны шилжилт хөдөлгөөний хязгаарлалтаас үүдэн гарах Өөрчлөлтийн Онол	13
Зураг 4.	Мэдээлэл цуглуулсан зорилтот дүүрэг, хороод	15
Зураг 5.	Судалгааны түүврийн бүрэлдэхүүн	16
Зураг 6.	Чанарын судалгааны бүрэлдэхүүн	17
Зураг 7.	Улаанбаатар хот дахь шилжин суурьшигчдын тоо	19
Зураг 8.	Шилжилт хөдөлгөөн хийх үндсэн шалтгаан	22
Зураг 9.	Улаанбаатар хотод хөдөө орон нутгаас шилжин суурьшсан буй иргэдийн тоо	23
Зураг 10.	Шилжигч болон шилжигч бус өрхийн тэргүүний нас, хүйсийн байдал	28
Зураг 11.	Шилжин суурьшсаны дараа иргэдэд тулгарч буй гол бэрхшээлүүд, шилжилт хөдөлгөөний хугацаагаар	29
Зураг 12.	Олон талт эмзэг байдлын индексийн хистограм	30
Зураг 13.	Шилжигч болон шилжигч бус өрхийн ОТЭБИ болон бүрэлдэхүүн индекс (ЭЗБИ, ЭМБИ НИ болон СҮИ)-ийн оноо	31
Зураг 14.	Шилжигч болон шилжигч бус өрхийн дундаж ЭЗБИ үзүүлэлтийн оноо	31
Зураг 15.	Шилжигч болон шилжигч бус өрхийн орлого олж байгаа гишүүд	32
Зураг 16.	Өрхийн гол орлого олж буй гишүүдийн боловсрол, гэрлэлтийн байдал	33
Зураг 17.	Шилжигч болон шилжигч бус өрхийн ЭМБИ үзүүлэлтүүдийн дундаж оноо	34
Зураг 18.	Шилжигч болон шилжигч бус өрхийн НИ үзүүлэлтийн оноо	34
Зураг 19.	Бүртгэлгүй шилжигчдэд тулгардаг үндсэн бэрхшээлүүд	35
Зураг 20.	Шилжигч болон шилжигч бус өрхийн СҮИ үзүүлэлтийн дундаж оноо	35
Зураг 21.	КОВИД-19-тэй холбоотой өрхийн орлогод орсон өөрчлөлт	46
Зураг 22.	КОВИД-19-тэй холбоотой өрхийн орлогын өөрчлөлт	46
Зураг 23.	КОВИД-19 цар тахлаас шалтгаалан үндсэн хэрэгцээгээ хангахад өрхийн орлого хангалтгүй байх давтамж	47

Хүснэгт 1.	Хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний талаарх хууль тогтоомж, захирамж, арга хэмжээ	5
Хүснэгт 2.	Шилжилт хөдөлгөөний хориг нь иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын шалгуур үзүүлэлтийг хангасан байдал	8
Хүснэгт 3.	Судалгааны бүлгийн түүврийн хэмжээ	16
Хүснэгт 4.	Эмзэг байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлт	26
Хүснэгт 5.	Эмзэг байдлын түвшний шалгуур үзүүлэлт	27
Хүснэгт 6.	Вариацийн шинжилгээний үр дүн буюу бүртгэлийн төрлөөс хамааран олон талт эмзэг байдлын индексийн оноо өөрчлөгдөж буй эсэх	37
Хүснэгт 7.	Фишерийн хамгийн бага ач холбогдол бүхий зөрүүний загварын үр дүн	38
Хүснэгт 8.	Шилжин суурьшсан өрхийн олон талт эмзэг байдлыг тодорхойлох регрессийн үр дүн	39
Хүснэгт 9.	Богино, дунд болон урт хугацаанд зориулсан тодорхой бодлогын зөвлөмжүүд	52



ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АХС	Ажиллах хүчний судалгаа (Монгол улс)
АХБ	Азийн Хөгжлийн Банк
ANOVA	Вариацийн шинжилгээ
ГМЯ	гол мэдээлэгчийн ярилцлага
ЗБХ	зорилтот бүлгийн хэлэлцүүлэг
ИБУТЭТОУП	Иргэний болон улс төрийн эрхийн талаар олон улсын пакт
МНССБС	Монголын Нийгмийн Сайн Сайхан Байдлын Судалгаа
МСҮТ	мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НҮБЭЭНЗ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн Засаг Нийгмийн Зөвлөл
ОТЭБИ	олон талт эмзэг байдлын индекс
ОУШХБ	Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага
ӨО	Өөрчлөлтийн онол
СҮИ	суурь үйлчилгээний индекс
ТХЗ	Тогтвортой Хөгжлийн Зорилтууд
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ҮЭЗИ	Үндэсний Эрх Зүйн Институт
НҮБХТБГХТГ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хар Тамхи Болон Гэмт Хэрэгтэй Тэмцэх Газар
ХБСХ	Хараат Бус Судалгааны Хүрээлэн
ЭЗБИ	Эдийн засгийн байдлын индекс
ЭМБИ	Эрүүл мэнд, боловсролын индекс



Далайд гарцгүй Зүүн Азийн 3.2 сая хүн амтай Монгол улсад хөдөөгөөс хот руу шилжин суурьших хөдөлгөөн эрс нэмэгдэж, нийслэл Улаанбаатар хотын хүн ам 2019 оны эцэс гэхэд 1.5 сая орчим (нийт хүн амын тал)-д хүрчээ. (Нийслэлийн Статистикийн газар, 2011) Сүүлийн хорин жилийн хугацаанд хөдөө орон нутагт байгалийн гамшгийг даван туулах чадвар суларсан, харин хот суурин газруудад боловсрол эзэмших, ажил эрхлэх боломж илүү болсон, дэд бүтэц сайжирсан гэх мэт түлхэх, татах хүчин зүйлсийн нэгдэл нь хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний урсгалыг эрчимжүүлжээ. Дотоодын шилжилт хөдөлгөөн нь нийслэлд хурдацтай хотжилт, хөгжлийг авчирсан ч хотын хүн амын хэт өсөлт, төрөл бүрийн бохирдол (агаар, хөрс, ус, дуу чимээ) болон ачаалал даах хангалттай дэд бүтцийг бүрдүүлэх төрийн чадавх хүрэлцэхгүй байх зэрэг олон бэрхшээлүүдийг бий болгосон байна. (ОУШХБ, 2020б)

Энэ нөхцөл байдал нь 2017 онд Улаанбаатар хотын захиргаанаас бүртгэлийн хязгаарлалт (хориг) тавьж нийслэл хот руу чиглэсэн шилжин суурьших хөдөлгөөнийг түр зогсооход хүргэсэн юм. Тухайн үед нийслэлийн засаг дарга тус хязгаарлалтын зорилго нь “нийслэлийн оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах явдал” гэж үзсэн байна. (Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, 2017а) Шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлогыг эхний ээлжинд зөвхөн 2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байсан ч хязгаарлалтын эхний жилд хөдөөгөөс бүртгэгдсэн шилжилт хөдөлгөөний урсгал буурсан тул тус хязгаарлалтыг 2020 оны 1-р сар хүртэл сунгажээ. (Монгол Улсын Засгийн газар, 2017) Уг хязгаарлалт нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай; Улаанбаатар хотод орон сууц худалдан авсан; албан томилолтоор нийслэлд 6 сараас дээш хугацаагаар томилогдон ажиллах төрийн албан хаагч, тэдний гэр бүлийн гишүүдээс бусад бүх иргэдэд хамааралтай байв.

2020 оны эхээр цуцлагдсан шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлогын үр нөлөөний талаар тодорхой судалгаа, үнэлгээ хийгдээгүй тул энэхүү судалгааны ажил нь тус хоосон орон зайг нөхөх зорилготой бөгөөд дараах үндсэн дөрвөн асуулыг судалгааны түлхүүр асуулт болгосон юм. Үүнд: (а) Уг хязгаарлалтын бодлого хэрэгжиж байх хугацаанд шилжилт хөдөлгөөний бодит тоо хэмжээ хэд байсан бэ? (б) Хязгаарлалт нь дотоодын шилжин суурьшигчдын эмзэг байдлыг нэмэгдүүлсэн үү? (в) Хязгаарлалт нь Улаанбаатарын оршин суугчдын амьдрах орчныг сайжруулах эцсийн зорилгодоо хүрсэн үү? (г) Цаашид бодлогын ямар арга, хэмжээнүүдийг хэрэгжүүлэх вэ? Судалгааны эдгээр асуултаудад хариулахын тулд тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан ашиглалаа. Үүнд: Өрхийн асуулга, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг (ЗБХ), олон улсын болон дотоодын судалгаа, эрдэм шинжилгээний ажилд хийсэн баримт бичгийн шинжилгээ багтсан болно.

Судалгаанд 6 дүүргийн 40 хорооны нийт 1562 шилжигч болон 943 шилжигч бус өрх (нийт 2505 өрх)-ийг хамруулсан. Түүнчлэн Хүн ам, орон сууцны 2020 оны тооллого, 2007-2019 оны Ажиллах хүчний судалгаа зэрэг Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны хоёрдогч мэдээллийг судалгаанд ашиглаж хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний чиг хандлагыг тооцоолсон болно. Чанарын судалгааны хувьд эмнэлэг, цагдаа, нутгийн захиргааны байгууллагуудын төлөөлөл 15 төрийн үйлчилгээ үзүүлэгч нартай ганцаарчилсан ярилцлага, шилжигч болон шилжигч бус иргэдийн төлөөлөл 15 хүнтэй бүлгийн ярилцлагыг тус тус хийв. Энэхүү судалгааны хосолсон аргын үр дүнд судалгааны дөрвөн асуултын хүрээнд дараах дүгнэлтэд хүрлээ:



(а) Шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан хугацаанд бүртгэгдсэн шилжилт хөдөлгөөний хэмжээ буурсан ч бүртгэлгүй шилжин ирэгсдийн тоо өссөн байх магадлалтай байна.

Улаанбаатарт хөдөө орон нутгаас шилжиж ирсэн мэдээлээ бүртгүүлсэн иргэдийн албан ёсны тоо 2017 онд 25000 байсан бол 2019 онд 6800 болж эрс буурсан ч бүртгэлгүй шилжин суурьшигчдын тоо албан ёсны бүртгэлд ороогүй юм. Хамгийн сүүлийн тооллого, захиргааны мэдээлэл, чанарын судалгаанд хийсэн харьцуулсан дүн шинжилгээнээс харахад энэ хугацаанд бүртгэлгүй шилжин суурьшигчдын тоо нэмэгдсэн байх өндөр магадлалтай. Илүү тодорхой дүгнэлт гаргахад албан ёсоор бүртгэгдээгүй шилжин суурьшигчдын тоог үнэн зөв тогтоох мэдээллийн нэмэлт эх үүсвэр шаардлагатай. Нөгөө талаас бүртгэлтэй шилжин ирэгсдийн тоо буурах хандлага нь шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлогоос бус бусад нөхцөл байдал, тухайлбал судалгаанд хамруулсан цаг үе, тухайн үеийн нийгэм, эдийн засгийн хөгжил, байгалийн гамшигт үзэгдэл буурах, хөдөө орон нутагт гамшгийн бэлэн байдал сайжирсан зэрэг хүчин зүйлээс шалтгаалсан байж болзошгүй юм. Түүнчлэн бидний хийсэн судалгааны өгөгдлөөс харахад шилжилт хөдөлгөөн хязгаарласан үеэр Улаанбаатар хотод ирсэн хүмүүсийн 83 хувь нь уг хязгаарлалтын бодлогыг мэддэг эсэхээс үл хамааран шилжин ирэх байсан гэж хариулсан нь шилжин суурьшихаар завдаж буй хүмүүсийн хүсэл зоригийг бууруулна гэсэн бодлогын анхны зорилгод хүрэхэд төдийлөн нөлөө үзүүлээгүй буюу тэдний зан төлөвийг өөрчлөхөд төдийлөн нөлөөтэй байж чадаагүйг харуулж байна.

(б) Шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь шилжигч өрх, нэн ялангуяа бүртгэлгүй шилжигч өрхүүдийн болон бусад шилжигч дэд бүлгүүдийн дэд бүлгүүдийн эмзэг байдлыг нэмэгдүүлсэн.

Эмзэг байдлын шинжилгээгээр дотоодын шилжин суурьшигчид нь эдийн засаг, нийгэм, эрүүл мэндийн хувьд эрсдэлд өртөж, шилжигч бус иргэдтэй харьцуулахад эмзэг байдлын түвшин нь илүү нэмэгджээ. Шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах үеэр Улаанбаатар хотод шилжин суурьшсан бүртгэлгүй иргэд Улсын бүртгэлийн мэдээллийн санд албан ёсоор бүртгүүлж, боловсрол, эрүүл мэнд болон бусад нийгмийн суурь үйлчилгээг хүртэх боломжгүй болсон тул нэмэлт бэрхшээлүүдтэй тулгарсан. Бүртгэлгүй иргэдэд тулгарсан тодорхой бэрхшээлүүд нь эрүүл мэндийн үйлчилгээ авах (29%), байр, орон сууц түрээслэх эсвэл худалдаж авах (10%), ажил олох (20%), өмч хөрөнгөтэй болох (25%) байв. Энэхүү судалгааны тайланд шилжигч өрх дотроо эмзэг бүлэгт хамаарах хэд хэдэн дэд бүлгүүдийг тодорхойлсон бөгөөд үүнд өрх толгойлсон эмэгтэй, өндөр настан, бага боловсролтой иргэд (дунд болон түүнээс доош боловсролтой), 14-өөс доош насны олон хүүхэдтэй эсхүл тэтгэврийн насны гишүүдтэй өрхүүд багтаж байна. Шилжигч өрхүүдийн дунд эмзэг байдлыг мэдрэх гол хүчин зүйл нь хүйсийн онцлог байсан нь тогтоогджээ. Тухайлбал, өрхийн орлогыг бүрдүүлэгч нь эмэгтэй байх үед эмзэг байдлын түвшин нь эрэгтэй гол орлого бүрдүүлэгчтэй өрхтэй харьцуулахад хамаагүй өндөр байв.

(в) Шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь нийслэлчүүдийн амьдрах орчныг сайжруулахад төдийлөн нөлөө үзүүлж чадаагүй байна.

2017-2020 оны хооронд шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан нь Улаанбаатар хотод амьдрах нөхцөл байдалд нөлөөлсөн эсэх талаар судалгаанд оролцогчдоос асуухад дийлэнх нь (57%) ямар ч эерэг нөлөө гараагүй гэж хариулсан бөгөөд үүнийг зорилтот бүлгийн ярилцлагад оролцогчдын олонх нь баталгаажуулсан байна. Тодруулбал судалгаанд оролцогчдын 83 хувь нь замын түгжрэл дээрдээгүй; 79 хувь нь хөрсний бохирдол нэмэгдсэн; 75 хувь нь усны бохирдол нэмэгдсэн гэж хариулсан бол 66 хувь нь ажил эрхлэлтийн түвшин дээшлээгүй, 60 хувь нь аюулгүй байдал сайжраагүй гэж тус тус хариулжээ. Шилжилт хөдөлгөөний хязгаарлалт хэрэгжих цаг үетэй зэрэгцээд түүхий нүүрс ашиглахыг хориглож сайжруулсан түлшээр хангасан, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлсэн зэрэг Засгийн газрын зорилтот арга хэмжээ нь агаарын бохирдол багасах, халамжийн дэмжлэг нэмэгдэх зэрэгт нөлөөлсөн байж болох юм. Эдгээр үр дүнгүүд нь шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь нийслэлчүүдийн амьдрах ерөнхий нөхцөлийг сайжруулах зорилгодоо хүрч чадаагүйг харуулж байна.

Нэмж дурдахад, шилжих хөдөлгөөнийг хязгаарласнаар өмнө дурдсан эрсдэлт бүлэг (жишээлбэл, өндөр настан/хүүхэдтэй өрхүүд)-ийн шилжигчид нийгмийн суурь үйлчилгээг авах боломжгүй болсноос хууль бусаар тог цахилгаан ашиглах, хүүхдээ сургуульд оруулахын тулд хахууль өгөх гэх мэт сөрөг арга замуудыг сонгоход хүрч, амьдрах орчны аюулгүй байдал нь алдагдах, эмзэг байдал нь нэмэгдэх зэрэг хүсээгүй үр дагаварт хүргэсэн болохыг орон нутгийн иргэдийг оролцуулсан ЗБХ-ээр илрүүлсэн. Мөн эрүүл мэндийн үйлчилгээний ажилтнууд бүртгэл харгалзахгүйгээр иргэдэд үйлчлэх шаардлага гардаг ч нэмэлт ачаалал, зардал нь үнэлэгддэггүй ажээ. Улаанбаатарын оршин суугчдын дотоодын шилжин суурьшигчдад хандах сөрөг хандлага, үүнээс болж бүртгэлгүй иргэдийг ялгаварлан гадуурхах байдал гардгийг зорилтот бүлгийн хэлэлцүүлгээр илрүүлсэн нь Дэлхийн Банкны 2017 оны судалгааны үр дүн ("Улаанбаатар хотын ядуурал: нөхцөл байдлыг ойлгож, тулгамдсан асуудлуудыг тодорхойлох нь") болон энэхүү тайланд танилцуулах олон улсын дотоодын шилжилт хөдөлгөөний жишээнүүдтэй нийцэж байна.



(г) Дотоод шилжилт хөдөлгөөнийг үр дүнтэй удирдахын тулд богино ба дунд хугацааны зорилтот арга хэмжээг урт хугацааны шийдлүүдтэй хавсарган хэрэгжүүлэх хэрэгтэй.

Судалгааны үр дүнд үндэслэн дотоод шилжилт хөдөлгөөнийг удирдах тогтвортой арга замын талаар баримтлах богино, дунд, урт хугацааны бодлогын зөвлөмж гаргалаа. Богино хугацаанд, олон нийтийн энэ чиглэлээрх ойлголтыг нэмэгдүүлэх, тэдэнд хүрч ажиллах замаар бүртгэлгүй шилжигчдийг илрүүлж бүртгэлд хамруулах хэрэгтэй байна. Тэгэхдээ бүртгэлгүй иргэдийн холбогдох шилжих зардлуудыг (тээврийн хэрэгсэл, интернэтэд нэвтрэх, торгууль, хураамж гэх мэт) бууруулах ёстой. Шилжилт хөдөлгөөнийг хязгаарласны сөрөг үр дагаврыг бууруулах нь онцгой ач холбогдолтой бөгөөд үүнд, өрхийн гол орлогыг эмэгтэйчүүд нь олдог, өрх толгойлсон эмэгтэй, боловсрол багатай (бүрэн дундаас доош болон түүнээс доош) эсвэл тэтгэврийн насны өрхийн тэргүүнтэй, эсвэл 14 ба түүнээс доош насны олон хүүхэдтэй бүртгэлгүй шилжигчдэд түлхүү анхаарах нь зүйтэй. Дунд хугацаанд, засгийн газар иргэдийнхээ шилжин суурьших эрхийг хууль ёсны дагуу хязгаарлахаас өмнө тухайн нөхцөл байдлыг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэхийг үндэсний болон олон улсын хүний эрхийн, шилжилт хөдөлгөөний хууль журамтай нийцэж байгаа эсэхийг харьцуулан судалж аль болох хүний эрхийг зөрчихгүйгээр зохицуулах нь зүйтэй. Түүнчлэн, энэхүү тайлан нь төрийн байгууллагын түвшинд зорилтот нөөцийг үр өгөөжтэй ашиглахын тулд үндэсний хэмжээний агентлаг байгуулах замаар шилжин суурьшигчдыг нэгтгэх, нийгэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эсвэл одоо хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн загварт дотоод шилжилт хөдөлгөөний санаачилгыг тусгах хэрэгтэйг санал болгож байна. Урт хугацааны зорилтын хувьд, орон нутгийн хөгжлийг хангахын тулд нийслэлээс гаднах дэд бүтцийг сайжруулах, төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын стратегийн зардлыг шилжилт хөдөлгөөнийг тогтворжуулах арга зам болгон ашиглахыг зөвлөж байна. Түүнчлэн, гамшгийн хор уршгийг бууруулах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, сэргээн босгоход чиглэсэн гамшиг, онцгой байдлын цогц менежментийг орон нутгийн засаг захиргааны түвшинд дээрээс доош, доороос дээш чиглэсэн байдлаар цогцоор нь хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Алсын хараа 2050, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (Монгол улсын Их хурал, 2020) зэрэг хөгжлийн бодлого, эрх зүйн баримт бичигт шилжин суурьшилтын талаар тодорхой зорилт, үйл ажиллагааг хариуцлагын механизмын хамт тусгахыг санал болгож байна. Эцэст нь энэ чиглэлийн судалгааг цаашид үргэлжлүүлэх, гүнзгийрүүлэн судлах, судалгааны үр дүнг тархах, санал зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт зохион байгуулах болон бусад нэмэлт судалгаа шинжилгээ хийхийг зөвлөж байна.

Энэхүү тайлан нь хүн ам зүйн үндсэн үзүүлэлтээр ангилсан асуулга судалгааны иж бүрэн мэдээллийг ашиглан Улаанбаатар хотын захиргаанаас хэрэгжүүлсэн шилжих хөдөлгөөнийг хязгаарлах бодлогын үр нөлөөг шинжилсэн Монгол дахь анхны тайлан юм. Судалгааны төслийг КОВИД-19 цар тахал ба Монгол улсын 2020 оны парламентын сонгууль гэсэн хоёр онцлог нөхцөл байдлын дор хэрэгжүүлж дууссан гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Эдгээр үйл ажиллагаа нь мэдээлэл цуглуулахад саад учруулсан боловч КОВИД-19-ийн үр нөлөө шилжигч болон шилжигч бус хүмүүст хэрхэн нөлөөлснийг шинжлэх замаар нөхцөл байдлыг янз бүрийн талаас нь шинжлэх боломжийг олгосон билээ.



1. УДИРТГАЛ



Шилжилт хөдөлгөөн нь нүүсэн болон суурьшсан газрынхаа аль алинд нь тодорхой үр дагаваруудыг бий болгодог бөгөөд хөгжлийн зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг билээ. Шилжигчид худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаанд идэвхтэй оролцох, орлого олох, хөдөлмөрийн зах зээлийн цоорхойг нөхөх, ажлын байр бий болгох, татварын орлогыг бүрдүүлэх замаар суурьшсан газрынхаа эдийн засгийг сайжруулахад хувь нэмэр оруулдаг. (Goldin et al., 2011) Нөгөө талаас, дотоодод нөөц, боломж хязгаарлагдмал нөхцөлд шилжилт хөдөлгөөн нь хөгжлийн нөөц боломжийг өргөжүүлэх, хувь хүн, нийгмийн сайн сайхан байдлыг сайжруулахад чухал үйл явц гэж үздэг. (ОУШХБ, 2016)

Уугуул нутаг дахь орлогын ялгаа, ядуурал, хүрээлэн буй орчны тогтворгүй байдал, эрүүл мэнд, боловсрол болон бусад үндсэн үйлчилгээний чанар, хүртээмж муу байх зэрэг нь хүмүүсийг шилжин суурьшихад хүргэдэг “түлхэгч хүчин зүйл” болдог бол суурьшиж буй газрынх нь нийгэм, эдийн засгийн давуу нөхцөл байдал, илүү боломжууд шилжилт хөдөлгөөнийг “татах хүчин зүйл” болж өгдөг. (Krishnakumar ба Indumathi, 2014)

Шилжилт хөдөлгөөнд оролцсоноор хувь хүн өөрийн ажлын байрыг сайжруулах, гэр бүлийнхээ амьжиргааг дээшлүүлэх боломжтой хэдий ч суурьшсан газарт нь ажил, амьдралын нөхцөл тааруу, нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарлагдмал, ялгаварлан гадуурхах байдал, хүний эрхийн зөрчил гардаг бол шилжилт хөдөлгөөн нь эерэг үр дүн авчирч чаддаггүй. (Krishnakumar ба Indumathi, 2014) Ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд шилжих хөдөлгөөнд оролцох нь үргэлж давуу тал бий болгодоггүй бөгөөд хүмүүс урт хугацааны эдийн засгийн сайн сайханд хүрэхэд шаардагдах суурь мэдлэг, ур чадваргүйгээр улс, орон, амьдардаг газраа орхиж нүүсэн тохиолдолд эсрэгээрээ ихээхэн зардлыг үүсгэж байдаг.

Дэлхийн улс орнууд шилжилт хөдөлгөөний бодлогоо тодорхойлохдоо эдийн засаг болон үндэсний аюулгүй байдлын хүчин зүйлүүдийг харгалзан үздэг. Засгийн газрууд шилжин суурьшигчдын орох, гарах урсгалыг удирдах, зохицуулахдаа бодлогын янз бүрийн арга хэрэгслийг ашиглаж байдаг ба тэдгээрийн нэг нь шилжилт хөдөлгөөнийг хууль ёсоор хязгаарлах, хорих билээ. Гэвч шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлого нь шилжих хөдөлгөөний тоо хэмжээнээс илүүтэйгээр шилжилт хөдөлгөөний чиглэлд илүү их нөлөөлдөг бөгөөд хязгаарлалт хэрэгжүүлсэн ч шилжилт хөдөлгөөн үргэлжилсэн хэвээр байдаг. (Czaika ба Haas, 2013)

Дараагийн хэсэгт Монгол дахь хөдөөгөөс нийслэл хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний талаар хийсэн судалгааны ажлын үр дүн (судлагдсан байдлын тойм), дотоод шилжилт хөдөлгөөнд нөлөөлж буй түлхэх болон татах хүчин зүйлүүд, урсгалыг зохицуулах талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар нэгтгэн дүгнэлээ. Мөн дотоод шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлсэн бусад орны туршлагаудыг харьцуулан харуулав.



1.1. МОНГОЛ УЛС ДАХЬ ДОТООДЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

1990 онд хийгдсэн нийгэм эдийн засгийн шилжилтээс өмнө Монгол Улсын Засгийн газар шилжилт хөдөлгөөнийг бүрэн хянадаг байсан бөгөөд хүмүүс аймгийн төв¹, нийслэл хот руу чөлөөтэй нүүх, шилжин суурьших эрхгүй байсан. (Алгаа, 2007) Социализмын үед шилжилт хөдөлгөөнийг төвлөрүүлэн хянаж, үйлдвэрийн ажилчдыг элсүүлэхийн тулд хотжилтыг сурталчилж байжээ. 1990 он гэхэд монголчуудын 55-60 хувь нь хот суурин газарт амьдарч байв. Хүн амын үлдсэн хэсгийн дийлэнх нь орон нутагт, сумын төв² -үүдэд амьдардаг байсан бөгөөд сургууль (дотуур байрыг оролцуулан), театр, нийтийн тээврийн хэрэгсэл, хэвлэл мэдээлэл, тог цахилгаан зэрэг нь оршин суугчдад хүртээмжтэй байсан нь амьжиргааны түвшин нь харьцангуй өндөр, өнөөгийнхтэй харьцуулах боломжтой байсныг харуулж байна. Энэ нь хөдөө орон нутагт ч гэсэн амьжиргааны түвшин, стандарт өндөр болоход хүргэсэн юм. (Gilberg ба Svantesson, 1999) Нэмж дурдахад, газрыг хүн бүр хамтаараа чөлөөтэй ашиглаж байсан ч 1992 он хүртэл иргэд газар өмчлөх боломжгүй байлаа.

Ардчилсан хувьсгалын дараа, Засгийн газар иргэдэд газар, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг хувьдаа өмчлөхийг зөвшөөрч, ардчилсан Монгол Улсын анхны Үндсэн хуулийг батлав. Үүгээр Монголчуудад өмчтэй болох боломж нээгдэж, шилжин суурьших эрх чөлөөтэй болсон байна. Шинэ үндсэн хууль батлагдсаны дараа 1994 онд Газрын тухай хууль батлагджээ. (2002 оны 6-р сарын 7-ны өдөр шинэчлэн найруулсан) Газрын тухай хуулийн 3.1.3-т “газар эзэмших” гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгах” гэж тодорхойлжээ. Энэ хуулиар Монгол улсын иргэдэд Монгол улсын нутаг дэвсгэрт газар эзэмших, өмчлөх боломжийг олгосон. Нийслэлд 0,07 га газар өмчлөх эрхээр хязгаарлагдаж байгаа бол аймгийн төвийн оршин суугчид 0,35 га, сумын иргэд 0,5 га хүртэл газар өмчилж болно. Ялангуяа, хөдөө аж ахуйн хувьчлалаар өрхүүдэд мал сүргийг өмчилж мал аж ахуй эрхлэх боломж олгосон нь хотоос хөдөө рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөнд ихээхэн нөлөөлсөн байна. Дотоодын шилжилт хөдөлгөөний талаарх үндэсний статистик мэдээллээс харахад хөдөө орон нутгийн дийлэнх хэсэг, ялангуяа хангай ба төвийн бүсүүдэд шилжин суурьшигчдын тоо 1991-1992 оны нийгэм, эдийн засгийн шилжилтийн дараа мэдэгдэхүйц нэмэгдэж 1999 он хүртэл өссөн хэвээр байжээ. (ҮСХ, 2020а)

Малчид голдуу төвийн бүсийн аймгууд руу (жишээлбэл төв, хангайн бүс) эсвэл аймгийн төв, томоохон сууринг чиглэн мал сүргээ авч нүүж эхэлсэн нь төвлөрлийг сааруулах хандлагатай байв. Ингэж олон малчин зах зээл, төрийн үйлчилгээнд хамрагдах боломжоо нэмэгдүүлсэн. (Лхагвадорж, 2013)

Зуд³ -ын давтамж улам бүр нэмэгдэж цаг агаарын нөхцөл байдал сүүлийн жилүүдэд ерөнхийдөө хүндэрсээр байна. 2000-2002, 2010 онуудад Монголын ихэнх нутаг зудад нэрвэгдсэн.

Зураг 1-ээс үзэхэд 1998 оноос хойш дараалан болсон зудын дараа нийслэл рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдэж эхэлсэн байна.


¹ Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд хуваагддаг.

² Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд хуваагддаг. Монгол улсад нийт 331 сум байдаг.

³ Зуд гэдэг нь их хэмжээний цас, хүйтэн хавсарсан байгалийн аюул үзэгдэл.

Зураг 1.

Нийгэм, эдийн засгийн шилжилтийн дараах дотоодын шилжилт хөдөлгөөний гадагш чиглэсэн урсгал, бүс нутгаар




Эх сурвалж: ҮСХ, 2020а

Бэлчээрийн доройтол, зудын давтамж болон цаг агаарын бусад эрс тэрс нөхцөл байдал нь малчдад нийгэм, эдийн засгийн олон бэрхшээлийг авчирчээ. Тухайлбал 1999-2002 оны хоорондох гурван жил дараалсан зудад нийт малын гуравны нэг хорогдсон нь (Lise at al., 2006) орон нутгийн иргэд шилжилт хөдөлгөөн хийж, хот сууринг бараадахад томоохон түлхэц болсон юм.

Албан ёсны статистикийн судалгаанаас харахад сүүлийн 10 жилийн хугацаанд жилд дунджаар 24000 болон түүнээс дээш тооны хүн Улаанбаатар хотод шилжин суурьшсан байна. 2010 оны зудын дараагаар Улаанбаатар хотын иргэний бүртгэлийн газарт орон нутгаас шилжин ирж байгаа хүмүүсийн тоо урьд жилүүдээс 40 хувиар өссөн буюу нэмэлт 10000 хүн Улаанбаатар хотод шилжин ирсэн. (статистик дээр зөвхөн албан ёсоор бүртгэлтэй хүмүүсийг багтаасан гэдгийг анхаарах хэрэгтэй)

Зураг 2.

Улаанбаатар хотод шилжин суурьшиж буй иргэд болон малын тоо толгойн талаар захиргааны тоо баримт, мянга



Эх сурвалж: ҮСХ, 2020а, 2020б

Хөдөө орон нутгаас нийслэл Улаанбаатарт шилжин суурьшиж байгаа иргэд нь харьяа дүүрэгтээ оршин суух хаягаа бүртгүүлж, харьяаллаа хотын оршин суугч



болгож шинэчлэх учиртай байдаг. Улаанбаатар хот руу бүртгэлгүйгээр шилжин суурьшиж байгаа иргэдийн талаарх албан ёсны тоо баримт, бүртгэл мэдээлэл одоогоор байхгүй байна.

2004 оноос хойш уул уурхайн салбар нь үндэсний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиараа хөдөө аж ахуйн салбараас илүү гараад байгаа билээ. Уул уурхайн салбарын энэхүү хөгжил нь орон нутгийн иргэдээс илүү хотын иргэдэд үр ашгаа өгч байна. (Mauger, 2016) Хөдөө, орон нутгийн өрхийн хувьд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүртэх боломжийг сайжруулах эрэлт, хэрэгцээ нь Улаанбаатар хот руу шилжин суурьших үндсэн хүчин зүйл, шалтгаан болж байна. Нийслэл хот бол шилжин суурьшигчдын хамгийн ихээр нүүдэллэн очдог гол байршил билээ. (Дэлхийн банк, 2017)

2017 онд Дэлхийн Банкнаас гүйцэтгэсэн “Улаанбаатар хотын ядуурал: нөхцөл байдлыг ойлгож, тулгамдсан асуудлуудыг тодорхойлох нь” сэдэвт судалгаагаар шилжигчид Улаанбаатар хотод нүүж ирсэн шалтгаанаа тайлбарлахдаа хүүхдүүд нь их сургуульд суралцах хүсэлтэй, хотын сургуулийн сургалтын чанар сайн байдаг тул хүүхдүүдийнхээ ирээдүйг баталгаажуулах шаардлагаар чанартай боловсрол олгох зорилготой гэсэн байна. Нэг талаар шинэ залуу үеийнхний хүлээлт, нөгөө талаар хөдөө орон нутагт чанартай боловсрол эзэмшиж чадахгүй байгаа нь шилжилтийн гол шалтгаан гэж үзвэл хөдөө орон нутгаас хот руу шилжих хөдөлгөөн цаашид өссөн хэвээр байна гэж дүгнэжээ. (Дэлхийн банк, 2017)

Хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний хууль эрх зүйн хүрээ бодлого, журамд туссан байдал

Хуучин Зөвлөлт Холбоот Улсын үед Монгол улс нь оршин суух зөвшөөрөл буюу “прописк” бүртгэлийн тогтолцоог ашигладаг байсан бөгөөд зөвшөөрлийг оршин суугчийн үнэмлэх дээр тэмдэглэдэг байв. Энэхүү системийн зорилго нь дотоодын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, чөлөөтэй шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах явдал байсан. Уг системээр хөдөө, хот хоёрын ялгааг социалист үзэл санаанд тулгуурлан гаргасан байдаг. (Hatcher ба Thieme, 2015) 1994 оноос хойш, нийгэм эдийн засгийн шилжилтийн дараа Монгол Улсын засгийн газар дотоодын шилжилт хөдөлгөөний асуудлыг эрх зүйн хийгээд бодлогын хүрээнд тусгаж эхэлсэн байна.

Шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахад чиглэсэн бодлогууд нь онолын хувьд дотоодын шилжилт хөдөлгөөнөөс урьдчилан сэргийлэх, чиглүүлэх, зохицуулах бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж чадаагүйгээс үүсдэг нөхцөл гэдгийг дурдах нь зүйтэй. Монгол улсын хувьд ч хязгаарлах төрлийн арга хэмжээ нь шилжилт хөдөлгөөнийг зохицуулах хамгийн эцсийн арга хэмжээ юм. Монгол улс дахь шилжилт хөдөлгөөн зөвхөн нэг чигт давамгайлж байгаа нь Улаанбаатараас өөр шилжилт хөдөлгөөнийг хүчтэй татах байршил байхгүйн илрэл бөгөөд үүнтэй уялдуулсан дотоодын шилжилт хөдөлгөөнийг шууд зохицуулах бодлого байхгүй байна. (Нарантулга, 2019)

Хүснэгт 1-т хөдөө, орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний талаар төрөөс авсан арга хэмжээнүүдийг он цагийн дарааллаар харуулав. Хүснэгтэд үзүүлсэн мэдээлэл нь бүрэн бус бөгөөд шилжих хөдөлгөөний хориг хэр үр нөлөөтэй талаарх тоо баримт хязгаарлагдмал байгааг дурдах хэрэгтэй.

Хүснэгт 1. Хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний талаарх хууль тогтоомж, захирамж, арга хэмжээ

Он	Хууль тогтоомж, захирамж, арга хэмжээ	Заалт
1994	Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, зүйл 8.2	Хуульд “нийслэлд хүн амын хэт төвлөрөл бий болох, ажил эрхлэлт, нийтийн үйлчилгээ, тээвэр, холбооны хэвийн ачаалал алдагдахаас сэргийлэх зорилгоор нийслэлд шилжин суурьших асуудлаар хууль тогтоомжийн хүрээнд зохицуулалт хийх” гэж тусгасан байна.
1995	Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс хураамж авах тухай	Иргэдийн төлөөлөгчийн хурлын 69 дүгээр шийдвэрээр дараах хураамжийг авна гэж тусгасан. Үүнд: (a) Насанд хүрсэн шилжигч бүрт – 26,000 төгрөг (b) Насанд хүрээгүй шилжигч бүрт – 13,000 төгрөг
2001	Улаанбаатар хот дахь шилжин суурьшигчдаас авах хураамжийг өсгөх тухай	69 дүгээр шийдвэрийн нэмэлт өөрчлөлтөөр шилжин суурьшигчдаас авах хураамжийн хэмжээг өсгөсөн: (a) Насанд хүрсэн шилжигч бүрт – 50,000 төгрөг (b) Насанд хүрээгүй шилжигч бүрт – 25,000 төгрөг
2003	Шилжин суурьшигчдаас хураамж авахыг цуцлах	Үндэсний Хүний Эрхийн Комиссоос Чингэлтэй дүүргийн шүүхэд 69 дүгээр шийдвэрийг цуцлуулах захирамж гаргасан.
2013	Улаанбаатар хотын мастер төлөвлөгөө боловсруулах	Мастер төлөвлөгөөнд тусгаснаар хотын төсвийн орлого бий болгож үйлчилгээний хүртээмжийг сайжруулахын тулд түр хугацааны болон бүртгэлгүй урт хугацааны шилжин суурьшилтыг хязгаарлахаар заасан.
2016	Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого	Бодлогод тусгасан үзүүлэлтэд “2020 он гэхэд хотын нийт иргэдэд эзлэх хөдөө орон нутгийн иргэдийн хувь 38 хувь байх бөгөөд 2025 онд 50 хувь болно гэж үзсэн байна.”
2017 оны 1-сар	Шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах	Нийслэл хотын засаг дарга “Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах үүднээс авах зарим арга хэмжээ” хэмээх бодлогын барим бичгийг баталсан бөгөөд 2018 оны 1 сар хүртэл хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу шилжин суурьших хөдөлгөөнийг хязгаарлана гэсэн байна.
2017 оны 12-р сар	Шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлогыг сунгах тухай	Шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлогын хэрэгжилтийг 2020 оны 1 сар хүртэл сунгасан.



Улаанбаатар хотын хүн ам тогтмол өсөж байгаатай холбоотойгоор нийслэл хот нь шинээр шилжигчид хүлээж авах, нэн ялангуяа эдийн засаг болон нийгмийн суурь үйлчилгээг хүргэхэд хүндрэл тулгараад байгаа юм. Зөвлөлт маягийн хот төлөвлөлтийн хэв шинжийг авч газар өмчлөх эрхийг хууль ёсны дагуу олгосноор хотын төв хэсэгт бага оврын барилга бүхий томоохон суурин газрууд бий болсон байна. Улаанбаатар хотод бүртгэлтэй оршин сууж буй Монгол улсын иргэд хотын захаар 700 м² газар эзэмших эрхтэй бол хотын төвөөр 400-550 м² газар эзэмших эрхтэй. Хот нь хүн амын өсөлтөд зориулж төлөвлөгдөөгүй бөгөөд төвдөө хямд орон сууц хангалттай биш байгаа байдал нь хотыг нэлээд тэлэхэд хүргэсэн байна. (Дэлхийн банк, 2017)

Улаанбаатар хотын оршин суугчдын үндсэн эрхийг хангах зорилгоор Улаанбаатар хотын Захирагчийн алба болон Нийслэл хотын Засаг даргын тамгын газар нь А/17 захирамжаар 2017 онд нийслэл хот руу шилжин суурьших иргэдийн тоог хязгаарлах бодлогыг танилцуулжээ. Тус бодлогын хүрээнд нэг жилийн хугацаанд шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах зорилготой байсан юм.

Эхний жилийн хэрэгжилтийн үр дүнд хөдөө орон нутгаас шилжин суурьших бүртгэлтэй шилжигчдийн тоо буурсан эерэг үзүүлэлт гарсан учраас бодлогын хугацааг дахин хоёр жилээр буюу 2020 оны 1 сар хүртэл сунгасан байна. Эхний жилд хэрэгжүүлсэн шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын хүрээнд 2017 оны 11 сарын байдлаар нийт 9567 хүн нийслэл хот руу байнгын оршин суухаар нүүж ирсэн бөгөөд энэ нь өмнөх жилийнхтэй харьцуулахад даруй 11552-оор бага байгаа юм. Энэ хугацаанд эсрэгээрээ 10161 хүн нийслэл хотоос хөдөө орон нутаг руу шилжин суурьшсанаар сүүлийн жилүүдэд анх удаа нийслэл хотын оршин суугчдын тоо буурсан үзүүлэлттэй гарсан юм. (Монгол улсын засгийн газар, 2017)

Шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлого нь Улаанбаатар хотын оршин суугчдын эрх ашгийг нэн түрүүнд тавьж, хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс үүдэн хүн амын нягтаршил ихэссэнтэй холбоотой гарах бэрхшээлээс хамгаалах үндсэн зорилготой юм. Энэхүү хязгаарлалтын хүрээнд хөдөө, орон нутгаас нийслэлд байнга оршин суухаар ирэх иргэдийн шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай заасан бөгөөд зөвхөн дор дурдсан гурван нөхцөлд бүртгэхийг⁴ зөвшөөрсөн юм:

- (а) эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах зайлшгүй шаардлагатай
- (б) Улаанбаатар хотод орон сууц худалдан авсан
- (в) албан томилолтоор нийслэлд 6 сараас дээш хугацаагаар томилогдон ажиллах төрийн албан хаагч, түүний гэр бүл

Улаанбаатар хотод оршин суух зөвшөөрөл авах гурван нөхцөлийн нэг нь нийслэл хотод орон сууц худалдан авах бөгөөд энэ нь шинээр шилжин суурьшигчдын хувьд боломж багатай юм.

Мөн өмнө нь хийгдсэн судалгаануудаас үзэхэд Улаанбаатар хотын уугуул оршин суугчдын зүгээс хотын ядуурлын түвшин өндөр байгаагийн шалтгаан, эмх замбараагүй байдлын эх үүсвэр нь шилжигчид гэсэн байдлаар ханддаг байна. Гэвч судалгааны үр дүнгээс харахад хотод шилжин суурьшиж байгаа иргэдийг орлогын түвшингээр нь авч үзвэл ядуу гэсэн ангилалд багтахгүй байна. (Дэлхийн Банк, 2017)

ХБСХ-ийн 2016 онд хийсэн Хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээний

⁴ Холбогдох бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр оршин суугчийн зөвшөөрөл авах.

судалгаанаас харахад шилжилт хөдөлгөөн ба боловсролын хоорондох харилцан хамаарал маш өндөр байна. Хүмүүс боловсрол эзэмшихийн тулд ажлын илүү дээр нөхцөл боломжийг хайж хот руу шилжиж байна. Хөгжингүй орнуудын хувьд шилжин суурьшиж буй хүмүүсийн 6 хувь нь дээд боловсролтой, 3 хувь нь бүрэн дунд боловсролтой байгаа юм. Хөгжингүй орнуудтай харьцуулахад Монгол улсын шилжилт хөдөлгөөн 18 хувиар илүү байна. Мөн дээд боловсролтой иргэдийг бүрэн дунд боловсролтой иргэдтэй харьцуулахад тэдний шилжилт хөдөлгөөнд оролцож буй хувь хоёр дахин их байна. (ХБСХ, 2016)

ОУШХБ-аас 2018 онд хийсэн судалгаагаар технологийн сайн хөрөнгө оруулалттай байгууллагууд нь дээд боловсролтой болон шинэ техник, технологи дээр ажиллах чадвартай ажилчдыг түлхүү татаж байгаа дүр зураг ажиглагдсан байна. Мөн төрийн болон боловсролын байгууллагууд, дэд бүтэц нь нийслэл хотдоо төвлөрсөн, хөдөө орон нутагт эдгээр боломж нь байхгүй байгаа хүмүүс Улаанбаатар хот руу өндөр боловсрол эрэлхийлж нүүх үндсэн шалтгаан болж байна гэж үзэж байна. Улсын хэмжээнд дээд боловсролын нийт 113 байгууллага байгаагаас 90 нь Улаанбаатар хотод байрлаж байна. (ОУШХБ, 2018а) Тийм ч учраас, хотын хүн ам ихэссэнээс үүссэн асуудалд зөвхөн шилжин суурьшигчдыг буруутгах нь зохисгүй юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын дагуу хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй байх, нэр төрийн хувьд тэгш эрхтэй, үндэс угсаа, арьс өнгө, хүйс, шашин шүтлэг, хэл соёл, гарал угсаа, төрөлхийн болон бусад статусаас үл хамааран ижил тэгш эрхтэй байдаг. (Нэгдсэн үндэстний байгууллага, 1948) Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын бодлого нь иргэдийнхээ нэг хэсгийг ялгаварлан гадуурхаж хөдөө, хотын иргэн гэсэн хоёр ялгаатай ангийг бий болгож, энэхүү олон улсын гэрээний дагуу хүний эрхийг шууд зөрчсөн явдал болсон юм. Олон улсын хэм хэмжээнээс гадна энэхүү бодлого нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд тусгасан “улс дотроо шилжин суурьших, гадагшаа аялах, оршин суух, улс орондоо эргэн ирэх хүний эрх” (Монгол улсын засгийн газар, 2020) болон үндсэн үйлчилгээг хүртэх эрхийг зөрчсөн (Монгол улсын их хурал, 2017) явдал юм.

Шилжилт хөдөлгөөнд чөлөөтэй оролцох эрхийг зөвхөн үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар хязгаарлаж болно. (Монгол улсын засгийн газар, 2020) Гэвч дотоодын шилжилт хөдөлгөөн нь улсын аюулгүй байдал, төрийн засаглалд ямар аюул заналхийлэл учруулсан учраас ийм арга хэмжээ авсан талаар тодорхой үндэслэл гаргаагүй байна. Иргэний болон улс төрийн эрхийн талаар олон улсын пакт (ИБУТЭТОУП)-н 19 дүгээр зүйлд тусгасанчлан өөрийн дуу хоолойг илэрхийлэх, шилжин нүүх, цуглаан зохион байгуулах, нэгдэн нийлэх зэргийг хуулийн хүрээнд хязгаарлахын тулд тодорхой нөхцөлүүдийг хангасан байх ёстой. Тодорхой эрхийг хязгаарлахын тулд дараах хүснэгтэд харуулсан жагсаалтад багтсан асуултуудад тодорхой, бүрэн хариултаудыг өгсний үндсэн дээр тус хязгаарлалтыг тавьж болох юм. Харамсалтай нь оршин суух статуст үндэслэн гаргасан шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын бодлого нь эдгээр шалгууруудын алийг нь ч хангаж чадахгүй байгаа юм.



Шалгуур үзүүлэлт	Хангаж байгаа эсэх
1. Эрхийг хязгаарлах эрх зүйн үндэслэл байгаа эсэх?	Дотоодын шилжилт хөдөлгөөн нь үндэсний аюулгүй байдал болон олон нийтийн дэг журамд аюул заналхийлэл учруулж байгаа учраас ийм арга хэмжээ авсан гэсэн тодорхой эрх зүйн үндэслэл тайлбар байхгүй байна. Хязгаарласан арга хэмжээг авахаас өмнө суурь судалгаа, нөхцөл байдлын үнэлгээ зэрэг баттай нотолгоо гаргасан судалгааг хийгээгүй.
2. Эрхийг хязгаарласан явдал нь бусдын эрх, нэр төрийг хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах, олон нийтийн дэг журам, олон нийтийн эрүүл мэнд, ёс зүйг хангах зэрэг үндэслэл бүхий зорилготой эсэх?	Шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан арга хэмжээг баталсны дараа нийгмийн аюулгүй байдлыг хангах дүрэм журмыг гаргаагүй. Тийм ч учраас хязгаарлалт нь зорилготойгоо уялдахгүй байгааг харуулж байна.
3. Хэрэв хангалттай үндэслэлтэй бол хязгаарлалт нь үндэслэл бүхий зорилгодоо хүрэхэд нэн чухал, эсвэл гарах үр дүн нь хязгаарлалттай дүйцэж байгаа эсэх, үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах бодлого журам байгаа эсэх, үр дүнтэй ажиллаж байгаа эсэх нь энэхүү хязгаарлалт зохистой эсэхийг тогтоох гол үндэслэл болно.	Шилжилт хөдөлгөөний хориг нь хөдөө орон нутгийн иргэдийг ялгаварлан гадуурхсан учраас тэгш байдлын зарчимд нийцэхгүй байгаа юм. Энэхүү үйл ажиллагаа нь хөдөө орон нутгийн иргэдийн шилжин суурьших, улс орон дотроо оршин суух гэсэн үндсэн хуульд заасан эрхийг хязгаарлаж байгаа юм.
4. Хязгаарлалт нь тэгш байдлын зарчмыг харгалзан үзсэн ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд суурилсан эсэх? Ялгаварлан гадуурхах зарчимд суурилсан үйл ажиллагаа нь энэ байдлыг хангаж ажиллахгүй. Тиймээс энэ нь зайлшгүй асуух ёстой эрх тэгш байдлыг хангах гол асуулт юм.	

1.2. ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЯЗГААРЛАСАН ОЛОН УЛСЫН КЕЙС, ТУРШЛАГА

Энэхүү хэсэгт бусад улсын засгийн газрын дотоодын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах хязгаарлалт тавьсан кейсүүдийг авч үзэв. Судалгаагаар энэ төрлийн шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь Хятад, Нигери, Мьянмар зэрэг ардчилал бага хөгжсөн оронд түлхүү хэрэгждэг болохыг олж тогтоосон. Эдгээр кейсийг Монголын нөхцөл байдалтай уялдуулан хамгийн тохиромжтойгоос нь бага тохиромжтой гэсэн дарааллаар танилцууллаа.

1.2.1. Хятадын “хукоу” систем

1958 онд Хятад улсын засгийн газар нь “хукоу” гэх өрхийн бүртгэлийн системийг үндэсний хэмжээнд нэвтрүүлсэн ба энэ нь хот, орон нутагт оршин суух статус, хууль ёсны хаяг, үйл ажиллагаа явуулдаг салбар, шашин болон биеийн тодорхойлолт зэргийг багтаасан, иргэд, хүн амын үндсэн мэдээллийг бүртгэдэг систем юм. Өрхийн бүртгэлийг хийхээс гадна энэхүү систем нь засгийн газраас хүн амын суурьшил болон орон нутгаас хот руу шилжих хөдөлгөөнийг хянахад чухал үүрэг гүйцэтгэдэг (Juneja, 2017). Хотод хукоу буюу бүртгэл хийлгэх нь маш хэцүү бөгөөд ялангуяа, Бээжин, Шанхай, Гуанжоу зэрэг томоохон хотуудад маш их бэрхшээлтэй байдаг. (Fu, 2018) Учир нь хөдөөгөөс хот руу шилжин суурьшиж буй иргэд нь өргөдлийн хураамж төлөхөөс гадна өндөр орлоготой

байх, бизнесийн ур чадвартай байх, гадаадад боловсрол эзэмшсэн байх, төрөл садан нь хотын “хукоу”-тай байх зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг хангах хэрэгтэй болдог. Албан ёсны “хукоу”-тай биш бол хөдөө орон нутгийн шилжигчид нь хотод ажил эрхлэх, боловсрол, хүнс, эмнэлгийн үйлчилгээ болон бусад нийгмийн үйлчилгээг хүртэх боломжгүй байдаг. (Chan ба Buckingham, 2008) Хот руу шилжих хөдөлгөөнийг хязгаарласнаараа систем нь бүртгэлгүй, бичиг баримтгүй шилжилт хөдөлгөөн үүсэхэд нөлөөлж иргэдээ суурь үйлчилгээ авах боломжийг нь хязгаарлаж, эмзэг нөхцөл байдалд оруулдаг байна. (Girard, 2019) “Хукоу” системийг хөдөө орон нутгийн иргэдэд давуу нөхцөл хүртэх, хотын оршин суугчидтай адил эрх эдлэхэд ялгаварлан гадуурхаж, цаашлаад соёл болон хандлагын хувьд нийгмийн зааг ялгааг үүсгэж байна гэж дотооддоо болон олон улсын тавцанд шүүмжилдэг байна. Энэхүү бодлого нь ажиллах хүчний чөлөөт хөдөлгөөнийг хязгаарладаг учраас нийгмийг тэгш бус байдалд нөлөөлөхөөс гадна ажиллах хүчний нөөц хязгаарлагдах, хэрэглээ буурах, хот дотор тогтворгүй, зүй бус эдийн засаг үүсэх зэрэг эдийн засгийн сөрөг үр дагавартай болохыг судалгаагаар харуулсан байна. (Sheehan, 2017) 2015 онд 261 сая ажиллах хүч орон нутгаас хот руу шилжин суурьшсан байдаг бөгөөд ихэвчлэн тэднийг хоёрдугаар зэргийн иргэд мэтээр үзсэнээр тэд авах ёстой цалингаа бүрэн авч чаддаггүй гэж дүгнэсэн байна. (ECOSOC, 2005) Энэхүү сөрөг үр нөлөөг ойлгосны үндсэн дээр Хятад улсын засгийн газар нь 2014-2020 онд орон нутгаас хот руу шилжин суурьшиж буй 100 сая иргэдэд хотын оршин суух “хукоу” зөвшөөрөл олгохоор болсон бөгөөд 3 саяас доош хүн амтай жижиг хотуудад энэхүү хязгаарлалтыг тавихаа больсон байна. 2020 оны 6 дугаар сарын байдлаар Хятад улс нь тодорхой ахиц гарсныг зарлаж 8 сая шилжигчид хотын “хукоу” авсан байна. (Fang, 2020)

Хятадын хөдөө нутгаас хот руу нүүж буй шилжилт хөдөлгөөн нь өндөр орлоготой болох, ажилтай болох, илүү сайн төрийн үйлчилгээ авах, хотын орчинд амьдрах зэрэг нийгэм, эдийн засгийн шалтгаантай тул Хятадын “хукоу” системийг Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлоготой харьцуулах боломжтой байгаа юм. (Lu ба Xia, 2016) Хятад, Монгол хоёр улс нь хөдөө орон нутгаас шилжин суурьшигчдад хориг саад тавих, хотын оршин суух эрх авахын тулд тодорхой шаардлагыг заавал хангах зэрэг шалгуур үзүүлэлтүүдээрээ адил төстэй байгаа юм (тухайлбал үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эрүүл мэндийн зайлшгүй үйлчилгээнд хамрагдах, төрийн албанд томилогдох зэрэг).

“Хукоу” системийг хэрэгжүүлсэн кейсээс харвал ялгаварлан гадуурхах бодлогод үндэслэн хүн амын өсөлтийг шууд хязгаарлах нь нийгэм, эдийн засгийн олон асуудлуудыг бий болгож, дотоодын шилжин суурьшигчдыг эмзэг байдалд оруулах замаар далд шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлдэг байна. Тийм ч учраас Азийн Хөгжлийн Банкны шилжилт хөдөлгөөний мэргэжилтний зөвлөснөөр бодлого боловсруулж буй хүмүүс нь илүү зах зээлд чиглэсэн бодлого хэрэгжүүлж төрийн хязгаарлалтаас үүдсэн шилжилт хөдөлгөөний нийгэм, эдийн засгийн зардлыг бууруулах талаар илүү анхаарах ёстой. (Lu ба Xia, 2016)

1.2.2. Нигери улсын нээлтэй бэлчээрийн хориг

Нигерийн дунд бүсэд 2018 онд болсон фермерүүд болон малчдын дунд газар ашиглах талаарх зөрчил нь 300,000 гаруй хүнийг орон гэрээсээ дайжихад хүргэж яс үндэс, газар зүйн байршил болон шашны хэт туйлшралыг бий болоход нөлөөлсөн. (Олон улсын Хямралын асуудал хариуцсан бүлэг, 2018) Энэ хоёр бүлгийн хооронд зөрчил үүсэхэд нөлөөлсөн гол хүчин зүйл нь: (а) цаг уурын нөхцөл байдалтай холбоотойгоор малын бэлчээр доройтсон байдал, (б) малаа чөлөөтэй бэлчээх уламжлалт мал маллагааны арга барилыг хориглосон хууль



гарсан явдал юм. Ган, цөлжилт зэрэг цаг уурын өөрчлөлтийн асуудлууд нь малчдыг өөр бэлчээр, усны эх үүсвэр хайж нүүдэллэхэд хүргэсэн юм. Мөн засгийн газрын зүгээс гаргасан нэг бүлгийг нөгөөгөөс нь илүүд үзэж, ялгаварлан гадуурхах бодлогод бухимдсан малчдын зүгээс хүч түрэмгийлсэн үйлдэл гаргах том түлхэц өгсөн юм. Малаа чөлөөтэй бэлчээрлүүлэхэд хориг тавьснаас болж малчдын үндсэн амьжиргаа нь асуудалд орсон байна. Ган, зуд, цөлжилт (Kwong, 2019a) зэрэг цаг уурын өөрчлөлтөөс болж малаа алдсан малчид нийслэл хотод ирж, ажиллаж амьдрах орчноо сайжруулах боломжийг хязгаарласан нь Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалттай төстэй байгаа юм.

Нигерийн засгийн газрын хориг нь нийгэмд малчин, шилжигч нарын дунд хуваагдал үүсгэж байгаатай адил (McDonnell, 2017), Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь хотын иргэдийг илүүд үзэж хот хөдөөгийн ялгаа зааг гарахад нөлөөлж, хөдөөгөөс хот руу ирж буй шилжин суурьшигчдын эсрэг сөрөг хандлага үүсэхэд нөлөөлж байгааг ЗБХ дээрх ярианаас харж болно. Нигери улсад тавигдсан хориг нь малчдад нутагтаа үлдээд эдийн засгийн бэрхшээлтэй нүүр тулж хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй нүүр тулах, эсвэл өөрсдийг нь хүлээн авах сонирхолгүй газар руу тодорхойгүй ирээдүйн төлөө зугтах гэсэн сонголтыг л өгч байгаа юм. Нигерийн тус хориг нь Гадаад харилцааны зөвлөл зэрэг олон улсын оролцогч талуудаас ихээхэн шүүмжлэл хүлээсэн бөгөөд улс доторх зарим муж нь энэхүү хоригийн хэрэгжилтийг царцаагаад байгаа юм. Бодлогын мэргэжилтнүүд нь малчдыг аажимдаа фермер болоход нь туслах, малчдад зориулсан боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг ялгаварлан гадуурхаагүй үйл ажиллагаа явуулахыг зөвлөсөн байна. (Egunyomi, 2018) Энэ нь дотоодын шилжилт хөдөлгөөнийг зохицуулахад ямар нэгэн хязгаарласан бодлого хэрэгжүүлэх нь шийдэл болж чадахгүй гэсэн томоохон сургамжийг Монгол улсад өгч байна.

1.2.3. Мьянмарын Рохингя кейс

Рохингя нь Мьянмарын баруун хэсгээр байрлах Рахины мужид байрладаг Исламын шашинтай үндэстний цөөнх юм. Энэхүү кейс нь шашин, үндэс угсаа, төрсөн газраас нь хамааран шилжилт хөдөлгөөнд хориг тавьсан хэт туйлширсан кейс юм. Мьянмарын засгийн газар нь эдгээр хүмүүст иргэншил олгохгүй, хууль бус цагаачид гэж үзэн улс орноор зорчих хөдөлгөөн, гол үйлчилгээг хүртэх боломжийг нь хязгаарласан юм. (BBC Мэдээ, 2020) Монголын кейстэй яг ижил биш ч энэхүү хоёр кейсийн хувьд нэг ижил зүйл байгаа нь хэсэг бүлэг хүмүүсийг буруутгах соёлыг бий болгож, түүнээс нь үүдэн ялгаварлан гадуурхал бий болж байгааг харуулсан. Рохингя хүмүүс нь орон нутагт үймээн самуун үүсгэж улсын аюулгүй, даг тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байгаа гэж буруутгагддаг бөгөөд энэ нь Мьянмарын засгийн газраас тэдгээр хүмүүсийн хөдөлгөөнийг хязгаарлах үндэслэл болно гэж үздэг байна. (Albert ба Maizland, 2020) Яг үүнтэй адилаар Монголд хөдөө орон нутгаас шилжин суурьшиж буй иргэд нь хотын оршин суугчдын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх алдагдахад нөлөөлж байгаль экологийн тэнцвэргүй байдал үүсэхэд гол нөлөө үзүүлж байна гэж Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас гаргасан албан ёсны мэдэгдэлд дурдсан байдаг (Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, 2017б). Тийм ч учраас хотын бохирдлыг бууруулах хүрээнд шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлогыг бий болгосон. Сүүлийн хэдэн жилийн хугацаанд олон улсын хүмүүнлэгийн байгууллага, хүний эрхийг дэмжигч нар болон бусад улс орон Мьянмарын засгийн газрыг Рохингя хүмүүсийг хамгаалах үйл ажиллагаа явуулах талаар шахаж шаардаж байгаа юм. Гадаад харилцааны зөвлөлөөс буруутгах соёл болон Рохингя хүмүүсийн эсрэг төвлөрсөн ялгаварлан гадуурхлыг арилгах нь нөхцөл байдлыг сайжруулах гол түлхүүр бөгөөд энэхүү зарчим нь Монголын кейсэд ч адил үйлчлэх юм. (Albert ба Maizland, 2020)

Олон улсын гурван кейс нь Монголд анхаарах ёстой хэд хэдэн зүйлийг харуулж байна. Үүнд:

- (а) Шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь эмзэг байдлыг бий болгох, нийгмийг хуваах, хүчирхийллийн эрсдэлийг бий болгох зэрэг нийгэм эдийн засгийн асуудлыг үүсгэдэг.
- (б) Эдгээр ялгаварлан гадуурхах бодлогыг ардчилсан, чөлөөт зах зээл бүхий улс орнуудад нийтлэг хэрэглэдэггүй (Монгол улс нь ардчилсан, чөлөөт зах зээлтэй улс) бөгөөд дэлхийн тавцанд хүний эрхийн бүлэг, олон талт байгууллага, засгийн газраас маш хүчтэй шүүмжлэлд өртдөг.
- (в) Шилжилт хөдөлгөөний хязгаарлалтаас үл хамааран албан бус буюу бүртгэлгүй шилжилт хөдөлгөөний урсгал хэвээр байгаа бөгөөд энэ нь тус ангилалд багтах шилжин суурьшигчдын эмзэг байдлыг нэмэгдүүлж буй хүчин зүйл болж байна.



2. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ




2.1. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Энэхүү судалгааны гол зорилго нь дотоодын шилжилт хөдөлгөөн (нэн ялангуяа хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн) болон шилжин суурьшигчдын эмзэг байдалд Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын бодлогын нөлөөллийг үнэлэхэд оршиж байна. Ингэхдээ судалгааны баг нь 2017-2020 онд гарсан шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр дүнгээс одоо байгаа шилжилт хөдөлгөөний дүр зургийг гаргах “Өөрчлөлтийн онол”-д суурилан дараах судалгааны гол асуултуудыг тодорхойлсон юм.

Монгол улсын дотоодын шилжилт хөдөлгөөний талаарх хийгдсэн өмнөх судалгаагаар (ОУШХБ, 2018б) эдийн засгийн хүчин зүйл нь Улаанбаатар хот руу шилжин суурьших гол үндэслэл болж байна гэж дүгнэсэн. Эдийн засгийн хүчин зүйлс гэдэгт ажлын олдоц, сайн цалин хөлс, хотод бизнес эрхлэх сайн нөхцөл байдал зэрэг багтсан байна. Зураг 3-ын баруун дээд хэсэгт харуулсанчлан, хэрэв шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын бодлогын хэрэгжилт үр дүнтэй байвал, хөдөө орон нутгийн иргэд төрөлх нутагтаа үлдэж хот суурин газарт чиглэсэн шилжилт хөдөлгөөн буурна (ялангуяа Улаанбаатар хот) гэж үзсэн.

Зураг 3.

2017-2020 оны шилжилт хөдөлгөөний хязгаарлалтаас үүдэн гаргах Өөрчлөлтийн Онол



Нөгөө талаар, Зураг 3-ын доод хэсэгт үзүүлсэнчлэн, хэрэв өрхүүд албан бус байдлаар шилжилт хөдөлгөөн хийсээр байвал шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлого нь бодит зорилгодоо хүрч чадахгүй байх, цаашлаад Улаанбаатар хотын хүн амын тоо болон оршин суугчдын сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм. Тиймээс шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлогын хэрэгжилт, үр нөлөөг судлахын тулд дараах дөрвөн үндсэн асуултыг тодорхойлсон болно:

- (а) Шилжих хөдөлгөөнийг хязгаарлах бодлого хэрэгжүүлсэн хугацаанд (2017-2020) Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний урсгал буурсан уу?
- (б) Шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах хугацаанд Улаанбаатар хот руу шилжин суурьшсан дотоодын шилжин суурьшигчдын эмзэг байдал нэмэгдсэн үү?
- (в) Шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь Улаанбаатар хотын амьдрах орчныг сайжруулах үндсэн зорилгодоо хүрч чадсан уу?
- (г) Шилжилт хөдөлгөөний урсгалыг илүү үр дүнтэй зохицуулахад болон Улаанбаатар хот дахь шилжин суурьшигчдын эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн бодлогын ямар хувилбаруудыг хэрэгжүүлэх боломжтой вэ?

Судалгааны зорилгын хүрээнд тоон болон чанарын судалгааг зохион байгуулсан:

- (а) **Тоон судалгаа:** Эмзэг байдал болон сайн сайхан байдлыг үнэлэх, цаашлаад шилжилт хөдөлгөөний хориг нь тэдэнд хэрхэн нөлөөлсөн талаар үнэлгээ хийхийн тулд шилжигч болон шилжигч бус өрхүүдээс судалгаа авсан. Мөн хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний хэв маягийг тооцоолох үүднээс хоёрдогч тоон мэдээлэл, өгөгдлүүдэд дүн шинжилгээ хийсэн.
- (в) **Чанарын судалгаа:** Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний өнөөгийн байдал, иргэдийн амьжиргааны нөхцөл байдлын талаар илүү нарийвчилсан мэдээлэл цуглуулахын тулд ЗБХ хийх замаар зорилтот бүсэд амьдарч байгаа шилжигч болон шилжигч бус өрхүүдээс ярилцлага авсан. Шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөөний талаар үзэл бодол, нотолгоо цуглуулах, бодлогын өөрчлөлтийг илүү үр дүнтэй болгох үүднээс гол мэдээлэгчийн ярилцлагыг төрийн албан хаагчдаас авсан болно.

2.2. СУДАЛГААНЫ ЗАГВАР БОЛОН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

Энэхүү судалгааны хүрээнд тоон болон чанарын судалгааны аргыг ашиглан Улаанбаатар хотод байгаа өрх (шилжигч болон шилжигч бус)-д төвлөрөн мэдээлэл цуглуулсан. Судалгааг тоон болон чанарын аргыг хослуулан хийснээрээ Улаанбаатар хотын оршин суугчдад тулгарч буй бэрхшээлд дүн шинжилгээ хийж олон талт үзэл бодлыг тусгах боломж бүрдсэн юм. Үндсэн судалгааны хүрээнд дараах дүн шинжилгээг хийсэн. Үүнд:

- (а) Захиргааны болон үндэсний хэмжээний нэмэлт судалгааны тоо баримтыг ашиглан хоёрдогч статистик тоо баримтад дүн шинжилгээ хийснээр шилжилт хөдөлгөөний хязгаарлалт хийсэн хугацаанд хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний урсгалыг тооцоолов.
- (б) Улаанбаатар хотод амьдарч буй шилжигч болон шилжигч бус өрхийн эмзэг байдлыг үнэлсэн. Ингэхдээ эмзэг байдлын гол үзүүлэлт, бүрэлдэхүүн хэсгийг олж тогтоох зорилгоор баримт бичгийн шинжилгээ хийсэн.

Шилжигч өрхийн эмзэг байдлын үзүүлэлтийг өөр өөр цаг хугацаанд авч үзэхийн зэрэгцээ шилжигч бус өрхийн эмзэг байдалтай харьцуулж шинжлэв.

- (в) Нийгмийн суурь үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагын ажилтнуудтай ганцаарчилсан ярилцлага хийх болон хоёрдогч мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар Улаанбаатар хотын амьдрах орчинд гарсан өөрчлөлтийг дүгнэв.
- (г) Агуулгыг цогцоор ойлгохын тулд одоо байгаа нөхцөл байдал болон шилжилт хөдөлгөөнийг зохицуулах эрх зүйн болон бодлогын хүрээнд мөн шинжилгээ хийв.

Судалгааны хүрээний талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-ээс харна уу.

2.3. ТООН БОЛОН ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ, ТҮҮВРИЙН БҮРДЭЛ

2.3.1. Өрхийн судалгааны түүврийн хэмжээ, бүрдэл

Өрхийн судалгааны мэдээллийг 2020 оны 6 дугаар сарын 12-ноос 8 дугаар сарын 2-ныг дуустал Улаанбаатар хотын төвийн зургаан дүүргээс цуглуулсан. Мэдээлэл цуглуулах зорилтот бүсийг сонгохдоо хүн амын нягтаршил, өрхийн тоо, 2014-өөс 2020 онуудад шилжин суурьшсан болон шилжигч бус иргэдийн тоо, газар зүйн байршил болон хэмжээ зэрэг хэд хэдэн чухал хүчин зүйлийг харгалзаж үзсэн. Түүнээс нийт 40 хороог сонгож авав (Зураг 4). Зорилтот хороо болгоноос сонгох түүврийн хэмжээг үечилсэн түүврийн аргачлалаар сонгосон бөгөөд судалгааны түүврийн хэмжээг хэрхэн тооцоолсон талаарх мэдээлэл, хороо тус бүрийн түүврийн хэмжээг Хавсралт 2-т харуулсан болно.

Зураг 4. Мэдээлэл цуглуулсан зорилтот дүүрэг, хороод



Эх сурвалж:

Энэхүү инфографикийг ХБСХ-ийн судалгааны баг боловсруулав.


Зураг 5-д үзүүлсэнчлэн нийт 2505 өрхийг тоон судалгаанд хамруулсан. Үүнээс 943 нь нийслэл хотод албан ёсны бүртгэлтэй иргэд байв⁵. Судалгааны гол зорилго нь шилжигч болон шилжигч бус иргэдийн эмзэг байдлыг харьцуулж, хоёр бүлгийн амьжиргаанд тулгарч буй асуудлыг олж тогтоох байв. Судалгаанд хамрагдсан нийт 1562 шилжигч өрхийн (судалгаа авч буй хугацаанаас 6 жилийн дотор хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу шилжин суурьшсан) 1022 нь бүртгэлтэй

⁵ Сүүлийн зургаан жилийн хугацаанд хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнд оролцоогүй болон судалгаа хийгдсэн газарт оршин суух албан ёсны зөвшөөрөлтэй өрхийг хэлнэ. Шилжигч бус өрхүүд гэдэг нь огт шилжин суурьшиж байгаагүй гэсэн үг биш бөгөөд харин шилжин суурьшаад удсан, Улаанбаатар хотод тодорхой цаг хугацааг өнгөрүүлсэн хүмүүсийг хэлнэ.



(өөрөөр хэлбэл албан ёсоор бүртгүүлж байнгын оршин суух зөвшөөрөл авсан), бусад 540 нь бүртгэлгүй байв.

Зураг 5 Судалгааны түүврийн бүрэлдэхүүн



Эх сурвалж: Энэхүү инфографикийг ХБСХ-ийн судалгааны баг боловсруулав.

Шилжин суурьшсан өрхийн амьдралд шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь хэрхэн нөлөөлснийг харахын тулд хоёр төрлийн шилжигч өрхийг судалгаанд хамруулсан. Эхний бүлэгт шилжилт хөдөлгөөний хязгаарлалт тавигдахаас өмнөх гурван жилд (2014-2016) Улаанбаатар хот руу шилжин суурьшсан, хоёр дахь бүлэгт шилжилт хөдөлгөөн хязгаарласан хугацаанд (2017-2020) Улаанбаатар хот руу шилжиж ирсэн өрхийг багтаасан болно.

Бүлгүүдийн хооронд хийх харьцуулалтуудыг аль болох бодитой байлгах үүднээс нэг хороо болон нэг газарт амьдардаг шилжигч болон шилжигч бус өрхүүдээс ярилцлага авсан. Байршлын хувьд судалгаанд хамрагдсан нийт 2505 өрхийн 56.4 хувь нь орон сууцанд, үлдсэн 44.6 хувь нь гэр хороололд⁶ амьдардаг байв.

Судалгааны түүврийн төлөөлөх чадварыг дараах хэсэгт нэгтгэн дүгнэсэн болно.

Хүснэгт 3 Судалгааны бүлгийн түүврийн хэмжээ

Судалгааны бүлэг	Албан ёсны бүртгэлтэй эсэх	Улаанбаатарт нийт шилжиж суурьшсан иргэд	Түүврийн хэмжээ
Шилжигч бус өрхүүд	Бүртгэлтэй	н.а. ^a	943
Хоригоос өмнө шилжин суурьшсан иргэд (2014-2016)	Бүртгэлтэй	29 862 ^b	486
	Бүртгэлгүй	н.а. ^c	536
Хоригоос хойш шилжин суурьшсан иргэд (2017-2020)	Бүртгэлтэй	16 903 ^d	130
		н.а. ^c	407
Нийт		46 765	2 505

Тэмдэглэл: ¹ Тоо мэдээлэл хангалтгүй

² 2007-2016 хооронд Улаанбаатар хот руу шилжин суурьшсан дотоодын шилжин суурьшигчдын тоо (ҮСХ-ны статистик тоо баримт)

³ Тоо мэдээлэл хангалтгүй

⁴ 2017-2019 онуудад Улаанбаатар хот руу шилжин суурьшсан иргэдийн тоо (ҮСХ-ны статистик тоо баримтууд)

⁵ Тоо мэдээлэл хангалтгүй

⁶ Гэр гэдэг нь Монголын угсаатны уламжлалт сууц юм. Гэр хороолол гэдэг эсгий гэрээс бүрдсэн хүн оршин суух хороолол бөгөөд ихэвчлэн модон хашаагаар хоорондоо тусгаарлагдсан байдаг.

Тоон судалгааны түүврийн хэмжээг дараах томъёогоор гаргасан:

$$n = \frac{z^2 \cdot p \cdot (1-p)}{c^2}$$

Үүнд,

- z = z хэмжээ (95 хувийн итгэлцэх түвшинд 1.74 г.м)
- p = сонголт хийх хувь (түүврийн хэмжээнд 0.5 хувь ашигласан)
- c = итгэлцлийн интервал, алдаа гарах хамгийн дээд зөрүү (бид дүгнэлтийн үнэн зөв байдлыг хангахын тулд 1.9 хувийн бага интервал сонгосон)

Судалгааны түүврийн хэмжээ ~ 2505, харьцуулсан хоёр бүлгээс 1562 болон 943 өрхийг түүвэрлэсэн нь төлөөлөх чадвартайг илэрхийлж байна.

2.3.2. Чанарын судалгааны бүрдэл

Чанарын судалгааны гол зорилго нь илүү гүнзгийрүүлсэн, тодорхой тайлбар бүхий мэдээлэл, шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлогын талаар олон талт санаа, үзэл баримтлал, нотолгоог цуглуулахад оршино. Тийм ч учраас бид нийт 15 орон нутгийн хэмжээнд төрийн үйлчилгээ үзүүлдэг албан хаагч нарыг судалгаанд хамруулсан (Зураг 6). Үүнд:

- (а) Цагдаа;
- (б) Өрхийн эмнэлгийн эмч;
- (в) Нийгмийн халамжийн ажилтан;
- (г) Улсын бүртгэгч;
- (д) Сүхбаатар, Хан-Уул болон Баянзүрх дүүргийн гурван хороонд байрлах ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер.

Түүнчлэн ЗБХ-т 32 хүн оролцож шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын талаар өөрсдийн үзэл бодлыг хуваалцсан.

Зураг 6. Чанарын судалгааны бүрэлдэхүүн



шилжигч бус
өрх
шилжигч
өрх

Зорилтот бүлгийн ярилцлага

32 шилжигч ба
шилжигч бус



нийгмийн
суурь
үйлчилгээ
үзүүлэгчид

Ганцаарчилсан ярилцлага

15 албан хаагчид

Эх сурвалж:

Энэхүү инфографикийг ХБСХ-ийн судалгааны баг боловсруулав.

Байршил болон амьдарч буй орчноос улбаалан ялгаа үүсэж буй эсэхийг харахын тулд бид дараах газруудын төрийн албан хаагчдаас ярилцлага авсан:

- (а) Хотын төвийн зөвхөн орон сууц бүхий хороод
- (б) Хотын захын зөвхөн гэр хороололос бүрдэх хороод
- (с) Орон сууц, гэр хороолол хосолсон хороод



3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН



3.1. ХӨДӨӨГӨӨС ХОТ РУУ ЧИГЛЭСЭН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ УРСГАЛД ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ХЯЗГААРЛАЛТЫН ҮЗҮҮЛЖ БУЙ ҮР НӨЛӨӨ

Хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний урсгалд шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь ямар нөлөөтэй байсан талаар судалгааны эхний асуултад хариулахын тулд дараах хоёр дүн шинжилгээг хийсэн. Үүнд:


- (а) Улаанбаатар хотын бүртгэлтэй болон бүртгэлгүй шилжигчдийн тоог тооцоолох;
- (б) Эдийн засгийн өсөлт, малын хорогдол зэрэг бусад нийгэм эдийн засгийн нөлөөллийг салгаж бодлогын бодит үр дүнг үнэлэх.

3.1.1. Нийслэл хот дахь шилжигчдийн тооцоолол

Бүртгэлтэй болон бүртгэлгүйгээр хотод шинээр шилжин ирэгсдийн тоог тооцоолохдоо олон улсын практикт суурилсан шууд болон шууд бус арга барилыг ихэвчлэн хэрэглэдэг. Шууд арга барилаар жил тутам хийгддэг судалгаа болон хүн амын тооллого зэрэг захиргааны тоон мэдээлэлд суурилан шинээр ирж буй шилжин ирэгсдийн тоог гаргадаг. Харин эсрэгээрээ шууд бус арга барил нь цагдаа болон эмнэлгийн бүртгэлийн мэдээ зэрэг хоёрдогч эх үүсвэрийг ашиглахыг хэлнэ.

Албан ёсны статистик мэдээллийн дагуу Улаанбаатар хот руу шилжин суурьшиж байгаа иргэдийн тоо 2017-2018 онд огцом буурсан бөгөөд Зураг 7-д үзүүлсэнчлэн бусад бүс нутгуудад энэ тоо нь өөрчлөгдөөгүй байна. Гэвч захиргааны тоо баримт нь Улаанбаатар хотод зөвхөн бүртгэлтэй шилжин суурьшигчдын мэдээллийг гаргаж байгаа учраас бүртгэлгүй шилжилт зэрэг шилжилт хөдөлгөөний өөрчлөлтийг тооцоолохын тулд өөр эх үүсвэрийг харах шаардлагатай.

Зураг 7. Улаанбаатар хот дахь шилжин суурьшигчдын тоо



Эх сурвалж: ҮСХ, 2020а; Ажиллах хүчний судалгааны өгөгдөл (ҮСХ, 2020г)-д суурилан боловсруулсан судлаачийн тооцоолол.



Бүртгэлтэй болон бүртгэлгүй шилжилт хөдөлгөөний урсгалын хэв маягийг ойлгохын тулд бид ҮСХ-оос хийсэн үндэсний хэмжээний том судалгаа болох 2007-2019 оны Ажиллах Хүчний Судалгааг (АХС) ашигласан. Энэхүү судалгаанд бүртгэлтэй, бүртгэлгүйгээс үл хамааран шинээр шилжин суурьшсан иргэд мөн багтсан байдаг.

АХС-ны тоо баримтад суурилан бүх шинээр шилжин суурьшсан иргэдийн тоог Улаанбаатар хотод бүртгэлтэй шинээр шилжин ирэгч иргэдийн захиргааны тоо баримттай харьцуулахад томоохон хэмжээний ялгаа харагдаж байна. Зураг 7-д үзүүлсэнчлэн, АХС тоо баримтад суурилсан шинээр шилжин суурьшиж байгаа иргэдийн тоо (цэнхэр шугамаар үзүүлсэн) болон ногоон өнгөөр харуулсан найдвартай байдлын интервал нь бүртгэлтэй шилжигчдийн тоо (улаан шугам)-ноос бага байгаа юм. Гэтэл энэ тоо нь эсрэгээрээ байх ёстой. Зураг 7-д үзүүлсэнчлэн бүртгэлтэй шилжигч иргэдийн албан ёсны тоо (улаан шугам) 2017 оныг хүртэл 25000-аас их байсан боловч 2019 оныг хүртэлх хугацаанд энэ тоо нь 6800 болж бууран 2019 онд 12300 болж өссөн байна. АХС-д үндэслэсэн Улаанбаатар хотод шинээр шилжин суурьшсан иргэдийн тооцоолол нь (цэнхэр шугам) 2017, 2018 онуудад буурч 2019 онд өссөн үзүүлэлттэй байгаа боловч өөрчлөлтийн хэмжээ нь захиргааны тоо баримттай харьцуулахад тийм ч огцом биш байна. Судалгааны бичил тоо баримтаас харахад Улаанбаатар хотын нийт хүн амд эзлэх шилжин суурьшигчдын эзлэх хувь нь 2016 онд 0.65, 2017 онд 0.49, 2018 онд 0.46 хувиар тус тус буурч, 2019 онд 0.54 хувиар өссөн байна.

Үүнээс харахад Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнийг албан ёсоор хязгаарласан нь бүртгэлтэй шилжин суурьшигчдын албан тоо багасахад нөлөөлсөн байна. Гэвч шинээр шилжин суурьшиж буй бүртгэлгүй иргэдийн талаар судалгааны болон захиргааны тоо баримт хомс байгааг харгалзан үзэх ёстой.

Юуны түрүүнд Улаанбаатар хотын албан ёсны бүртгэлтэй шилжин суурьшигчдын тоо тодорхой хэмжээнд буурсан хэдий ч АХС тоо баримтаас бага зэрэг л буурсан байгаа нь албан ёсны статистикт багтаагүй, бүртгэлгүй шилжин суурьшигчдын тоо их байж болохыг харуулж байна.

Хоёрдугаарт, АХС нь үндэсний хэмжээнд гаргасан судалгаа боловч бүртгэлгүй шилжигчид тус судалгаанд оролцоогүй байх боломжтой. Тийм ч учраас бүртгэлгүй шилжин суурьшигчдын тоог гаргахад ярвигтай байдаг. Алберт болон Вогелийн (2008) тодорхойлсны дагуу бүртгэлгүй шилжин суурьшигчид нь ажиглахад хэцүү, ажигласан ч хүн амын нэг хэсэг гэж үзэхэд хэцүү байдаг “нуугдмал хүн ам”-д багтдаг байна. Мөн тухайн хүн амын бүтэц нь тодорхойгүй байгаа учраас нийт хүн амаас төлөөллийн түүвэр гаргах боломж ч мөн хомс байдаг. Ер нь бол мөшгөх арга барил ашиглахгүй бол тухайн бүлгийн иргэдийг зөвхөн ажиглах юм уу асуулт асуугаад албан бус бүртгэлгүй шилжигч гэж тодорхойлох ярвигтай байдаг. Хууль бус үйл ажиллагаа явуулдаг бусад хүмүүсийн нэгэн адилаар бүртгэлгүй шилжигчид нь төрийн захиргааны байгууллагуудаас өөрсдийгөө нуух нь дээр гэсэн хандлагатай байдаг.

Гуравдугаарт, судалгаанд зөвхөн цөөн тооны шинээр шилжин суурьшигчдыг хамруулсан учраас судалгаанд суурилсан тооцоолол нь найдвартай статистик тоо баримт болж чадахгүй байна. Тийм ч учраас АХС тоо баримтад суурилсан шинээр шилжин суурьшигчдын тооны өөрчлөлтийн коэффициент нь өндөр байгаа юм (11–18%). Хэрвээ бид судалгааны түүвэрт шинээр шилжин суурьшиж буй өрхийн эзлэх жинг нэмэгдүүлж, энэ тоо нь (Улаанбаатар хотод сүүлийн 12 сарын хугацаанд шилжин суурьшсан иргэд) бага жинтэй байсан гэж үзвэл асуудал улам хэцүү болно. Энэ нь судалгааны тооцооллын өөрчлөлтийг ихэсгэж үндэслэлгүй гарах магадлалыг нэмэгдүүлэх эрсдэлтэй.



Дотоодын шилжин суурьшигчдын тооцооллыг илүү найдвартай тоо баримтад суурилан гаргахын тулд бид ҮСХ-оос гаргасан Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогыг ашигласан (2020б). Тооллогын тайлангийн дагуу 2019 онд Улаанбаатар хот руу бусад бүс нутгаас шилжин суурьшсан дотоодын шилжин суурьшигчдын тоо нь 55296⁷ байжээ. Гэвч дээр дурдсанчлан ҮСХ-оос гаргасан дотоодын шилжилт хөдөлгөөний жилийн тайланд тэдгээр шилжин суурьшигчдын зөвхөн 12300 (тооллогын 20 хувь) нь бүртгэл хийлгэсэн гэж мэдээлжээ. Тийм ч учраас үлдсэн 44000 шилжигч буюу 80 хувийг нь албан бусаар шилжин суурьшсан буюу бүртгэлгүй иргэд гэж үзэж болохоор байна. Харамсалтай нь үндэсний тооллого болон захиргааны тоо баримтын тооцоолсон тоог нас хүйсээр нь нарийвчлан гаргах боломжгүй байгаа юм. Учир нь үндэсний тооллогын нарийвчилсан тайлан одоогоор хэвлэгдэж гараагүй байна. Зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн үр дүн ч мөн энэхүү үр дүнтэй нийцэж байгаа юм.



Шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан бодлого хэр үр дүнтэй байгаа талаар шилжигч бус иргэдийн үзэл бодол

Хэрэв шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь үр дүнтэй байсан бол Улаанбаатар хотод амьдарч буй хүмүүсийн тоо өсөхгүй байсан. Сүүлийн жилүүдэд маш олон барилга, орон сууц, амины сууцууд баригдсан. 9-р сар болоход түрээслэх байр олно гэдэг нь бараг боломжгүй зүйлүүдийн нэг болоод байна (хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбоотой).

Шилжигч бус иргэн 1 (эмэгтэй)

Хүмүүс хот руу нүүсээр байгаа гэж бодож байна. Гэр хорооллын бүсэд хүмүүс хашаа хатган гэр барьж амьдарсаар байна. Миний амьдардаг гэр хороололд хүн амын нягтаршил ихэссээр байна.

Шилжигч бус иргэн 2 (эрэгтэй)

3 (эрэгтэй): Албан ёсны бүртгэлийн тайланд шилжигчийн тоо буурсан байгаа. Гэхдээ хориг тавьсан ч хүмүүс Улаанбаатар хот руу шилжин суурьшсаар байна.

Шилжигч бус иргэн 3 (эрэгтэй)

Тооцооллын үр дүнг сайжруулах үүднээс бид цагдаа болон эмнэлгийн бүртгэлийн тоо баримтыг ашиглах замаар шууд бус аргаар судлахаар зорьсон. Энэ төрлийн хүн ам зүйн шинжилгээний арга барил нь хүн (бүртгэлтэй, бүртгэлгүй байхаас үл хамааран) амьдралынхаа турш төрөх, нас барах, эмнэлэгт хэвтэх зэрэг ямарваа нэгэн эрсдэлд өртөх магадлал дээр үндэслэдэг. Эдгээр эрсдэлүүд дээрх тохиолдлууд маш сайн бүртгэгддэг бөгөөд тухайн хүний нас, хүйс тодорхой бүлгийн төрөлт, нас баралт болон эмнэлэгт хэвтсэн байдлыг харьцуулах бүрэн боломжтой байдаг. Тийм ч учраас иргэний бүртгэлд тусгасан бүртгэлтэй хүн ам зүйн тоо баримт нь нас хүйс болон тодорхой бүлгийг илэрхийлж болох учраас албан бус буюу бүртгэлгүй оршин суугчдын тоог хасалт хийх замаар тооцоолон гаргах боломжтой гэж үзсэн.

⁷ Хүн амын тоологод, ҮСХ "сүүлийн нэг жилийн хугацаанд шилжин суурьшсан" тоог гаргахдаа сүүлийн 12 сарын хугацаанд бусад аймгуудаас нүүж ирсэн шилжин суурьшигчдыг тодорхойлсон байна. Хүн амын тооллогыг 2020 оны 1 сард хийсэн бөгөөд энэхүү тоо нь 2019 оны тоо баримтыг ашигласан болно.



Харамсалтай нь ийм төрлийн тоо баримтын эх сурвалж нь хот, дүүргийн хэмжээнд байгаагүй. Бид хорооны түвшинд шинээр шилжин суурьшсан иргэдийн тооцооллыг гаргахын тулд хэд хэдэн хорооны эрүүл мэндийн төв, цагдаагийн газар, сургууль зэрэг үндсэн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын ажилтнуудаас ярилцлага авсан. Мөн эдгээр төрийн үйлчилгээг авсан бүртгэлтэй, бүртгэлгүй шилжигчдийн талаар асуусан. Хорооны түвшинд нарийвчилсан тоо баримт байхгүй байгаа бөгөөд ярилцлага өгсөн зарим хүмүүсийн ярианаас захын хороодын хувьд үйлчилгээ авч байгаа хүмүүсийн 30 хүртэлх хувь нь бүртгэлгүй шилжигчид байдаг талаар мэдээлсэн.

Товчхондоо шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь Улаанбаатар хот руу шилжин суурьших бүртгэлтэй иргэдийн урсгалыг бууруулсан боловч сүүлийн үеийн үндэсний тооллого, чанарын мэдээллээс харахад бүртгэлгүй шилжилт хөдөлгөөний урсгал нэмэгдсэн байх магадлал өндөр байна.

3.1.2. Бусад хүчин зүйлийн нөлөө

А.Солонго (2018)-ын хийсэн судалгаагаар, Монгол улсын дотоодын шилжилт хөдөлгөөний үндсэн түлхэх хүчин зүйлд эдийн засгийн аюулгүй байдал, нийгэм эдийн засгийн үсрэнгүй байдал, мэдээлэл, нийгмийн үйлчилгээний хүртээмж зэрэг багтдаг байна. Үүнтэй адилаар ОУШХБ (2018а)-ын судалгаагаар ажил олох болон амьдралын нөхцөлөө дээшлүүлэх зэрэг эдийн засгийн хүчин зүйл нь хүмүүсийн нүүх үндсэн хүчин зүйл болдог байна. Энэхүү дүгнэлт нь энэ удаагийн судалгааны үр дүнгээр давхар баталгаажиг байгаа юм. Ярилцлагад хамрагдсан 2505 өрхөөс дийлэнх буюу 40.8 хувь нь ажлын байрны олдоц, бизнес хийх таатай нөхцөл зэрэг эдийн засгийн үндэслэлээр шилжин суурьшсан байсан. Нөгөө талаас шилжилт хөдөлгөөнд нөлөөлсөн томоохон хүчин зүйл нь Улаанбаатар хотын амьдрах орчин нөхцөл (22.3%) болон боловсролын чанар (18.2%) тус тус байна.

Зураг 8. Шилжилт хөдөлгөөн хийх үндсэн шалтгаан




Эх сурвалж: Энэхүү инфографикийг ХБСХ-ийн судалгааны баг боловсруулав.

Хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн буурсан нь дан ганц шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлогоос шалтгаалаагүй ба өөр бусад хүчин зүйлүүд нөлөөлсөн байх боломжтой. Зураг 9-д харуулсанчлан хязгаарлах бодлого баримталж эхлэхээс өмнө Улаанбаатар хот руу шилжин суурьших бүртгэлтэй шилжигчдийн тоо буурч эхэлсэн байна. Сүүлийн жилүүдэд

буурч байгаа явдал нь 2012-2017 онд эдийн засгийн хөгжил саарсантай холбоотой байж болно. Сүүлийн хорин жилийн тоо баримтаас харахад эдийн засгийн өсөлт болон шинээр Улаанбаатар хотод шилжин суурьшиж буй хүмүүсийн харилцан хамаарлын коэффициент 0.28 байгаа юм. Эдийн засгийн өсөлт муу байх үед Улаанбаатар хот руу шилжих хөдөлгөөн нь буурч байгаа бөгөөд энэ нь 2016-2017 оны байдлаас харагдаж байна. Гэвч эдийн засаг 2017-2018 онд өссөн ч гэсэн шинээр шилжин суурьшиж буй бүртгэлтэй иргэдийн тоо өмнө жилүүдийнхтэй харьцуулахад бага түвшинд хэвээр байсан. Эндээс харахад шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлого нь наанадаж богино хугацаанд бүртгэлтэй шилжин ирэгсдийн тоог бууруулсан байж болохыг харуулж байна.

Зураг 9. Улаанбаатар хотод хөдөө орон нутгаас шилжин суурьшсан иргэдийн тоо



Эх сурвалж: ҮСХ, 2020а, 2020в

ОУШХБ-ын (20186) судалгаанаас харахад хөдөөгөөс хот руу чиглэх шилжилт хөдөлгөөнд хөдөө орон нутагт нийгэм эдийн засгийн боломж бага байх, ган зуд зэрэг байгалийн гамшиг нэмэгдсэн байдал холбоотой байж болно. Зураг 9-д үзүүлсэнчлэн, Улаанбаатар хотод шинээр шилжин суурьшигчдын тоо нь 2000-2001 болон 2010 онуудад мал их хэмжээгээр хорогдсонтой холбоотойгоор огцом өссөн байна. Мөн түүнчлэн сүүлийн хорин жилийн хугацаанд шинээр шилжин суурьшиж буй иргэд болон малын хорогдлын харилцан хамаарал нь сул (0.11) хэдий ч, эерэг болон тэгээс их байгаа нь тодорхой хэмжээнд нөлөөлөл байгааг харуулж байна. Энэ нь байгалийн гамшиг бага байсан жилүүдэд Улаанбаатар хот руу шилжин суурьших иргэдийн тоо цөөрснийг харуулж байна. Ер нь сүүлийн 10 жилд цаг агаарын нөхцөл байдал харьцангуй сайн байсан учраас шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлого хэрэгжихээс өмнө шилжилт хөдөлгөөн буурсан явдлыг дээрх нөхцөл байдалтай холбож болно.

Шилжилт хөдөлгөөний хоригийн хэрэгжилтийн үе дэх шилжилт хөдөлгөөний урсгалын хэв маягтай холбоотой тоон мэдээлэл болон холбогдох дүн шинжилгээнүүдээс дараах дүгнэлтийг гаргаж байна:

- (а) Шилжилт хөдөлгөөний түр хязгаарлалт нь 2017-2020 оны хооронд Улаанбаатар хотод ирсэн бүртгэлтэй шилжигчдийн тоог тодорхой хэмжээнд бууруулсан. Гэвч энэ хугацаанд улс орны хувьд онцлог байсан эдийн засгийн хөгжил зэрэг хот руу татах хүчин зүйл нь хэвээр байсан учраас бүртгэлгүй шилжигчдийн тоо өссөн байх магадлалтай.



- (б) Бүртгэлгүй шилжигчдийн тоо нь албан ёсны захиргааны бүртгэлд тусгагдаагүй байгаа ч сүүлд хийсэн хүн амын судалгаа, захиргааны болон чанарын судалгааны мэдээлэлтэй харьцуулахад өндөр байсан байх магадлалтай.
- (в) АХС зэрэг үндэсний хэмжээнд төлөөлөх чадвар бүхий судалгааны тоо баримт нь бүртгэлтэй, бүртгэлгүй шилжигчдийн тоог бодитоор гаргахад хангалттай, найдвартай эх сурвалж болж чадахгүй байна.
- (г) Эдийн засгийн өсөлт буурсан, малын хорогдлын түвшин буурсан зэрэг бусад хүчин зүйлээс хамааран шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах бодлогоос үл хамааран бүртгэлтэй шилжигчдийн тоо буурсан байх магадлалтай.

3.2. ДОТООДЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ХОРИГ НЬ ШИЛЖИН СУУРЬШИГЧДЫН ЭМЗЭГ БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ БАЙДАЛ

Энэхүү хэсэгт бид шилжилт хөдөлгөөний хориг нь хөдөөгөөс хот руу шилжин суурьшсан иргэдийн эмзэг байдалд хэрхэн нөлөөлж байгааг шинжилсэн юм. Юун түүрүүнд өрхийн эмзэг байдлыг тооцоолох арга зүйд суурилсан олон талт эмзэг байдлын индекс (ОТЭБИ)-г нийт 2505 шилжигч болон шилжигч бус иргэдийн дунд хийсэн өрхийн судалгааны тоо баримтад үндэслэн тооцоолсон. Түүний дараа бид олон талт урвуу хамаарлын дүн шинжилгээгээр дамжуулан ОТЭБИ-д нөлөөлж буй гол хүчин зүйлүүдийг тодорхойлж холбогдох дүгнэлтүүдийг гаргав.

3.2.1. Дотоодын шилжин суурьшигчдын эмзэг байдлын тодорхойлолт

Эмзэг байдлыг тодорхойлох судалгааны олон арга барилууд байдаг бөгөөд тэдгээр нь нэр томъёоноос гадна хэмжих арга барилуудын хувьд харилцан адилгүй байдаг. Бид ОУШХБ-ын хийсэн өмнөх судалгааны ажлууд болон бусад адил төстэй судалгаануудад суурилан эмзэг байдлыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойллоо.

ОУШХБ-ын гаргасан Хүчирхийлэл, мөлжлөг, дарамтад өртөх эрсдэл бүхий шилжин суурьшигчдыг хамгаалах, туслах гарын авлага (2019)-д эмзэг байдал гэдэг ойлголтыг ямарваа нэгэн эрсдэлд өртсөний улмаас аюул учрах магадлал нь бусад хүмүүстэй харьцуулахад харьцангуй өндөр байхыг хэлнэ гэж тодорхойлсон байна. Шилжигчдийн өртөх магадлал бүхий аюул, эрсдэл нь харилцан адилгүй байх бөгөөд сэтгэл зүй, бие махбодын эсвэл орчны холбогдолтой байдаг. Эрсдэлийн хүчин зүйл нь аюулаас хамааран өөр өөр байж болох бөгөөд хоорондоо давхцаж болно. ОУШХБ-ын хувьд НҮБ-ын “Эмзэг нөхцөл байдалд байгаа шилжигчдийн хүний эрхийг хамгаалах практик удирдамж, зарчим болон зөвлөмжүүд”-ийн “Эмзэг байдалд байгаа шилжигч” хэсэгт тусгасан тодорхойлолтыг ашигласан байна. Уг тодорхойлолтод хүний эрхээ үр дүнтэй эдэлж чадахгүй байгаа хүчирхийлэл дарамтад өртөх эрсдэл бүхий хамгаалах шаардлагатай иргэд хэмээн тусгасан байдаг (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Дээд Комиссар, 2019)

Түүнчлэн Монгол улс дахь хотын оршин суугчдын эмзэг байдлын үнэлгээнд (ОУШХБ, 2018а) Гэр иргэдийн оролцоотой амьдрах орчны зураглалын төв (Ge Community Mapping Center буюу “GCMC”)-с эмзэг байдлыг “Нийгэм, эдийн засаг, байгаль орчны болон биет хүчин зүйлс, үйл явцын улмаас хувь хүн, нийгмийн бүлэг, өмч хөрөнгө, систем нь аюул гамшгийн нөлөөнд илүү эмзэг, өртөмтгий болох нөхцөл байдал” хэмээн тодорхойлжээ.

Лошмен болон Сиегель (2014) нар эмзэг байдлын үндэс суурийн талаарх судалгааны ажилдаа Сен (1981, 1999), Чамберс (1989) болон Жода (1988) зэрэг бусад судлаачдын тус бүрдээ томъёолсон ядуурал гэдэг нь зөвхөн орлогогүй

байхаас хамаагүй өргөн утга санааг агуулдаг хэмээх үзэл санааг баяжуулан ашигласан байна. Хэдийгээр ядуурал, эмзэг байдал хоёрт ижил төстэй зүйл олон байгаа ч адилхан гэсэн үг биш юм. Ядуурал нь орлого, хэрэглээ, эрүүл мэнд боловсрол зэрэг үзүүлэлтүүдийг хангах боломжгүй байхыг хэлдэг бол эмзэг байдал гэдэг нь эдгээр хүчин зүйлүүдийг хангаж чадахгүй байхтай холбоотой үүссэн тодорхой бус байдал гэж ойлгож болно. Тийм ч учраас ядуурал гэдэг нь тухайн мөч дэх статик (хөдөлгөөнт бус) нөхцөл бол харин эмзэг байдал нь ирээдүйн талаар итгэлгүй байх динамик (хөдөлгөөнт) нөхцөл юм.

Лошмен болон Сиегель (2014) нар “Дотроосоо аливаа зүйлд өөрийн гэсэн эрх мэдэлгүй байх, гаднаасаа эрсдэлд өртөх байдал нь тухайн хүнд эмзэг байдлыг бий болгож, сайн сайхан байдалд нь сөргөөр нөлөөлж байдаг” хэмээн дүгнэсэн. Дотоод хүчин зүйлүүд нь тухайн бүлэг хүн, хувь хүн болон өрх ямар нэгэн гэнэтийн цочролд ороход эрсдэлээ зохицуулах чадвар бага байж даван туулах чадвар сул байхыг хэлнэ. Гадна талын хүчин зүйлд тухайн орон нутагт болсон цочрол болон орон нутгийн иргэд, нийт нийгмийн амьжиргаанд аюул заналхийлж буй асуудал нь эрсдэл, цочрол, санаа зовоох асуудлыг үүсгэж байгааг хэлнэ.

3.2.2. Эмзэг байдлын үнэлгээний шалгуур

Улаанбаатар хот руу шилжин суурьшиж байгаа иргэдийн эмзэг байдлыг тодорхойлохдоо бид Лошмен болон Сиегель (2014) нарын хэрэглэсэн нэр томъёо, арга зүйг ашигласан билээ. Шилжигчдийн эмзэг байдлыг хэмжихдээ ядуурлыг хэмжих сүүлийн үеийн хүчин чармайлтын дагуу олон хэмжээст аргыг ашиглан, хүний аюулгүй байдал, эрх чөлөө, нийгмийн үнэт зүйл болон хүртээмж зэрэг дөрвөн үндсэн хүрээнд үүссэн хохирлыг хэмжихийг зорьсон юм⁸.

Мартин Равалион (1998) халамжийн түвшнээс хамааран тодорхой цаг хугацаа болон газарт тухайн хүнд гарч буй мөнгөн өртгөөр ядуурлын шугамыг тодорхойлно гэсэн байна. Хэрэв тэр хүн нь амьдралын хамгийн доод стандарт түвшинд хүрч чадахгүй байвал ядуу гэж тооцогдоно. Хэдий тийм ч ихэнх хүмүүс “доод хязгаар” гэдэгт юуг авч үзэх вэ гэдэгт санал нийлдэггүй учраас ядуурлын шугамыг тогтоох нь өөрөө асуудалтай байдаг. Гэсэн хэдий ч ядуурлын шугам нь ядуурлыг хянах, бодлогын шийдвэр гаргахад чухал үүрэгтэй байсаар байна.

ҮСХ болон Дэлхийн банк нь 2002 оноос эхлэн өрхийн орлого зардлын судалгаа болон амьжиргааны стандартыг хэмжих судалгаагаар дамжуулан ядуурлын үнэлгээг хийсээр ирсэн. Ядуурлын шугамыг суурь хэрэгцээний өртгөөр дамжуулан 2010 онд хийсэн өрхийн нийгэм эдийн засгийн судалгаанд үндэслэж тогтоосон юм. Ядуурлын шугамыг нэг хүний нэг өдөрт авах ёстой илчлэгийн хэмжээ 2100 ккал байхаар тооцоолж, хүнсний зүйл авах хэрэгцээний багц болон бусад хүнс биш ч гэлээ шаардлагатай бүтээгдэхүүн, үйлчилгээ авах боломжийг тооцоолон гаргасан билээ. Үндэсний ядуурлын шугам нь судалгаа хийгдэх үед үнийн өөрчлөлттэй холбогдуулан тогтмол шинэчлэгдэж байв. 2018 оны үндэсний ядуурлын шугам нь нэг хүний нэг сарын хэрэглээ 166,580 төгрөг байхаар тогтоогдсон бөгөөд энэ нь 2020 оны 12 сарын 31-ний өдрийн Монгол банкны албан ханшаар 58.40 ам.доллар орчим байна.

ҮСХ-ны ашигладаг ядуурлыг хэмжих хэмжигдэхүүн болон Лошмен болон Сиегель (2014) нарын хохирлын үндсэн дөрвөн хүрээнд үндэслэн эмзэг байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг судалгааны арга зүйн хэсэгт дурдсан байгаа. Зорилтот оролцогчдын эмзэг байдлыг түвшинг Хүснэгт 4 болон Алкир болон Фостер (2011) нарын “хосолсон хязгаарлалт (dual cutoff)”-ын арга зүйг ашиглан үнэлгээг хийсэн болно.

⁸ Бид Хүний хөгжлийн индекс, үзүүлэлт (Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр) болон ҮСХ-ны ядуурлын хэмжилтийг онцолсон болно



Хүснэгт 4. Эмзэг байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлт

Хүрээ	Хувьсагч/үзүүлэлт	Өрхийн эмзэг байдлын босго
Хүрээ 1: Эдийн засгийн сайн сайхан байдал	<ol style="list-style-type: none"> 1. Нэг хүнд ноогдох орлого болон хэрэглээ 2. Орлогын эх үүсвэрийн тоо 3. Өмчилсөн хөрөнгийн байдал 4. Газар болон малын эзэмшил 	<ol style="list-style-type: none"> 1. Ядуурлын түвшингээс доош (сарын 166580* төг) 2. Хоёроос доош орлогын эх үүсвэртэй 3. Түүврийн дунджаас доогуур 4. Газар болон мал өмчилдөггүй
Хүрээ 2: Эрүүл мэнд болон боловсрол	<ol style="list-style-type: none"> 1. Хүнсний аюулгүй байдал 2. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж 3. Өрхийн гол орлого олдог хүний боловсролын түвшин 4. Сургуулийн насны хүүхдийн хичээлийн тогтмол ирц 	<ol style="list-style-type: none"> 1. Хэдэн сард нэг удаа эсвэл түүнээс богино хугацаанд хоол хүнсний хангамжийн дутагдалд ордог байх 2. Өрхийн гишүүд эрүүл мэндийн төв, эмнэлгээр үйлчлүүлэх боломжгүй 3. Өрхийн тэргүүний боловсролын түвшин нь дунд болон түүнээс доош байх 4. 6-14 насны хүүхдүүд нь сургуульд сурдаггүй байх
Хүрээ 3: Нийгэм	<ol style="list-style-type: none"> 1. Олон нийтийн ажиллагаа дахь идэвх, оролцоо 2. Шаардлагатай тохиолдолд албан бус тусламж авах боломж (олон нийт, хүрээлэн буй орчин, нийгмийн бусад бүлгүүдээс г.м) 3. Хүрээлэн буй орчин, нийгэм, олон нийтэд үзүүлж буй итгэл 4. Хүрээлэн буй орчин, нийгэм, олон нийтийн аюулгүй байдал 	<ol style="list-style-type: none"> 1. Ямар нэгэн оролцоо байхгүй 2. Хэрэгцээтэй үед албан бус тусламжийг авах боломжгүй байх 3. Олон нийтэд итгэлцэл байхгүй байх 4. Аюулгүй байдал хангагдаагүй байх
Хүрээ 4: Суурь үйлчилгээ	<ol style="list-style-type: none"> 1. Усны эх үүсвэр 2. Ариун цэврийн байгууламжийн төрөл 3. Дулааны эх үүсвэр 4. Цахилгааны хүртээмж 	<ol style="list-style-type: none"> 1. Усны эх үүсвэрээ гол, нуур цөөрөм, горхиноос хангадаг байх 2. Жорлонгүй, жорлон нь дундын нүхэн жорлон эсвэл хувин байх 3. Түлшний гол эх үүсвэр нь мод, өвс, бургас болон аргал байх 4. Цахилгааны холболт байхгүй байх

Эх сурвалж: Лошмен болон Сиегел (2014)-ын судалгаанаас ашиглав.

Тэмдэглэл: *Энэхүү хэмжээг ҮСХ 2018 оны ядуурлын түвшний босго болгож тогтоосон.

3.2.3. Шилжин суурьшигчдын эмзэг байдлын түвшинг үнэлэх арга зүй

Судалгаанд оролцсон шилжигчдийн эмзэг байдлын түвшинг үнэлж олон талт эмзэг байдлыг хэмжихдээ бид тухайн өрхийг эмзэг гэж тооцоход хэрэглэх хувьсагч болон үзүүлэлтийн тоог тодорхойлох хязгаарлалт (cutoff)-ыг олж тогтоосон. Ингэхдээ бид Алкир болон Фостер (2011) нарын боловсруулсан “хосолсон хязгаарлалт (cutoff)-ын арга зүйг” ашигласан болно.

Судалгаандаа хосолсон хязгаарлалтын аргыг ашиглахдаа хүрээ хоорондын эмзэг байдлыг хоёр түвшинд авч үзсэн (эмзэг болон эмзэг бус). Индекс тус бүрийн бүх үзүүлэлт нь Хавсралт 4-ийн 3-7-р томьёонд тусгасанчлан хоёр оронтой байна. Лошмен болон Сиегэл нарын онолоор тухайн хүрээн дэх нэгтгэсэн болон жигнэсэн үзүүлэлт нь хязгаарлалт – k буюу 33 хувиас их байвал үзүүлэлт тус бүр нь 1 гэсэн үнэлгээг авна. Хүрээн дэх үзүүлэлт тус бүрийг тэгш жигнэж нийлбэрийг 1 хүргэх юм.

Өрх тус бүрийн ОТЭБИ-ийг гаргасны дараа бид эмзэг байдлын түвшнийг гаргахдаа Хүснэгт 5-д үзүүлсэн хосолсон хязгаарлалтыг ашигласан юм.

Хүснэгт 5. Эмзэг байдлын түвшний шалгуур үзүүлэлт

Эмзэг байдлын түвшин	Хосолсон хязгаарлалт
Эмзэг бус	$k \leq 33\%$
Эмзэг	$k > 33\%$

Олон талт эмзэг байдалд буй өрхийн хувьд бүх үзүүлэлтээс жигнэсэн дунджаар талаас илүү хувьд нь бага оноо авсан өрхүүдийг жигнэсэн дундаж үзүүлэлтээр талаас бага хувьд нь бага оноо авсан өрхүүдтэй харьцуулахад эмзэг байдлын түвшин нь илүү ноцтой байгааг илэрхийлнэ.

3.2.4. Олон талт эмзэг байдлын индексийн тооцоолол


Бид энэхүү судалгааны хүрээнд 943 шилжигч бус болон 1562 шилжигч, нийт 2505 өрхөөс судалгаа авсан бөгөөд тоон мэдээлэлд суурилан Хүснэгт 2-т тусгасан шалгуур үзүүлэлтийн дагуу ОТЭБИ-ийг тооцоолж гаргасан болно.

Шилжигч болон шилжигч бус өрхийн тэргүүн буюу гол орлого бүрдүүлэгчийн хүйсийн ялгаа 5.2 хувь байв (Зураг 10). Өрхөд гол орлогыг бүрдүүлж буй хүмүүсийн насны хувьд шилжигч өрхийн гол орлого бүрдүүлэгчид шилжигч бус өрхийнхтэй харьцуулахад харьцангуй залуу байв. Мөн шилжигч өрхийн гол орлого бүрдүүлэгчдийн 60 хувь нь, шилжигч бус өрхийн 38 хувь нь 18-35 насны иргэд байна.



Зураг 10.

Шилжигч болон шилжигч бус өрхийн тэргүүний нас, хүйсийн байдал




Зураг 11-т Улаанбаатар хот руу хөдөө орон нутгаас шилжин суурьшиж ирсний дараа 1562 шилжигч өрхүүдэд тулгарсан бэрхшээлүүдийг харуулав. Шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөөг харуулахын тулд бодлого хэрэгжихээс өмнө болон дараагийн хугацааг харьцуулж авч үзсэн. Тухайлбал, бодлого хэрэгжиж эхлэхээс өмнө (2014–2016 онд) Улаанбаатарт шилжин суурьшсан иргэдтэй харьцуулахад 2017-2020 буюу шилжилт хөдөлгөөний хязгаарлалт хэрэгжиж байх үед шилжин суурьшсан иргэд нь байр худалдан авах түрээслэх (26%) болон эрүүл мэндийн үйлчилгээ авах (12.5%) зэрэг бэрхшээлтэй илүү тулгарч байжээ.

Улаанбаатар хотод 2014-2016 онд шилжин суурьшсан иргэд 2017-2020 онд шилжиж ирсэн иргэдтэй харьцуулахад ажил олоход (29.2%) илүү бэрхшээлтэй байжээ. Үүнийг эдийн засгийн уналттай холбоотойгоор буюу 2016 онд ажилгүйдлийн түвшин буурсантай холбож тайлбарлах боломжтой.

Зураг 11.

Шилжин суурьшсаны дараа иргэдэд тулгарч буй гол бэрхшээлүүд, шилжилт хөдөлгөөний хугацаагаар




ОТЭБИ-ийн аргачлалын дагуу 0-1 хүртэлх оноогоор эмзэг байдлыг үнэлэх бөгөөд 0.67-оос бага оноо авах тохиолдолд “эмзэг” гэсэн ангилалд багтах юм. ОТЭБИ тооцсон аргачлалыг Хавсралт 4-т тусгав.

Нийт судалгаанд хамрагдсан 2505 өрхийн хувьд ОТЭБИ-ийн дундаж дүн нь 0.671 гарсан бөгөөд “эмзэг бус” гэсэн ангилалд дөнгөж багтаж байгаа юм. Гэвч энэ нь эмзэг байдлын түвшний босго оноо болох 0.67-той маш ойрхон байгааг онцлох шаардлагатай. Бүх өрхийн ОТЭБИ графикийг авч үзвэл судалгаанд хамрагдсан 2505 өрхийн 26.04 хувь нь 0.67 онооноос бага буюу эмзэг гэсэн ангилалд багтах оноог авсан байна.

Нийт шилжигч өрхийн ОТЭБИ оноо нь 0.67 байгаа бол шилжигч бус өрхийнх 0.68 байв. Вариацийн шинжилгээнээс харахад шилжигч болон шилжигч бус өрхийн хооронд ОТЭБИ-ийн хувьд статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаа байхгүй байна. Ялангуяа, ANOVA буюу вариацийн шинжилгээ, $\chi^2(1) = 1.8214$ Магадлал $> \chi^2 = 0.177$ гарсан бөгөөд таамаглал нь (өөрөөр хэлбэл шилжигч болон шилжигч бус өрхийн ОТЭБИ-ийн дундаж дүн нь тэнцүү), $\alpha = 0.05$ ач холбогдолтой түвшинд батлагдана гэж үзсэн.






Зураг 12-т шилжигч болон шилжигч бус өрхийн ОТЭБИ-ийн оноог харуулсан бөгөөд шилжигч өрхийн 27.6 хувь, шилжигч бус өрхийн 23.5 хувь нь эмзэг гэсэн ангилалд багтсан байна. Үүнээс шилжигч өрхүүд шилжигч бус өрхтэй харьцуулахад илүү эмзэг байдалд байгаа нь харагдаж байна. Бүртгэлийн статусаар нь тоо мэдээллийг задалж үзвэл албан ёсны бүртгэлтэй иргэдийн 27.8 хувь, түр оршин суух бүртгэлтэй иргэдийн 26.9 хувь, бүртгэлгүй шилжигч иргэдийн 27.7 хувь нь тус тус эмзэг гэсэн ангилалд багтсан байна. Эндээс, албан ёсны бүртгэлтэй болон бүртгэлгүй өрхийн хувьд эмзэг байдлын түвшинд бараг ялгаа байхгүй байгаа нь харагдаж байна.

Судалгаанд оролцсон хүмүүсийн эмзэг байдлыг ОТЭБИ болон түүний бүрэлдэхүүн дөрвөн индекс тус бүрээр задлан гаргасныг Зураг 13-т харуулав. Нийгмийн индекс (НИ) болон эдийн засгийн байдлын индекс (ЭЗБИ)-ийн дундаж оноо нь эрүүл мэнд, боловсролын индекс (ЭМБИ) болон суурь үйлчилгээний индекс (СҮИ)-ийн дунджаас харьцангуй бага байгаа юм.

Зураг 13.

Шилжигч болон шилжигч бус өрхийн ОТЭБИ болон түүний бүрэлдэхүүн индекс (ЭЗБИ, ЭМБИ, НИ, СҮИ)-ийн оноо




Бүх индексүүдийг хавсралтад тусгасан арга зүйн дагуу бүрэлдэхүүн үзүүлэлт бүрт хувааж индекс тус бүрийн үр нөлөөний үйлчлэх хүчийг тодорхойлсон (Зураг 14).

Үнэлгээний үр дүнгээс харахад ЭЗБИ нь ОТЭБИ-д хамгийн ихээр нөлөөлсөн байна. Шилжигч болон шилжигч бус өрхийн ЭЗБИ нь 0.67-гоос доош буюу эмзэг гэж гарсан. Нэн ялангуяа нэг хүнд ноогдох сарын орлогын хэмжээ нь шилжигч болон шилжигч бус өрхийн хувьд ядуу гэсэн ангилалд багтаж байна. Шилжигч өрх нь шилжигч бус өрхтэй харьцуулахад орлогын эх үүсвэрийн тоо, хөрөнгө өмчлөл зэрэг үзүүлэлт дээр сул индекстэй байгаа ч газар болон мал өмчлөлийн хувьд илүү сайн байна.

Зураг 14.

Шилжигч болон шилжигч бус өрхийн дундаж ЭЗБИ үзүүлэлтийн оноо



Нэг хүнд ноогдох сарын орлого нь ядуурлын шугамаас (сард 166580 төгрөг) дээш байвал 1 гэсэн үнэлгээ өгсөн бөгөөд ядуурлын шугамаас доош байвал 0 гэсэн үнэлгээ өгсөн. Нэг хүнд ноогдох сарын орлогын хэмжээг шилжигч болон шилжигч бус өрхийн хувьд харьцуулж үзсэн. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 96 хувь нь нэг хүнд ноогдох сарын орлогын хэмжээгээрээ 166580 төгрөгөөс бага орлоготой байна. Бусад үзүүлэлттэй харьцуулахад орлогын түвшин хамгийн доогуур байгаа бөгөөд энэ нь ЭЗБИ дахь эмзэг байдлын зэрэг өндөр байгаад хамгийн хүчтэй нөлөө үзүүлсэн байна.


Зураг 15-д үзүүлсэнчлэн, шилжигч бус өрхийн гишүүдийн ажил эрхлэлт шилжигч өрхтэй харьцуулахад 2.9 хувиар өндөр байгаа нь тэдний хувьд ажил олох боломж өндөр байдгийг харуулж байна.

Нийт шилжигч бус өрхийн 14.2 хувь, шилжигч өрхийн 17.3 хувь нь хөдөлмөр эрхэлдэггүй насанд хүрсэн гишүүдтэй байв. Гэвч нөгөө талаас шилжигч өрхийн



ажил эрхэлдэг гишүүдийн тоо шилжигч бус өрхтэй харьцуулахад олон байна. Шилжигч өрхийн бараг тал буюу 47.5 хувь нь хоёр болон түүнээс дээш орлого олдог гишүүнтэй бол шилжигч бус өрхийн хувьд 40.2 хувь нь хоёр болон түүнээс дээш хөдөлмөр эрхэлдэг гишүүнтэй байна.

Зураг 15. Шилжигч болон шилжигч бус өрхийн орлого олж байгаа гишүүдийн тоо




Шилжигч болон шилжигч бус өрхийн ажил эрхлэлтийн байдлын нарийвчилсан статистикийг харахад ижил хэв маяг ажиглагдсан юм. Шилжигч болон шилжигч бус өрхийн ажил эрхлэлтийн гол гурван салбарт барилга (шилжигч өрхийн 16.8% болон шилжигч бус өрхийн 14.6%), бөөний болон жижиглэнгийн худалдаа, машин засвар (13.7% болон 12.7%, тус тус), тээвэр болон агуулах үйлдвэр (шилжигч өрхийн 7.8% болон шилжигч бус өрхийн 9%)-ийн салбар орж байна.


Шилжигч болон шилжигч бус өрхийн 50-аас илүү хувь нь бүрэн дунд юм уу мэргэжлийн боловсролын дипломтой. Мөн өрхийн гол орлого олж байгаа гишүүн бакалавр болон түүнээс дээш боловсролтой байх тохиолдол судалгааны хоёр бүлэгт аль алинд нь өндөр байна. Гэрлэлтийн байдлын хувьд шилжигч бус өрхийн гол орлого олж буй хүн нь албан ёсоор батлуулсан, батлуулаагүйгээс үл хамааран 79.7 хувь нь хамтран амьдрагчтай байна.

Зураг 16. Өрхийн гол орлого бүрдүүлж буй гишүүдийн боловсрол, гэрлэлтийн байдал

Гол орлого ологчийн боловсролын түвшин



Гол орлого ологчийн гэрлэлтийн байдал




Эх сурвалж: Инфографикийг ХБСХ-ийн судалгааны баг боловсруулав.

Зураг 17-д Эрүүл мэнд, боловсролын индекс (ЭМБИ)-ийн дөрвөн бүрэлдэхүүн үзүүлэлтээр авсан оноог өрхийн төрлөөр (шилжигч болон шилжигч бус өрх) харуулсан болно. ЭМБИ-ийн үндсэн дөрвөн үзүүлэлтийн гуравт нь шилжигч болон шилжигч бус өрхийн аль аль нь харьцангуй өндөр оноо авсан байна. Харин сүүлийн үзүүлэлт болох өрхийн тэргүүн буюу гол орлого олж буй хүний боловсролын түвшний үзүүлэлт нь 0.67 буюу эмзэг байдлын босго онооноос бага байна. Өөрөөр хэлбэл өрхийн тэргүүн буюу гол орлого олж буй хүний боловсролын түвшин нь эрүүл мэнд, боловсролын хүрээнд өрхийн эмзэг байдлыг үнэлэхэд чухал нөлөөтэй хүчин зүйл болж байна.



Зураг 17


Шилжигч болон шилжигч бус өрхийн ЭМБИ үзүүлэлтүүдийн дундаж оноо



Нийгмийн индексийн (НИ) бүрэлдэхүүн үзүүлэлтэд гарсан оноог Зураг 18-д харуулав. Амьдарч буй орон нутагт дахь аюулгүй байдлаас бусад үзүүлэлтэд шилжигч болон шилжигч бус өрхийн оноо нь эмзэг байдлын босгоос доош байна. Шилжигч өрхийн хувьд амьдарч буй орчин, нийгэм, олон нийт дэх дахь оролцоо, итгэх итгэл, аюулгүй байдалд шилжигч бус өрхүүдээс бага оноо авсан байна. Харин шилжигч өрхүүд нь шилжигч бус өрхүүдтэй харьцуулахад албан бус дэмжлэг авах боломжийн хувьд өндөр оноо авсан байна. Албан бус дэмжлэг нь эцэг эх, ах дүүс, бусад гэр бүлийн гишүүд, найз нөхөд болон ажлын газар, хөршүүд болон уугуул нутагт нь байгаа хүмүүсээс өгч буй хоол хүнс, санхүү болон сэтгэл зүйн дэмжлэгийг өдөр тутамдаа өгч туслах хэлбэрээр илэрч байдаг.

Зураг 18.

Шилжигч болон шилжигч бус өрхийн НИ үзүүлэлтийн оноо



Зураг 19-т Улаанбаатар хот руу шилжин суурьшсаны дараа бүртгэлгүй шилжигчдэд түгээмэл тохиолддог бэрхшээл, асуудлуудыг тусгав. Шилжигч өрхүүд нь бүртгэлгүй учраас гэрэлтүүлэг зэрэг дэд бүтцийн хөгжил муу, хотын захын бүс нутгуудаар хашаа байшин түрээсэлж амьдардаг. Мөн чанарын судалгаагаар бүртгэлгүй шилжигч өрхүүд нь хотын захаар оршин суухдаа хөршүүдээсээ хууль бусаар цахилгаан авдаг болохыг нь тогтоосон. Асуулгад оролцсон зарим хүмүүс худаг гэрээс нь хол байрладаг учраас худаг ус авахад хүндрэлтэй байдаг гэж хариулсан байна.


Бүртгэлгүй 540 шилжигчдийн гуравны нэг нь буюу 29.3 хувь нь ус, цахилгаан, дулаан зэрэг үндсэн дэд бүтцийн үйлчилгээ авах нь хамгийн том бэрхшээл байдаг гэж хариулсан. Дэд бүтцийн хангамжийн дараах хоёр дахь хамгийн том тулгардаг бэрхшээл нь хотод тохиромжтой ажил олох гэж хариулжээ. Албан ёсны оршин суух зөвшөөрөлтэй л бол тухайн хүн байнгын ажилтай байж, цахилгаанд холбогдох боломж бүрддэг учраас чанарын судалгааны үр дүн ч бас энэ үр дүнг баталж байна.

Зураг 19 Бүртгэлгүй шилжигсдэд тулгардаг үндсэн бэрхшээлүүд



Зураг 20-д СҮИ дахь үзүүлэлтүүдийн оноог харуулсан бөгөөд бүгд эмзэг байдлын босго буюу 0.67-оос дээш байгаа юм. Хэдийгээр бүртгэлгүй шилжигчдийн хувьд дэд бүтцийн үйлчилгээ авахад бэрхшээлтэй тулгардаг ч гэсэн эцсийн дүндээ ямар нэг аргаар ус, тог, дулааны эх үүсвэр зэргээ хангаж чаддаг байна.

Зураг 20. Шилжигч болон шилжигч бус өрхийн СҮИ үзүүлэлтийн дундаж оноо



3.2.5 Шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь шилжин суурьшигчдын эмзэг байдалд хэрхэн нөлөөлснийг үнэлэх арга зүй

Энэ хэсэгт ANOVA буюу вариацийн шинжилгээ, олон хувьсагчийн регресс ашиглан дотоодын шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь шилжин суурьшигчдын эмзэг байдалд хэрхэн нөлөөлснийг үнэлсэн болно.

Өрхийн эмзэг байдалтай холбоотой өмнөх судалгаануудад үндэслэн шилжигчдийн эмзэг байдал нь газар зүй, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлтэй хамааралтай гэсэн таамаглалыг бид дэвшүүллээ. Нийгэм эдийн засгийн үзүүлэлтэд (Bhattacharjee ба Behera, 2018) дараах хүчин зүйлс багтана. Үүнд: Өрхийн тэргүүний гэрлэлтийн байдал; өрхийн тэргүүний хүйс, нас болон боловсрол эзэмшсэн хугацаа; ам бүлийн тоо, хүүхдийн тоо; ам бүлийн тоонд эзлэх хүүхэд, настай хүний тооны хувь (нэг өрхөд байх 0-14 насны хүүхэд болон 60-аас дээш настай ахмадуудын тоог ам бүлийн тоотой харьцуулсан хувь) (Baileygunhi ба Fraser, 2010); болон өрхийн тэргүүний орлого, ажил эрхлэлт зэрэг багтана. Газар зүйн хүчин зүйлд (Brooks et al., 2005) засмал зам, малын зах, усны эх үүсвэр хүртэлх зай зэрэг багтана.

Энэхүү дүн шинжилгээнд хамаарах хувьсагч нь ОТЭБИ бол тайлбарлах хувьсагч



нь Тэгшитгэл 1-д харуулсан газар зүй болон нийгэм эдийн засгийн дараах хувьсагчдаас бүрдэнэ:

$$MVI_j = \alpha + \beta_1 \cdot x_1 + \beta_2 \cdot x_2 + \dots + \beta_i \cdot x_i + \gamma \cdot BAN + \delta \cdot \text{Migration Dummy} + \varepsilon \quad (1),$$

ҮҮНА

MVI_j	=	өрхийн олон талт эмзэг байдлын индекс j
x_i	=	газар зүй болон нийгэм эдийн засгийн хувьсагч
BAN	=	2017-2020 оны хязгаарлалтын үеийн dummy хувьсагч
Migration Dummy	=	шилжин суурьшсан өрхийн dummy хувьсагч
ε	=	алдааны хэсэг

Тэгшитгэл 1-д бид шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь шилжигчдийн эмзэг байдалд хэрхэн нөлөөлснийг үнэлэхийн тулд BAN буюу 2017-2020 оны хязгаарлалтын үеийн dummy хувьсагч болон Migration Dummy буюу шилжин суурьшсан өрхийн хувьсагч ашигласан. BAN dummy хувьсагчийн хувьд тухайлсан он нь 2017-2020 оны хооронд байвал 1, үгүй бол 0 гэсэн утга авна. Шилжигч өрхийн хувьсагчийн хувьд өрх нь шилжин суурьшсан бол 1, үгүй бол 0 гэсэн утга авна.

3.2.6. Вариацийн шинжилгээ болон олон хувьсагчтай регрессийн үр дүн

Энэ хэсэгт өрхийн судалгааны өгөгдөл ашигласан вариацийн шинжилгээ болон олон хувьсагчтай регрессийн үр дүнг тайлбарлав. ANOVA шинжилгээ нь шилжигчдийн бүртгэлийн төрлөөс хамааран олон талт эмзэг байдлын индексийн оноо ялгаатай байх эсэхийг шалгах юм. Харин олон хувьсагчтай регресс нь шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан онуудад шилжин суурьшсан бол олон талт эмзэг байдлын индексийн оноо ялгаатай байх эсэхийг тодорхойлох зорилготой.

Шилжилтийн бүртгэлийн төрлөөс хамааран олон талт эмзэг байдлын индексийн оноо өөрчлөгдөх эсэх дээр дараах таамаглалыг дэвшүүлсэн. Үүнд:

$$H_0 : \mu_{\text{Officially registered}} = \mu_{\text{Unregistered}} = \mu_{\text{Temporarily}}$$

H_a : Нийт түүврийн дундаж утга тэнцүү биш.

H_0 нь албан ёсны бүртгэлтэй байнгын оршин суугч, түр оршин суугч, бүртгэлгүй оршин суугч гэсэн 3 бүлгийн хувьд олон талт эмзэг байдлын индексийн дундаж утга (MVI mean values) нь ижил байхыг илэрхийлнэ. Вариацийн шинжилгээ нь 3 түүврийн ажиглагдсан ялгаа нь H_0 таамаглалыг няцаахад хангалттай их эсэхийг тодорхойлох статистик аргачлал юм. Хэрэв H_0 таамаглал няцаагдвал бүх түүврийн дундаж нь ялгаатай гэж дүгнэх боломжгүй болно. H_0 таамаглалыг няцаана гэдэг нь доод тал нь 2 төрлийн түүврийн хувьд дундаж нь ялгаатай байна гэсэн үг.

6-р хүснэгтэд вариацийн шинжилгээний үр дүнг харуулав. P-Утга = 0.00087, байгаа нь ач холбогдлын түвшин $\alpha=0.05$ -аас бага байна. p-утга $\leq \alpha$, байснаар H_0 таамаглал няцаагдаж байна. Өөрөөр хэлбэл, **бүртгэлийн төрлөөс хамааран 3 төрлийн түүврийн ОТЭБИ-ийн дундаж утга өөр өөр гарч байна гэсэн үг.**

Хүснэгт 6.

Вариацийн шинжилгээний үр дүн буюу бүртгэлийн төрлөөс хамааран олон талт эмзэг байдлын индексийн оноо өөрчлөгдөж буй эсэх

ҮР ДҮН

Бүлэг	Тоо	Нийт	Дундаж	Хувьсагч
Албан ёсны бүртгэлтэй шилжигч өрхүүд	532	362.3125	0.681038534	0.012147731
Бүртгэлгүй шилжигч өрхүүд	540	354.6875	0.656828704	0.012196731
Түр оршин суух бүртгэлтэй шилжигч өрхүүд	490	325.375	0.664030612	0.010487811

Вариацийн шинжилгээ

Хувьсагчийн эх үүсвэр	SS	df	MS	F	p-утга	F crit
Бүлгүүдийн хооронд	0.164859316	2	0.082429658	7.079142751	0.00087	3.001496
Бүлэг дотроо	18.15302241	1 559	0.011644017			
Нийт	18.31788172	1 561				

Note: SS – sum of squares; df – degrees of freedom; MS – mean square; F – F-test statistic; F crit – F-test critical value

Одоо аль 2 бүлгийн хувьд дундаж утга өөр байсныг олъё. Ингэхдээ Фишерийн хамгийн бага ач холбогдол бүхий зөрүүний загвар (Fisher’s least significant difference (LSD))-ыг ашиглалаа. Энэ загвар нь t-тестийн статистик ашигладаг ба дараах томъёогоор илэрхийлэгдэнэ. Үүнд:

$$t = \frac{\bar{x}_i - \bar{x}_j}{\sqrt{\text{MSE} \left(\frac{1}{n_i} + \frac{1}{n_j} \right)}}$$

Энд,

- \bar{x}_i, \bar{x}_j = бүлэг тус бүрийн олон талт эмзэг байдлын индексийн дундаж утга
- n_i, n_j = бүлэг тус бүрийн түүвэр өгөгдлийн тоо
- MSE = алдааны квадрат дундаж ба өмнөх вариацийн шинжилгээний хүснэгтэд 0.011644017-тай тэнцүү байсан (Хүснэгт 6).
- Чөлөөний зэрэг (df) = $n_T - k = 1,562 - 3 = 1,559$

Фишерийн хамгийн бага ач холбогдол бүхий зөрүүний загварын үр дүнг 7-р хүснэгтэд харуулав. Хүснэгтийн хамгийн сүүлийн мөрөнд H_0 таамаглалыг няцаасан эсэхийг оруулсан болно.



Хүснэгт 7. Фишерийн хамгийн бага ач холбогдол бүхий зөрүүний загварын үр дүн

#	Таамаглал	$\bar{x}_i - \bar{x}_j$	$\sqrt{MSE \left(\frac{1}{n_i} + \frac{1}{n_j} \right)}$	t тест статистик	t тархалтын утга $df = 1559$	Үр дүн
1	$H_0: \mu$ Албан ёсны бүртгэлтэй = μ Бүртгэлгүй $H_a: \mu$ Албан ёсны бүртгэлтэй $\neq \mu$ Бүртгэлгүй	0.681-0.657 =0.024	0.0066	3.641	1.961	Няцаагдсан H_0
2	$H_0: \mu$ Албан ёсны бүртгэлтэй = μ Түр зуурын $H_a: \mu$ Албан ёсны бүртгэлтэй $\neq \mu$ Түр зуурын	0.681-0.664 =0.017	0.0068	2.516	1.961	Няцаагдсан H_0
3	$H_0: \mu$ Түр оршин суух = μ Бүртгэлгүй $H_a: \mu$ Түр оршин суух $\neq \mu$ Бүртгэлгүй	0.664-0.657 =0.007	0.0067	1.040	1.961	Няцаах боломжгүй H_0

Албан ёсны бүртгэлтэй шилжигчид болон бүртгэлгүй шилжигчдийн олон талт эмзэг байдлын дундаж утга ижил байна гэсэн H_0 таамаглал статистикийн хувьд няцаагдав. Өөрөөр хэлбэл бүртгэлгүй шилжигчид нь байнгын оршин суух бүртгэл хийлгэсэн шилжигчидтэй харьцуулахад илүү эмзэг байдалтай гэсэн үр дүн гарсан болно. Түүнчлэн байнгын оршин суух бүртгэл хийлгэсэн болон түр оршин суух бүртгэлтэй шилжигчдийн хувьд олон талт эмзэг байдлын дундаж утга ижил байна гэсэн H_0 таамаглал статистикийн хувьд няцаагдав. Тиймээс вариацийн шинжилгээнээс харахад түр оршин суух бүртгэлтэй шилжигчдийн хувьд мөн л байнгын оршин суух бүртгэл хийлгэсэн шилжигчдээс илүү эмзэг гэсэн дүгнэлт гарч байна. Гэхдээ түр оршин суух бүртгэлтэй болон бүртгэлгүй шилжигчдийн хувьд олон талт эмзэг байдлын дундаж утга нь ижил гэсэн H_0 таамаглалыг няцаах боломжгүй байлаа. Эндээс харвал түр оршин суух бүртгэлтэй болон бүртгэлгүй шилжигчдийн хувьд олон талт эмзэг байдлын дундаж утга нь статистикийн хувьд ач холбогдолтой хэмжээний зөрүүгүй байна.

Вариацийн шинжилгээний дүнд албан ёсны бүртгэлтэй шилжигчид нь түр оршин суух болон бүртгэлгүй шилжигчдээс эмзэг байдал нь бага гэсэн дүгнэлт гарч байна. Харин түр оршин суух болон бүртгэлгүй шилжигчдийн хувьд эмзэг байдлын ач холбогдол бүхий статистик ялгаа байгаагүй болно.

Шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан онуудад шилжин суурьшсан байдал нь олон талт эмзэг байдлын утгад хэрхэн нөлөөлөхийг олон хувьсагчтай регресс ашиглан тодорхойлов. Эдгээр хувьсагчийг t болон F тест ашиглан 95% итгэлцлийн түвшингээр үнэлсэн ба загвараас ач холбогдолгүй хувьсагчийг хассан болно. Хүснэгт 8-д үнэлгээнд ашигласан 4 загварыг харуулсан ба загвар бүрт алдааны вариаци нь тогтмол биш (өөрөөр хэлбэл heteroscedasticity илэрсэн) байна. Мөн бүх загварын үнэлгээ “robust” буюу “сайн” гэж гарсан ба стандарт алдаа засагдсан. Өрхийн судалгаа бүхий регрессийн хувьд ОТЭБИ-т нөлөөлж болох хувьсагчийг ашигласан ба t болон F тест ашиглан 95% итгэлцлийн түвшингээр үнэлэхэд статистикийн хувьд ач холбогдолтой гарсан. Мөн ач холбогдолгүй хувьсагчийг хассан болно. BAN dummy хувьсагчийн хувьд тухайлсан он нь 2017-2020 оны хооронд байвал 1, үгүй бол 0 гэсэн утга авсан.

Хүснэгт 8. Шилжин суурьшсан өрхийн олон талт эмзэг байдлыг тодорхойлох регрессийн үр дүн

Хамаарах хувьсагч: Шилжигч өрхийн ОТЭБИ				
Бие даасан хувьсагч	(1)	(2)	(3)	(4)
BAN_dummy	-0.024 ^a	-0.022 ^a	-0.015 ^a	-0.013 ^b
	(0.006)	(0.005)	(0.005)	(0.005)
Өрхийн гол орлого бүрдүүлэгч, эмэгтэй (Main-Sex_Woman)		-0.015 ^a	-0.013 ^b	-0.013 ^b
		(0.006)	(0.005)	(0.005)
Хамаарах байдлын харьцаа (Dependency_Ratio)		-0.027 ^a	-0.03 ^a	-0.031 ^a
		(0.009)	(0.009)	(0.009)
Өрхийн гол орлого бүрдүүлэгч, бага боловсролтой (Main_Edu_Low)		-0.062 ^a	-0.058 ^a	-0.058 ^a
		(0.005)	(0.005)	(0.005)
Өрхийн тэргүүн, гэрлэсэн (Head_Married)		0.032 ^a	0.024 ^a	0.025 ^a
		(0.006)	(0.006)	(0.006)
Өрхийн тэргүүн, салсан (Head_Divorced)		-0.024 ^c	-0.029 ^b	-0.027 ^b
		(0.014)	(0.013)	(0.013)
Шилжин суурьшихаас өмнөх үеийн орлого (Income_Before_Migrating)			0.0 ^a	0.0 ^a
			(0)	(0)
Байшинд амьдардаг (Housing_House)			0.038 ^a	0.038 ^a
			(.006)	(0.007)
Нийтийн байранд байдаг (Housing_Public_Dormitory)			-0.072 ^a	-0.07 ^a
			(0.008)	(0.009)
Сүхбаатар дүүрэгт амьдардаг (District_Sukhbaatar)				-0.014 ^a
				(0.005)
Шилжсэн шалтгаан: амьдрах орчин (Mig_Reason_Living_Condition)				-0.014 ^b
				(0.006)
Улаанбаатар хотын бүртгэл (Registration Type in Ulaanbaatar)				-0.001
				(0.003)
Сул коэффициент (тогтмол тоо) (Intercept)	0.682 ^a	0.712 ^a	0.704 ^a	0.71 ^a
	(0.004)	(0.006)	(0.007)	(0.009)
Ажиглалтууд (Observations)	1 562	1 562	1 562	1 562
R квадрат	0.011	0.13	0.196	0.203

Тэмдэглэл: хаалтын дотор стандарт алдааг илэрхийлсэн.

^a $p < 0.01$, ^b $p < 0.05$, ^c $p < 0.1$



Тооцооллын дүнд бид 4-р загварыг сонгосон ба уг загвар нь бусадтай харьцуулахад тайлбарлах боломж өндөртэй байв. Мөн $BAN\ dummy$ хувьсагч болон бусад тайлбарлах хувьсагчийн хувьд статистикийн ач холбогдолтой байсан. $R^2=0.203$ гэдэг нь шилжин суурьшсан өрхийн олон талт эмзэг байдлын хувьд эдгээр тайлбарлах хувьсагч нь 20.3 хувийн вариаци буюу тархалттай байна гэсэн үг. Загвар 4-т ашигласан коэффициентийг тайлбарлавал $BAN\ dummy$ -ын утга нь -0.013 буюу хязгаарлалт бүхий онуудад шилжин суурьшсан бол олон талт эмзэг байдлын индекс нь бусад онуудтай харьцуулахад 1.3 хувиар бага байна. Хэрэв өрхийн орлогыг зонхилон бүрдүүлэгч гишүүн нь эмэгтэй бөгөөд боловсролын түвшин доогуур бол ОТЭБИ бага байх хандлагатай. Гэрлэлтийн байдлын хувьд өрхийн тэргүүн нь гэрлэсэн бөгөөд албан ёсоор бүртгүүлсэн бол ОТЭБИ өсөх ба гэр бүл салсан бол бага байх хандлагатай байна.

Ам бүлийн тоонд эзлэх хүүхэд, хөгшдийн тоо 10 хувиар өсөхөд өрхийн эмзэг байдал дагаад 3.1 хувиар өсөх магадлалтай байна. Шилжин суурьшихаас өмнө орлого сайтай байсан өрхийн хувьд ОТЭБИ өссөн гарах магадлалтай ажээ. Мөн хувийн байшинд амьдардаг шилжигчдийн ОТЭБИ нь нийтийн байранд амьдардаг шилжигчийнхээс өндөр гэсэн үр дүнтэй байна.

Мөн регрессийн үр дүнгээс харахад Сүхбаатар дүүрэгт шилжигчдийн хувьд ОТЭБИ бусад дүүрэгтэй харьцуулахад тааруу байна. Энэ нь тус дүүрэгт олон тооны оюутан, түрээсээр амьдрагч нар байдагтай холбоотой байх боломжтой. Мөн нэгэн сонирхолтой үр дүн гарсан нь Улаанбаатар хотод амьжиргаагаа дээшлүүлэхээр ирсэн шилжигчдийн ОТЭБИ нь бусадтайгаа харьцуулахад доогуур гарсан явдал юм. Улаанбаатарт шилжин суурьшиж судалгаанд хамрагдсан 1562 өрхийн хувьд 212 нь амьжиргаагаа дээшлүүлэхийн тулд нүүж ирсэн бөгөөд тэдгээрийн 28.8 нь эмзэг өрх байна.

Улаанбаатар хот дахь шилжигчдийг албан ёсоор бүртгүүлсэн, түр оршин суугчаар бүртгүүлсэн, огт бүртгэлгүй гэсэн гурван ангилалд хуваадаг. Тиймээс регрессийн тэгшитгэлд оршин суух төрлийг үл хамаарах хувьсагчаар сонгож ОТЭБИ-т хэрхэн нөлөөлөхийг тооцсон боловч энэ хувьсагч нь статистикийн хувьд ач холбогдолгүй гарсан юм.

3.3. УЛААНБААТАР ХОТЫН ОРШИН СУУГЧДАД ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ХЯЗГААРЛАЛТ НӨЛӨӨЛСӨН БАЙДАЛ

Энэхүү тайлангийн хүрээнд Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг хориглосон түр зуурын хориг нь шилжигч бус болон шилжигч иргэд, хотын уугуул оршин суугчдын амьдралын нөхцөл байдлыг сайжруулах үндсэн зорилгодоо хүрсэн үү гэсэн асуултад хариулахыг зорьсон. Шилжилт хөдөлгөөний хоригоос болж амьдрах орчны чанарт тодорхой өөрчлөлт орсон эсэхийг энэхүү судалгаа олж тогтоох зорилготой байсан. Арга зүйн хувьд эдийн засгийн сайн сайхан байдал, эрүүл мэнд ба боловсрол, нийгмийн нөхцөл байдал болон нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж зэрэг дөрвөн үндсэн хүрээнд эмзэг байдлын индекс дүн шинжилгээ хийж, ЗБХ зохион байгуулсан юм. Үнэлгээний үр дүнд шилжилт хөдөлгөөний хориг нь Улаанбаатар хотын оршин суугчдын амьдралын орчин нөхцөлийг сайжруулаагүй гэсэн дүгнэлт гарсан.

Шилжигч бус иргэдээс авсан тоон судалгаанаас харахад судалгаанд хариулсан хүмүүсийн ихэнх буюу 57 хувь нь Улаанбаатар хот дахь амьдрах орчныг сайжруулахад түр зуурын хориг нь ямар нэгэн нэмэр болоогүй гэж хариулсан байна. Шилжигч болон шилжигч бус иргэдийн оролцсон ЗБХ нь энэхүү үр дүнг дэмжиж байгаа юм. Хорио бүрэн хэрэгжиж байх хугацаанд амьдралын нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөн талаар асуулт асуухад гэр хороолол болон

орон сууцанд амьдарч буй хүмүүс амьдралын нөхцөл хэцүү хэвээр байгааг дурдсан. Гэвч тэд 2017-2020 оны хорио тавигдах хугацаанд агаарын бохирдол буурч нийгмийн тусламж, халамжийн үйлчилгээний хэрэгжилт сайжирсан гэж үзсэн байна. Шилжих хөдөлгөөний хязгаарлалт тавих үед мөн түүхий нүүрсний хэрэглээг бууруулах, сайжруулсан түлш хэрэглэх зэрэг шинэ санаачилгыг мөн давхар дэвшүүлэн хэрэгжүүлж байсан учраас эдгээр дэвшил нь шилжилт хөдөлгөөний хязгаарлалттай бүрэн холбоотой гэж дүгнэхэд бэрхшээлтэй байна (Kwong, 2019b). Нийгмийн хамгааллын хувьд Засгийн газар нь 2020 оны УИХ-ын сонгуулийн стратеги болгож КОВИД-19-т хариу үйлдэл үзүүлэх зорилгоор хүүхдийн мөнгөний дүнг 20000 төгрөгөөс 100000 (НҮБХС, 2020) болгож өсгөсөн зэрэг Засгийн газраас хэрэгжүүлсэн халамжийн бодлоготой холбоотойгоор иргэдэд хүрэх үйлчилгээ нэмэгдсэн байна.

Шилжилт хөдөлгөөний хориг нь хүмүүсийн сайн сайхан байдалд эерэг үр дүн авчраагүй гэсэн үр дүнг эмзэг байдлын индексийн дүн шинжилгээнээс давхар харах боломжтой. Шилжигч болон шилжигч бус иргэдийн хувьд ОТЭБИ нь 0.67-0.68 хувьтай байгаа бөгөөд (0-ээс 1 хүртэлх үнэлгээгээр харьцуулахад 1 нь эмзэг байдал хамгийн багатай) эдгээрээс шилжин суурьшиж буй иргэд нь илүү эмзэг байдалд өртөж байна гэдгийг гаргасан. Эмзэг байдал өндөр байгаа нь шилжин суурьшиж буй иргэд болон шилжигч бус иргэдийн аль алиных нь сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлсөн гэж үзэж байгаа юм. Нийт түүврээс шилжигч иргэдийг тусад нь авч үзвэл шилжигч иргэд нь шилжигч бус иргэдтэй харьцуулахад дөрвөн хүрээнд нэн ялангуяа эдийн засгийн сайн сайхан байдлын хувьд илүү эмзэг байдалд байгаа нь тогтоогдсон. Тэр дундаа бүртгэлгүй шилжигчид нь шилжилт хөдөлгөөний хоригийн үеэр боловсрол, эрүүл мэнд ба хамгаалал (яаралтай түргэн тусламж, гэр бүлийн хүчирхийлэл, жирэмслэлт болон нярайн асаргаанаас бусад үед) болон дэд бүтцийн үйлчилгээнүүд (цахилгаан) зэрэг гол үйлчилгээнүүдийг авч чадахгүй байсан байна.

3.3.1. Эдийн засгийн сайн сайхан байдал

Хэдийгээр энэхүү хүрээнд шилжигч болон шилжигч бус иргэд нь нэн эмзэг байгаа боловч шилжигчийн ЭЗБИ оноо нь 0.34, шилжигч бус нь 0.38 оноотой байгаа нь статистикийн хувьд томоохон ялгаатай ба шилжигч иргэд илүү эмзэг байдалд байгааг илэрхийлж байна. КОВИД-19 болон ерөнхий эдийн засгийн нөхцөл байдал зэрэг бусад томоохон хүчин зүйлүүд нь эдийн засгийн нөхцөл байдалд нөлөөлж байгаа хэдий ч индекс болон ЗБХ-ийн үр дүнгээс харахад шилжилт хөдөлгөөний хориг нь Улаанбаатар хотын оршин суугчид нэн ялангуяа шилжигчдийн эдийн засгийн байдалд сөргөөр нөлөөлсөн байна. Тухайлбал шилжигч иргэдийн дундаж цалингийн хэмжээ шилжигч бус иргэдийн дундаж цалингийн хэмжээнээс 200000 төгрөгөөр бага байгаа бөгөөд асуулгад оролцсон шилжигчдийн 28 орчим хувь нь ажил олоход бэрхшээлтэй байсан, 25 хувь нь хоригийн хэрэгжилтийн хувьд хөрөнгө өмчлөн авахад асуудалтай байсан гэж хариулсан байна. ЗБХ-ээр үүний цаадах шалтгааныг нь тодорхой гаргаж өгсөн юм.





“Би Улаанбаатар хотод албан ёсоор бүртгүүлээгүй байгаа. Хүүхдүүдтэйгээ амьдрахын тулд Дархан-Уул аймгаас хот руу нүүж ирсэн. Бүртгүүлэх гэж оролдох болгонд орон нутгийн засаг захиргаанаас шилжилт хөдөлгөөний хоригтой холбоотойгоор буцаадаг. Энэ талаар хорооны засаг даргатай нэлээд ярилцсан. Ажлын байр байгаа хэдий ч миний насны хүмүүст зөвхөн цэвэрлэгчийн ажил олдож байна. Зарим нэг ажил олгогчийн хувьд Улаанбаатар хотын бүртгэлгүй болохоор миний ажлын өргөдлийг ч авч хэлэлцдэггүй. Зарим газар нь туршилтын байдлаар хэдэн өдөр ажиллуулаад л албан ёсоор бүртгэлгүй гээд авалгүй буцаадаг. Заримдаа туршилтын хугацааныхаа цалинг ч авч чадахгүй байдалд ордог. Бүртгэлгүй болохоор одоогоор дөрөв дэх ажлынхаа туршилтын хугацаанд явж байна.

Шилжигч иргэний ажил хайсан тухай түүх I



“Манай нөхөр хөдөө орон нутагт бүртгэлтэй ч хотод ажилладаг. Шилжилт хөдөлгөөний хоригийн улмаас Улаанбаатарт албан ёсоор бүртгэлгүй байгаа учраас машин авахаар хөөцөлдөхөд банкнаас бидний өргөдлийг хүлээж аваагүй. Тиймээс бид хувь зээлдэгч нараас өндөр хүүтэй зээл авсан бөгөөд машинаа мөргөлдүүлэх зэрэг ямар нэгэн асуудал гарахад Улаанбаатар хотод бүртгэлгүй гэдэг шалтгаанаар даатгалд хамрагдах боломжгүй байдаг.

Шилжигч иргэний зээл авах, хөрөнгө эзэмшихэд тулгарсан асуудлын талаарх түүх II

3.3.2. Нийгмийн нөхцөл байдал

Нийгмийн нөхцөл байдлын хүрээнд бид олон нийтийн ажиллагаа дахь идэвх оролцоо, шаардлагатай тохиолдолд албан бус (олон нийт, хүрээлэн буй орчин, нийгмийн бусад бүлгүүдээс) тусламж авах боломж, амьдарч буй орчин, орон нутаг, нийгэм, олон нийтэд итгэх итгэл болон хүрээлэн буй орчин, нийгэм, олон нийтийн аюулгүй байдлыг авч үзсэн. Нийгмийн нөхцөл байдлын эмзэг байдлын дүн шинжилгээгээр шилжигч болон шилжигч бус өрхүүд нь шилжилт хөдөлгөөний хоригийн үед НИ оноо нь 0.52–0.53 байгаа нь адилхан эмзэг байдалд өртдөг гэдгийг харуулсан байна. Энэхүү үр дүнг баталгаажуулж ЗБХ-ийн оролцогч нар хот болон хөдөөгийн оршин суугчдын хооронд томоохон хэмжээний зөрчил, соёл, хандлагын ялгаа байдаг гэж үзсэн байна. Хотын уугуул иргэд хөдөө орон нутгийн хүмүүсийг ялгаж харьцдаг болохыг ч зарим нь дурдсан юм.



Манай давхарт ганцаараа амьдардаг залуу бий. Хүмүүс гэрийнх нь хаалган дээр хог битгий хая гэсэн сануулга бичиж байсан. Үнэн хэрэгтээ тэр залуу хог хаядаггүй. Өөр нэг жишээ гэвэл саяхан гурван давхарт нэг хүн хөдөөгөөс нүүж ирсэн бөгөөд оршин суугчид хог хаяхгүй байх тухай ижил утгатай бичиг бүхий цаасыг тэдний хаалган дээр нааж байсан. Ихэнх оршин суугчид нүүж ирсэн хүмүүсийг хөдөөгөөс ирж байгаа, тиймээс хогоо ил задгай хаяж байна гэж бодоод байдаг бололтой.”

Шилжигч иргэний гадуурхалтын талаарх түүх III

ЗБХ-ийн оролцогчдын ихэнх нь хорооны уулзалт, орон нутгийн засаг захиргааны баг, хорооны ажилтнууд, тэдний үүрэг, үйл ажиллагааны талаар сайн мэдэхгүй

гэж хариулсан байна. Мөн шилжигчид нь хотын нийтийн эзэмшлийн талбайд аюулгүй байдлыг мэдэрдэггүй бөгөөд ихэнхдээ хотоос хол, гэр хороололд нүүж ирдэг, гэр хороолол нь гудамжны гэрэлтүүлэг байхгүй, зохих дэд бүтэцгүй учраас аюулгүй байдлын хувьд учир дутагдалтай байдаг гэж хариулсан байна. Зарим шилжигч нь цахилгааны холболт хийлгэхийн тулд албан ёсны бүртгэл шаардлагатай байдаг учраас ихэвчлэн цахилгаантай болох хууль бус, аюултай арга замыг сонгодог учраас шилжилт хөдөлгөөний хориг нь нөхцөл байдлыг улам хүндрүүлсэн гэж мэдээлсэн байна. Энэхүү аюулгүй байдал хангаагүйгээс болж гэр хороололд насан хүрсэн хүн, бага насны хүүхэд хүртэл нас барах үзэгдэл гарч байжээ (MMINFO, 2019).

Эмзэг байдлын индексийн үр дүн болон ЗБХ-ээр гарсан санаануудаас харахад хориг тавьсны үр дүнд Улаанбаатар хотын оршин суугчдын нийгмийн сайн сайхан байдал сайжраагүй. Харин ч эсрэгээрээ илүү аюултай, баталгаагүй амьдрах орчин бүрдүүлж, хот хөдөөгийн соёл, хандлагын ялгааг дэвэргэн нийгэм дахь итгэлцлийг бууруулж нөхцөл байдлыг улам хүндрүүлсэн байна. Энэхүү үр дүн нь бидний судалгааны тоо баримтаар баталгаажиг байна. Илүү дээр амьдрах орчин нөхцөл хайж ирсэн шилжигчид нь бүр илүү эмзэг байдалд өртсөөр байсан бөгөөд шилжих хөдөлгөөний хориг нь Улаанбаатар хотын иргэдийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх зорилтоо хүрч чадаагүй юм.

3.3.3. Эрүүл мэнд, боловсрол

Энэ хүрээнд бид хүнсний аюулгүй байдал, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, өрхийн тэргүүн, гол орлого бүрдүүлдэг хүний боловсролын түвшин болон сургуулийн насны хүүхдийн тогтмол хичээлийн ирц зэргийг авч үзсэн. Холбогдох эмзэг байдлын индексээс харахад шилжигч бус болон шилжигч өрхийн хувьд ЭМБИ оноо нь 0.83-0.85 байгаа нь эмзэг байдлын босго онооноос өндөр байгаа тул эмзэг бус гэсэн ангилалд багтаж байгаа юм. Эдгээр индекс нь эрүүл мэнд болон боловсролын үйлчилгээний хүртээмжийн нөхцөл байдлыг илтгэж байгаа боловч ЗБХ-ийн үр дүнгээс харахад энэхүү оноог цаашид задалж дээрх үйлчилгээг авахын тулд хүмүүс олон төрлийн арга хэмжээ авдаг талаар олж мэдсэн юм. Тухайлбал, сургуульд хүүхдээ оруулахын тулд авлига өгөх зэрэг хууль бус аргыг ашиглан эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг авч буй хүмүүсийг олж тогтоосон. ЗБХ-ээр гарсан мэдээллээс харахад ихэнх оролцогчид энэ төрлийн далд механизм байдаг бөгөөд тодорхой хэмжээний мөнгө албан бусаар өгдөг гэсэн нийтлэг ойлголттой байсан. Эндээс харахад индексийн хариуг чанарын судалгааны үр дүнгээр баяжуулж авч үзэх нь чухал юм.



Хандивын хэлбэр доор хүмүүс хүүхдээ сургуульд оруулахын тулд хамгийн багадаа 100000 төгрөг өгдөг. Хотын төв орчмын сургууль нь бүр үнэтэй байдаг. Энэ нь өөрөө бараг бичигдээгүй хууль болж тогтжээ. Өнгөрсөн жил хотын төвийн сургуульд хүүхдээ өгөхөд 250000 төгрөгийн хандив өгч байсан бол энэ жил хандив нь өссөн гэж байсан.

Шилжигч иргэний сургуулийн авлигын талаарх хуваалцсан түүх IV

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж буй хүмүүсийн хэлснээр эмч нар анхны тусламжийг үзүүлдэг боловч шинжилгээ хийлгэх, нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх болон хагалгаа хийлгэх зэрэг эрүүл мэндийн нэмэлт үйлчилгээ авах ёстой бол бүртгэлгүй шилжигчдийг хоёрдугаар зэрэглэлийн эмнэлгүүд рүү явуулдаг бөгөөд тэнд тэд бүртгэлээ харуулах ёстой. Хорооны түвшинд өрхийн эмнэлгийн



эмч нар нь бүртгэлийн статусаас үл хамааран өвчтөнийг үзэх боловч бүртгэлгүй шилжигчдийн мэдээллийг эрүүл мэндийн бүртгэлийн системд оруулах боломжгүй байдаг. Энэ нь хороон дээр ажиллаж үйлчилгээ үзүүлдэг төрийн албан хаагч нарын хувьд хийсэн ажлаа үнэлүүлэх, ажлын ачааллыг бодитой гаргах, нэмэлт эх үүсвэр хүсэх боломжийг нь хязгаарлах зэргээр олон асуудлуудыг үүсгэж байгаа юм. Тэд асуудлаа бүртгэлгүй шилжигч иргэдэд тайлбарлах гэж оролдвол иргэд бухимдаж, үйлчилгээ үзүүлж буй хүмүүсийг хэл амаар доромжлох, ажлаа хийх нөхцөлийг нь алдагдуулахад хүргэдэг байна. Эдгээр ЗБХ-ээр гарсан үр дүнгээс шилжилт хөдөлгөөний хориг нь хорооны эрүүл мэндийн ажилтнуудын ажлын ачааллыг нэмэх, иргэд болон төрийн албан хаагчдын хоорондох асуудлыг хурцатгах гээд анх бодож тооцоолоогүй үр дүнг авчирч байгаа юм.



“Бүртгэлгүй шилжигчид нь өөрсдийн регистрийн дугаарыг хэлэхээс татгалзаж уурлаж бухимдан биднийг залхуу гэх мэтээр доромжилдог учраас тэднийг үзэхээс өөр аргагүй байдалд хүрдэг. Тийм ч учраас шилжилт хөдөлгөөний хоригийн дараа ажлын ачаалал ихээхэн нэмэгдэж албан бус ажлын ачаалал нэмэгдсэн.”

Нэмэлт ажлын ачааллын талаарх өрхийн эмнэлгийн ажилтны яриа

3.3.4. Суурь үйлчилгээ

Энэ хүрээнд бид өрхийн ундны усны эх үүсвэр, халаалтад хэрэглэх түлш болон цахилгааны хүртээмжийг авч үзсэн юм. Эмзэг байдлын дүн шинжилгээгээр шилжин суурьшсан болон шилжигч бус өрхийн хувьд СҮИ оноо нь 0.95–0.96 байгаа нь хоёулаа эмзэг бус байгааг харуулж байгаа юм. Индекс нь эмзэг байдлын хувьд бага түвшинг илэрхийлж байгаа нь эерэг үр дүнг харуулж байгаа боловч үүнийг маш болгоомжтой авч үзэх нь зүйтэй. ЭМБИ-тэй адилаар энэхүү индекс нь тухайн хүний үйлчилгээг авах хүртээмжийг илэрхийлж байгаа боловч эдгээр үйлчилгээг авахын тулд ямар нөхцөл байдал, саад бэрхшээлийг туулдаг талаар харуулаагүй юм. Түүний тоо баримтуудыг задалж үзвэл шилжигч болон шилжигч бус өрхийн 39 хувь нь төвийн шугамаас бус харин нийтийн болон хувийн худаг, борооны уснаас усаа авдаг байна. Гэр хорооллын ихэнх хэсэгт бохир зайлуулах шугам холбогдоогүй байдгаас эдгээр өрхийн 38 хувь нь нүхэн жорлонтой. Өрхийн 39 хувь нь төвийн халаалттай холбогдоогүй учраас нүүрс, мод түлж дулаанаа хангадаг гэж хариулжээ. Түүврээс шилжигч өрхүүдийг салгаж авч үзвэл үр дүн нь улам муу гарч байгаа юм. Тийм учраас эдгээр нөхцөл байдлуудыг орхигдуулан хүмүүсийн нөхцөл байдал эмзэг бус байна, гол үйлчилгээг авч чадаж байна хэмээн ойлгох нь өрөөсгөл юм. НҮБ-аас эрүүл ахуйтай холбоотой хүний эрхэд ариун цэврийн байгууламж нь бодитой, хямд, хүртээмжтэй байх, хүний бүхий л амьдралын туршид энэ нь аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан, нийгэм соёлын хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүний хувийн орон зайг хүндэлсэн, нэр төртэйгөөр үйлчилгээг авах боломжтой байх ёстой гэж тусгасан. Нүхэн жорлонд бие засах, худгаас ус авах гэж хол замыг туулах, нүүрс түлж дулаацах зэрэг нь эдгээр үндсэн хэрэгцээг хангах таатай нөхцөл биш гэдэг нь тодорхой. Тийм ч учраас индексийн үр дүнг бодлогын шийдвэрт тусгахдаа тухайн газар, орон нутгийн нөхцөл байдал бус хүний эрхийн хэм хэмжээг харгалзан үзэж анхааралдаа авах нь чухал юм.

Үзүүлэлтийн оноо нь бага байгаа нь шилжигч бус болон шилжигч иргэд нь цахилгаан, дулааны хүртээмжийн хувьд харьцангуй эмзэг байдал багатай гэж үзэхээр байна. Гэвч нь ЗБХ-ээр гарсан орон нутгийн иргэд цахилгаанд хэрхэн холбуулдаг тухай үр дүнтэй зөрчилдөж байгаа юм. Шилжилт хөдөлгөөний

хоригийн дагуу бүртгэлгүй шилжигчид нь газар эзэмших эрхгүй бөгөөд албан ёсоор газар эзэмшиж болохгүй учраас цахилгаанд холбогдох боломжгүй юм. Тиймээс бүртгэлгүй иргэд нь өөрийн холбоо, сүлжээг ашиглан тун аюултай нөхцөл байдалд цахилгаанаа холбуулдаг байна (хөршийнхөө цахилгаанаас шугам татах зэргээр).



“Бүртгэлгүй шилжигчид нь хотод ирэхдээ цахилгаан, дулаантай холбогдоогүй хотын хамгийн алслагдмал газарт ихэвчлэн нүүж очдог. Манай гэрийнхний хувьд бид онгоцны буудлын хажууд, Туул голоос цааш Морингийн даваа гэдэг газарт нүүж ирсэн. Дэд бүтэц хөгжөөгүй учраас шөнөдөө хав харанхуй болдог.”

Суурь үйлчилгээний талаарх шилжигч иргэний тухай түүх V

Чанарын болон тоон судалгааг нэгтгэн үнэлж харвал шилжилт хөдөлгөөний хориг нь Улаанбаатар хотын оршин суугчдын сайн сайхан байдалд анх бодож байсан шигээ эергээр нөлөөлж чадаагүй юм. Дөрвөн үндсэн хүрээ болох эдийн засгийн сайн сайхан байдал, эрүүл мэнд боловсрол, нийгмийн нөхцөл байдал болон суурь үйлчилгээний тал дээр ахиц дэвшил гараагүй. Харин ч эсрэгээрээ энэхүү хэсэгт тусгасанчлан бүртгэлгүй шилжигч өрхүүд болон нийт хүн амын хувь шилжилт хөдөлгөөний хориг нь илүү их нийгэм эдийн засгийн асуудлыг үүсгэсэн байна.

3.4. ШИЛЖИГЧ БОЛОН ШИЛЖИГЧ БУС ИРГЭДЭД КОВИД-19 ЦАР ТАХАЛ НӨЛӨӨЛСӨН БАЙДАЛ

КОВИД-19 цар тахал нь дэлхийн улс орон бүрийн нийгэм эдийн засгийн байдалд тодорхой хэмжээгээр нөлөөлж байна. Монгол улсын засгийн газар нь 2020 оны 2 сарын 13-ны өдөр Улаанбаатар хотод КОВИД-19-ийн анхны тохиолдолд бүртгэгдсэнээс хойш бэлэн байдлын зэрэг тогтоон ажилласан. Үүний хүрээнд бүх төрлийн сургууль, цэцэрлэг танхимаар хичээл орохоо больсон бөгөөд бүх төрлийн нийтийн тээвэр (Улаанбаатар хот доторх) болон олон нийтийн үйл ажиллагаанд хязгаарлалт тавьсан. Баар, спорт клуб, жуулчны бааз, амралтын газар, зочид буудал, бараа бүтээгдэхүүний зах болон бөөний худалдааны төвүүдийг хаах, соёлын болон шашны цугларалтыг хориглох зэрэг арга хэмжээг авсан. (Wilson, 2020)


Монгол улсын засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний дагуу зарим байгууллага болон хувийн хэвшлүүд нь ажлын цаг болон цалингаа өөрчилж, зарим нь ажилчдынхаа тоог бууруулсан байна. Тайлангийн энэхүү хэсэгт цар тахал болон түүнтэй холбогдуулан засгийн газраас хэрэгжүүлсэн хорио цээрийн арга хэмжээ нь Улаанбаатар хот дахь шилжигч болон шилжигч бус өрхүүдэд хэрхэн нөлөөлсөн тухай авч үзсэн болно.

КОВИД-19 болон ажил эрхлэлт

Судалгаанд хамрагдсан өрхийн орлогыг бүрдүүлж буй 2120 гишүүдийн ихэнх нь (61%) КОВИД-19 цар тахлаас болж ажиллах цаг нь өөрчлөгдөөгүй гэсэн бол үлдсэн 39 хувь нь гэрээсээ ажиллаж, цалинтай чөлөө авч, хагас цагаар ажиллах болсон байна.



Зураг 21. КОВИД-19-тэй холбоотой нийт өрхийн орлогод орсон өөрчлөлт



Ажил эрхэлдэг гишүүнтэй 2120 өрхөөс авсан судалгаанаас гол орлого олж буй гишүүдийн 46.4 хувь нь цалин нь өөрчлөгдөөгүй гэсэн бол 2.7 хувь нь цалин нь өссөн, 31 хувь нь цалин буурсан гэж хариулсан байна (Зураг 21).


Шилжигч бус 780 өрхийн 50 хувь нь орлого өөрчлөгдөөгүй, 46.3 хувь нь орлого багассан гэсэн бол шилжигч 1340 өрхийн хөдөлмөр эрхэлж буй гишүүдийн 57.7 хувийн орлого нь өөрчлөгдөөгүй харин 31 хувь нь орлого нь багассан гэж хариулсан байна.

Шилжигч, шилжигч бус гэдгээс үл хамааран КОВИД-19 цар тахалтай холбоотой цалингийн хэмжээ хэрхэн өөрчлөгдсөн тал дээр статистикийн хувьд ач холбогдолтой гараагүй юм.

КОВИД-19 болон өрхийн эдийн засгийн нөхцөл байдал

КОВИД-19 цар тахалтай холбогдуулан өрхийн орлого буурсан байдлыг харьцуулж үзэхэд шилжигч бус өрхийн эзлэх хувь нь шилжигч иргэдийнхээс 17.1 хувь бага байсан юм. Нийт судалгаанд хамрагдсан 1562 шилжигч бус өрхийн гуравны хоёр нь буюу 66 хувь нь үндсэн ажилтай, тогтвортой орлоготой байсан бол тэдний 18.4 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж орлого олдог байна. (Зураг 22) КОВИД-19-тэй холбоотойгоор тогтмол ажилтай ажилтнуудын ажлын цаг багассан бөгөөд энэ нь тэдний орлого буурахад нөлөөлсөн байна.


Зураг 22. КОВИД-19-тэй холбоотой шилжигч болон шилжигч бус өрхийн орлогын өөрчлөлт



Орлого буурсантай холбогдуулан шилжигч бус өрхийн 11.2 хувь нь (шилжигч иргэдийн хувьд 6.9 хувь) үндсэн хэрэглээгээ хангаж чадахгүй байна. Шилжигч өрхүүд нь уугуул нутагтаа үлдсэн гэр бүл болон найз нөхдөөсөө албан бус тусламж авах боломжтой байдаг бол Улаанбаатар хотын уугуул иргэдийн хувьд ийм тусламж авах боломж хязгаарлагдмал байдаг. Үүнтэй холбоотойгоор

шилжигч өрхийн дийлэнх хувь нь (59.6%) шаардлагатай үед ойрын хамаатан, найз нөхдийн хүрээллээсээ мөнгөн тусламж авах харьцангуй боломжтой гэж мэдэгдсэн байна. Энэ нь шилжигч бус өрхүүдтэй харьцуулахад 13.1 хувиар өндөр байгаа юм. Нөгөө талаас хотын байнгын оршин суугч өрхийн хувьд шилжигч өрхтэй харьцуулахад зээл авсан байх тохиолдол 16 орчим хувиар өндөр байна.

Зураг 23. КОВИД-19 цар тахлаас шалтгаалан үндсэн хэрэгцээгээ хангахад өрхийн орлого хангалтгүй байх давтамж



Судалгаанаас харахад шилжигч бус өрхийн 65 хувь болон шилжигч өрхийн 49.2 хувь нь бодит өр, зээлтэй байжээ. Яаралтай мөнгө хэрэгтэй болсон үед туслах хүн байгаа юу гэсэн асуултад шилжигч өрхийн 59.5% хувь нь, шилжигч бус өрхийн 46.4% хувь нь туслах хүн байгаа гэж хариулсан байна.

Энэхүү хэсгийг товчхонд нь дүгнэвэл, цар тахлын нөхцөл байдал болон хорио цээрийн арга хэмжээ нь шилжигч бус иргэдэд илүү нөлөөлж байна. Учир нь тэд шилжигч иргэдтэй харьцуулахад өр зээл ихтэй бас шууд тусламж авах боломж муутай байдаг байна.



4. ДҮГНЭЛТ



Дотоодын шилжилт хөдөлгөөний бодлогыг хүний эрхийн үндэсний болон олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй уялдуулан төлөвлөх нь тогтвортой хөгжил, хотжилтыг зохистойгоор дэмжсэн эрүүл, хүртээмжтэй арга зам юм. Хүний эрхийг хязгаарлах тухай цөөн тохиолдолд улсын хил дотор чөлөөтэй зорчих, шилжин суурьших явдлыг хязгаарлах нь хүн амын аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хамгаалахад онц ач холбогдолтой гэдгийг харуулсан үндэслэл, нотолгоог харуулах шаардлагатай билээ (Монгол улсын Үндсэн хуулийн 16 (18) дугаар зүйл). 2017 оны нийслэлийн засаг даргын тамгын газрын гаргасан шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь үндэсний болон олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй нийцэхгүй байгаа бөгөөд хүний эрхийг хязгаарлах шалгуур үзүүлэлтүүдийг хангахгүй байгааг энэхүү судалгааны үр дүнгээс харж болохоор байна. Энэхүү судалгаа нь шилжилт хөдөлгөөний хориг түүний нөлөөллийн талаар эмпирик үнэлгээг агуулсан хамгийн анхны цогц судалгаа болсон юм. Тус судалгааны төслийн хүрээнд өргөн хүрээг хамарсан тоон судалгаа, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, олон улсын болон дотоодын адил төстэй судалгаануудын харьцуулсан дүн шинжилгээ зэрэг судалгааны олон арга барилыг хослуулан ашигласан болно.

Шилжигчийн бүртгэлийн статусаас хамаарч ОТЭБИ-д зөрүү гарч байгаа эсэх болон шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь шилжигчдийн эмзэг байдалд хэрхэн нөлөөлж байгааг олж тогтоохын тулд өрхүүдээс цуглуулсан мэдээлэлд вариацийн шинжилгээ болон олон хувьсагчтай регрессийн тэгшитгэлийг бодсон. Статистик шинжилгээний үр дүнд бүртгэлгүй шилжигч өрхүүд болон түр оршин суух статустай шилжигч өрхүүд нь албан ёсны бүртгэлтэй шилжигч иргэдээс илүү эмзэг байдалд байгааг олж тогтоосон. Мөн ОТЭБИ-ээс харахад шилжилт хөдөлгөөний хязгаарлалт хэрэгжиж буй хугацаанд нүүж ирсэн өрхийн хувьд ОТЭБИ нь 1,3 хувиар бага байгаа үр дүн гарсан. Эндээс харахад шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь шилжигчдийн эмзэг байдалд сөргөөр нөлөөлсөн гэж харагдаж байна.

Шилжилт хөдөлгөөний хориг нь албан ёсоор бүртгэл хийлгэх боломжийг олгоогүй учраас шилжин суурьшсан иргэдийн тоо албан ёсны статистик дээр буурсан мэт харагдаж байгаа боловч судалгаагаар бүртгэлгүй шилжигчдийн тоо өссөн байх магадлалтай бөгөөд энэхүү хориг нь шилжилт хөдөлгөөний урсгалыг бууруулах зорилгодоо хүрч чадаагүй болохыг тогтоосон. Бас нэг онцлох үр дүн нь нийт судалгаанд оролцогчдын 83 хувь нь шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын талаар мэдээлэлтэй байсан ч гэсэн Улаанбаатар хотод нүүх хэвээрээ л байсан гэж хариулсан юм. Энэ нь хязгаарлалтын бодлогын талаарх олон нийтийн дундах ойлголт, мэдээлэл дутмаг байгааг илтгэж байгаа бөгөөд цаашлаад тус бодлого нь ирээдүйд шилжин суурьших хүмүүсийн шийдвэр гаргалтад төдийлөн нөлөөгүй гэдэг нь харагдаж байгаа юм.



Судалгаа нь бүртгэлгүй шилжигчид нь Улаанбаатар хотын байнгын оршин суугчидтай харьцуулахад шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын улмаас эдийн засаг, нийгэм болон эрүүл мэндийн эрсдэлүүдтэй давхар тулгарч байгааг олж тогтоосон юм. Нэн ялангуяа өрх толгойлсон эмэгтэйчүүд, өрхийн тэргүүн нь тэтгэврийн насны болон боловсролын төвшин доогуур байх эсхүл өрхийн гишүүдийн дийлэнх хувь нь тэтгэврийн насны хөгшид болон 14-өөс доош насны олон хүүхэдтэй өрхүүд илүү эмзэг бүлэгт багтаж байгаа бөгөөд төрийн үйлчилгээ авах, ажил олох, үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших боломжгүй байх зэрэг томоохон бэрхшээлүүдтэй тулгарч байна. Эдгээр асуудлуудын үр дүнд төрийн үйлчилгээ авахад авлига өгөх, цахилгаан, дулааны шугамыг хууль бусаар холбох зэрэг эрүүл мэнд, аюулгүй байдлыг зөрчсөн ноцтой үйлдлүүд гарч байна. Үүнээс гадна хотын байнгын оршин суугчдын зүгээс шилжигчдийг ялгаварлан, гадуурхах үзэл ч давхар гарч байсан болно. Зорилтот бүлгийн хэлэлцүүлгээр хотын уугуул оршин суугчдын дийлэнх нь шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь Улаанбаатар хотын хүн амын төвлөрөл, ус хөрсний бохирдол, замын түгжрэл, аюулгүй байдлын асуудал, ажил эрхлэлт зэрэг амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад нэмэр болоогүй гэж үзсэн байна.

Шилжилт хөдөлгөөний хоригийн үр нөлөөний талаар болон дотоодын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах сайн туршлагын талаар мэдлэг мэдээлэл дутмаг байгаа энэ үед уг судалгааны ажил нь энэ чиглэлийн судалгаанд томоохон хувь нэмэр оруулж, цаашдын бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргах үйл явцад нөлөөлнө гэж найдаж байна. Энэхүү судалгаагаар шилжилт хөдөлгөөний хориг нь үр дүнгүй байснаар зогсохгүй олон төрлийн урьдчилан тооцоолоогүй хор холбогдолтой байсан учраас бид богино хугацааны практик шийдэл болон урт хугацааны бодлогын зөвлөмжийг дараагийн хэсэгт тус тус санал болголоо. Бидний санал болгож буй бодлогын стратеги, зөвлөмжүүд нь шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын шууд болон шууд бус үр нөлөөний талаар үнэлгээ, холбогдох талуудын ярилцлага, хэлэлцүүлэг, цуглуулсан нотолгоо, баримтад үндэслэсэн бөгөөд илүү хүртээмжтэй, зохистой шилжилт хөдөлгөөний бодлого, зохицуулалтыг цаашид бий болгоход чиглэсэн билээ.

5. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ



Энэхүү судалгаагаар шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үед шилжигч, тэр дундаа бүртгэлгүй шилжигчид, өрх толгойлсон эмэгтэйчүүд, өрхийн толгойлогч нь тэтгэврийн насны болон боловсролын төвшин доогуур байх эсхүл өрхийн гишүүдийн дийлэнх хувь нь тэтгэврийн насны хөгшид болон 14-өөс доош насны олон хүүхэдтэй зэрэг илүү эмзэг нөхцөл байдалтай өрхүүдэд ямар саад бэрхшээлүүд тулгарч байгааг судлахыг зорилоо. Тоон асуулгын үр дүн, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, бусад чанарын судалгааны үр дүн хоорондоо нийцэж байгаа бөгөөд тэдгээрт үндэслэн бид дараах бодлогын зөвлөмжүүдийг санал болголоо. Тэдгээрийг хүснэгт 6-д нарийвчлан тусгахын зэрэгцээ доорх байдлаар товчлон сийрүүлэв.

- (а) Бүртгэлийн үйл явцыг цахимжуулах, мэдээлэл цуглуулах олон хувилбаруудыг хэрэглэх замаар илүү хялбар, хүртээмжтэй болгож, үйлчилгээний зардлыг бууруулах, орон нутгийн иргэдийг оролцоог сайжруулах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх замаар бүртгэлгүй шилжигчдийг олж илрүүлэх, бүртгэх.
- (б) Шилжин суурьшигч хүн амын эмзэг дэд бүлгүүдэд чиглэсэн зорилтот арга хэмжээг зохион байгуулах, эдийн засгийн нөхцөл байдлыг нь сайжруулах төрийн үйлчилгээнүүдэд зуучлах.
- (в) Үндэсний, нийслэлийн болон засаг захиргааны бүхий л түвшинд шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, удирдан зохион байгуулах агентлаг, газар, хэлтсийг байгуулж дотоодын шилжилт хөдөлгөөнд зориулсан нөөц бололцоог илүү төвлөрсөн байдлаар удирдан зохицуулах.
- (г) Олон улсын хүний эрхийн хэм хэмжээг харгалзах, хот суурин газарт шилжих шалгуурыг хөнгөвчлөх, Улаанбаатарт хотод суурьшсан иргэдийг сайн дураараа буцах шилжилт хөдөлгөөн хийхэд нь дэмжлэг үзүүлэх зэргээр шилжилт хөдөлгөөний хэт хүнд хэлбэрийн хязгаарлалтаас зайлсхийх.
- (д) Дотоодын шилжилт хөдөлгөөний талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, үнэн бодит, цэгцтэй мэдээлэл, бодлого, шийдвэрийг нийгэмд түгээх.
- (е) Мэдлэг дээшлүүлэх кампанит ажлууд зохион байгуулж, шилжин суурьшигчдын давуу талуудыг нотолгоонд үндэслэн харуулах замаар шилжилт хөдөлгөөний талаарх хэм хэмжээ, сөрөг хандлагыг өөрчлөх; шилжин суурьшигчдын эрхийг таниулах, чадавхжуулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх, шилжигчдийн эрх, тулгардаг бэрхшээлийн талаар төрийн үйлчилгээний ажилтнуудад сургалт явуулах.
- (ё) Урт хугацаандаа хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн буй шилжилт хөдөлгөөнийг саармагжуулах, тогтворжуулах зорилгоор бүс, орон нутаг дахь хүн амын түлхэх хүчин зүйлүүдийг бууруулах.
- (ж) Дотоодын шилжилт хөдөлгөөний асуудлыг урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах.
- (з) Судалгааны ажлыг цаашид гүнзгийрүүлэх, нэмэлт судалгаа болон зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулах.



Хүснэгт 9 Богино, дунд болон урт хугацаанд зориулсан тодорхой бодлогын зөвлөмжүүд

Хугацаа	Бодлогын ерөнхий чиглэл	Тусгайлан бодлогын зөвлөмж	Хариуцсан агентлаг болон байгууллага
<p>Богино хугацаанд: Эрсдэл бууруулах хүчин чармайлт</p>	<p>Бүртгэлгүй шилжигчдийг тогтоох, бүртгүүлэх</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хорооны зохицуулагч, хэсгийн ахлагч, оршин суугч зэрэг нөхцөл байдлын талаарх бодит мэдээлэлтэй хамгийн ойр хүмүүстэй хамтран бүртгэлгүй иргэдийн талаарх мэдээллийг цуглуулах, тэднийг бүртгэлжүүлэх. 2. Орон нутагт байгаа бүртгэлгүй шилжигчдийг олж тогтоох, тэднийг албан ёсоор бүртгэлжүүлэхэд санхүүгийн болон техникийн дэмжлэгийг хорооноор үзүүлэх. 3. Олон улсын байгууллагууд, орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран бүртгэлгүй шилжигч хүн амын тоог үндэсний статистикийн системд оруулах, нэгтгэх, бүртгэлгүй иргэдийг олж тогтооход ОУШХБ-н "ДТМ" буюу нүүлгэн шилжүүлэхийн тандаалтын загвар, урсгал хөдөлгөөнийг хянах мэдээллийн олон арга хэрэгслүүдийг ашиглах. 4. Бүртгэлийг сайжруулахын тулд бүртгэлтэй байхын давуу талын талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлж, хэрхэн бүртгүүлэх талаар мэдээлэл өгөх. 5. Бүртгүүлэхэд шаардагдах шилжих зардалуудыг бууруулах (өргөдлийн хураамж, торгууль, тээврийн зардал, интернет ашиглалтын төлбөр гэх мэт), үйлчилгээг цахимжуулах, алслагдсан бүс нутагт байгаа бүртгэлгүй иргэдэд зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр бүртгэлийн явцыг хөнгөвчлөх, хялбарчлах. 	<ul style="list-style-type: none"> • Улаанбаатар хотын захиргаа гэдгийг Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар • Хороод • Олон улсын хөгжлийн байгууллага (тухайлбал ОУШХБ)
	<p>Шилжигч хүн ам доторх эмзэг бүлгүүдийн эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах, эмзэг байдлыг нь бууруулах</p>	<ol style="list-style-type: none"> 1. Ажил олох, зуучлах аэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх, өрх толгойлсон эмэгтэйчүүдэд зориулсан мэргэжлийн сургалтууд болон өөрийн гэсэн хөдөлх болон үл хөдөлх хөрөнгө (тухайлбал, машин болон байр)-тэй болоход хөнгөлөлттэй зээл олгох зэрэг эмзэг бүлгүүдэд чиглэсэн эдийн засгийн зорилтот багц арга хэмжээнүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх. 2. ХНХЯ-наас хэрэгжүүлж буй нийгэм, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд холбон зуучлах, хүнсний талон, тэтгэмж авах, сургалтын тэтгэлэг болон түүнтэй адил тусламжид хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх. Судалгааны үр айна дараах аэд бүлгүүдийг нэн эмзэг гэсэн ангилалд багтаасан: Өрхийн гол орлого бүрхүүлж буй гишүүн нь эмэгтэй, өндөр настан, боловсрол багатай (ахлах сургууль эсвэл түүнээс доош) хүн байх эсхүл тухайн өрхөд тэтгэврийн насны болон 14-өөс доош насны хүмүүс олон байх. 	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)</p>



Хугацаа	Бодлогын ерөнхий чиглэл	Тусгайсан бодлогын зөвлөмж	Хариуцсан агентлаг болон байгууллага
<p>Дасан зохицох, нутагшуулахаа чиглэсэн зөөлөн арга хэмжээ авах</p>	<p>Дотоодын шилжилт хөдөлгөөнд тусгайлан зориулсан санхүүгийн болон хүний нөөцийг хуваарилах, төвлөрүүлэх</p>	<p>Үндэсний, нийслэлийн болон засаг захиргааны бүхий л түвшинд шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, удирдан зохион байгуулах агентлаг, газар, хэлтсийг байгуулж дотоодын шилжилт хөдөлгөөнд зориулсан нөөц бололцоог илүү төвлөрсөн байдлаар удирдан зохицуулах.</p> <p>Дасан зохицох хөтөлбөр</p> <ol style="list-style-type: none"> 1. Хотын нөхцөл байдал, амьдралын орчны талаар мэдээлэл олгох, хөдөө орон нутгаас хот руу болон буцах шилжилт хөдөлгөөний талаарх хоёр талын ойлголт өгөх мэдээллийн аян зохион байгуулах, хэт эмзэг шилжигчдэд зориулан түр байраар хангах зэргээр хотын амьдралд дасан зохицуулах хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх. 2. Дотоодын эдийн засгийн гол хүч болох дундаж давхаргад чиглэсэн бизнес болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэх. <p>Мэдээллийн аян болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаануудад хамаатан садан болон хөршийн холбоо зэрэг орон нутаг дахь албан бус сүлжээг зохистойгоор ашиглах (Суаалгааны үр дүнгээс харахд Улаанбаатар хотод шилжин суурьшиж буй иргэд нь нийслэлийн байнгын оршин суугч өрхтэй харьцуулахад гэр бүл, хамаатан, найз нөхөд болон хөршийн холбооноос хоол хүнс, санхүү, сэтгэл зүйн дэмжлэг зэрэг албан бус тусалцаа авах харьцангуй боломжтой байдаг)</p> <p>Эргэн суурьшуулах хөтөлбөр</p> <ol style="list-style-type: none"> 1. Ажил эрхлэхэд нь дэмжих, тэтгэлэг олгох, нийгмийн үйлчилгээнд бүрэн хамруулах зэргээр орон нутгийн иргэдийг буцах шилжилт хөдөлгөөнд оролцохыг идэвхжүүлэх 2. ХНХЯ-ны харьяа 6 газрын хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдэд дотоодын шилжин суурьшигчдыг идэвхтэй хамруулах, тэдгээр үйлчилгээнүүдийг өргөжүүлэх (шилжин суурьшигч хүн ам доторх хөгжлийн бэрхшээлтэй, өсвөр насны, бизнес эрхлэгч иргэдэд түлхүү хүрч ажиллах). 3. Дотоодын шилжилт хөдөлгөөний асуудлыг үндэсний, бүсийн, орон нутгийн түвшинд эдийн засгийн хөгжил, бүс нутгийн хөгжил, хүний хөгжил, аэд бүтцийн хөгжил, боловсрол, уул уурхай болон байгаль орчны хамгаалал, эрүүл мэнд зэрэг салбарын бодлогуудад хэвтээ болон хөндлөн чиглэлд тусган хэрэгжүүлэх. 	<p>ХНХЯ</p>



Хугацаа	Бодлогын ерөнхий чиглэл	Тусгайлан бодлогын зөвлөмж	Хариуцсан агентлаг болон байгууллага
	<p>Хүний эрхийг зөрчсөн шилжилт хөдөлгөөний хэт туйлширсан хязгаарлалтаас зайсхийхийн хамтаар Улаанбаатарт суурьшсан иргэд сайн дураараа буцаж нүүхийг нь дэмжих</p>	<p>Ирээдүйд шилжин суурьших иргэдийн хувь:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шилжилт хөдөлгөөний хязгаарлалт нь хүн амын хөдөлгөөнийг зохицуулахад хамгийн эцсийн хатуу арга хэмжээ гэдгийг харгалзан илүү зөөлөн бодлогын арга хэрэгслүүдийг хэрэгжүүлэх. Тухайлбал, шилжин суурьшигчдыг шинэ газар дасан зохицох болон уугуул нутагтаа эргэн суурьшихад нь дэмжих хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлэх, үүнд шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах, урамшуулах. Шилжигч хүн ам доторх хамгийн эмзэг дэд бүлгүүдэд туслахын зэрэгцээ дундаж орлоготой шилжигч хүн амд нийгэм, эдийн засгийн дэмжлэг үзүүлэх, тэдний орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахад нь туслах. 2. Дотоодын шилжилт хөдөлгөөний хязгаарласан бодлого хэрэгжүүлэхээс өмнө ИБҮТЭТОУП-н 19 дүгээр зүйлд тусгасан нөхцөл, шалгуур үзүүлэлт, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 13 дугаар зүйл болон Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд тусгасан чөлөөтэй шилжин суурьших хүний эрхийн талаарх харгалзан үзэх. 3. Дотоодын шилжилт хөдөлгөөний талаарх аливаа бодлогын шийдвэр гаргасны дараа нийт хүн амд зөв зохистой мэдээлэл өгөх үүднээс дотоод шилжилт хөдөлгөөнийг таниулах, системтэй мэдлэг дээшлүүлэх мэдээллийн аянг хэрэгжүүлэх. Энэхүү судалгаагаар хоригийн үеэр шилжин суурьшсан иргэдийн 83 хувь нь хязгаарлалтын бодлогын талаар мэдээгүй байсан бөгөөд мэдсэн ч шилжин суурьших байсан гэж хариулсан нь энэ талаарх олон нийтийн ойлголт бага байсныг харуулж байна. <p>Суурьшсан шилжигч иргэний хувь:</p> <ol style="list-style-type: none"> 1. Уугуул нутаг руугаа буцаж шилжилт хөдөлгөөн хийж байгаа иргэдэд эргэн суурьшихаа дэмжих үйлчилгээнүүдийг санал олгох (ажлын байраар хангах, нийгмийн үйлчилгээнд бүрэн хамрагдауулах, хөнгөлөлттэй орон сууцны зээл гэх мэт). 2. 2007 онд Беларусь амжилттай хэрэгжүүлж байсан хот суурин газрын ажиггүй иргэдийг хөдөө орон нутагт ажиллуулахаар илгээх, эргэн суурьшуулах схемийг туршин хэрэгжүүлэх (Albert and Hárs, 2012). 	<p>Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар</p> <ul style="list-style-type: none"> • Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар • ХНХЯ

Хугацаа	Бодлогын ерөнхий чиглэл	Тусгайсан бодлогын зөвлөмж	Хариуцсан агентлаг болон байгууллага
	<p>Дотоодын шилжилт хөдөлгөөний талаарх сөрөг хэм хэмжээ, айдсын хандлагыг шийдвэрлэх</p>	<ol style="list-style-type: none"> 1. Шилжин суурьшигч нь хотод ямар давуу тал, үр чадвар (боловсролтой ажиллах хүчин, дотоодын эдийн засаг, үйлдвэрлэлд нэмэлт орлого, шинэ бизнес, үр чадвар гэх мэт)-г авчирч байгаа талаар мэдлэг дээшлүүлэх кампанит ажил, нийт хүн амд таниулах уулзалтуудыг зохион байгуулах (Дэлхийн банк, 2017; ХБСХ, 2016) 2. Дотоодын шилжин суурьшигчдад зориулан “Эрхээ Ойгох” кампанит ажлыг зохион байгуулж, тэднийг бусдад нөлөөлөгч болоход нь чадавхжуулах. 3. Шилжигчдийн нөхцөл байдал, эрхийн талаар төрийн албан хаагчдын бодлого, үйл ажиллагаана хэрхэн тусгасан талаар төрийн ажилтнууд, ялангуяа үйлчилгээний ажилтнуудад зориулан сургалт явуулах. 4. Шилжилт хөдөлгөөн хийх эрхийн талаар, үндэсний хууль тогтоомжийн талаар шилжигч болон шилжигч бус өрхүүдэд зориулсан мэдлэг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах. Бүртгэлгүй шилжигч иргэдийн 76 хувь нь шилжилт хөдөлгөөнийг хязгаарласнаар тэдний эрхийг зөрчөөгүй гэж хариулсан байна. Эндээс харахад иргэд нь үндсэн хуулинд заасан үндсэн эрхийг мэдэхгүй байгаа бөгөөд улс дотроо чөлөөтэй шилжих эрхийнхээ талаар ойлголтгүй байгаа юм. Монгол улсын Үндсэн хуулийн 16 аугаар зүйлд “улс дотроо шилжих суурьших, гадаад улс руу аялах, оршин суух, эх орондоо эргэн ирэх”⁹ эрхтэй гэж тусгасан байдаг¹⁰. 	<ul style="list-style-type: none"> • Иргэний нийгмийн байгууллага • Олон улсын түнш байгууллагууд • Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар • ХНХЯ • Боловсрол, Шинжлэх Ухааны Яам • Хүний Эрхийн Үндэсний Хороо

⁹ https://www.conscourt.gov.mn/?page_id=842&lang=en

¹⁰ <https://www.legalinfo.mn/additional/details/311?lawid=49>



Хугацаа	Бодлогын ерөнхий чиглэл	Тусгайлан бодлогын зөвлөмж	Хариуцсан агентлаг болон байгууллага
<p>Урт хугацаа: Урьдчилан сэргийлэх</p>	<p>Хөдөө орон нутагт амьдрахад түлхэгч хүчин зүйлсийг сааруулах, бүсчилсэн хөгжилд төвлөрөх</p>	<p>1. Дотоодын шилжин суурьшигчдын амьдралын нөхцөл, тэдэнд тулгарч буй саад бэрхшээлүүдийн талаарх ойлголт, тоо мэдээлэл, баримтуудыг нэгтгэх, бодит арга хэмжээ, үйлчилгээнүүдэд ашиглах, нэвтрүүлэх замаар бүс орон нутгийн хөгжлийн стратегийн хүрээ, төлөвлөлтөөр дотоодын шилжилт хөдөлгөөний асуудлуудыг тусгах, уялуулах.</p> <p>2. Монгол руу буцах хүсэлтэй, эсвэл гэр бүлийн гишүүдээрээ дамжуулан хөрөнгө оруулалт хийх сонирхолтой иргэдийг дэмжих, энэ чиглэлийн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, урамшуулах (татварын хөнгөлөлт, буцаан олголт, татварын хөнгөвчилсэн систем, бизнесийн хөнгөлөлттэй зээл, бэлэн мөнгө олгох, ажлын байр, байгууламжын төлбөрийг хөнгөвчлөх, газар эзэмших эрх олгох болон бусад дэд бүтцийн дэмжлэг үзүүлэх гэх мэт)</p> <p>3. Засаг захиргааны төвлөрлийг сааруулах, төрийн санхүүжилтийг уялуулан төлөвлөх, шинэчлэх. Орон нутгийн удирдлагуудад төсвийг захиран зарцуулах боломжийг бүрдүүлэх, илүү уян хатан санхүүжилтийг олгох, дэвшүүлсэн зорилтууд, хүлээгдэж буй үр дүнд үндэслэн хариуцлагын тогтолцоог бий болгох.</p> <p>4. Зам, цахилгаан, нийтийн тээвэр, өртөг багатай орон сууц, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн сүлжээг сайжруулах замаар хөдөө орон нутагт амьдрахад шаардлагатай “Шилжих зардал”-уудыг бууруулах.</p> <p>5. Ган, зуд зэрэг байгалийн гамшиг даван туулахад малчдын чадварыг дээшлүүлэх зорилгоор орон нутгийн удирдлага, засаг захиргааны түвшинд онцгой байдлын үед хохирлыг бага хэмжээнд байлгах, урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэх, нөхөн сэргээх арга хэмжээнүүдийг дээрээс доошоо, доороос дээшээ чиглэлд хэрэгжүүлэх, төлөвлөх, шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх. Байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах томоохон стратеги нь шилжилт хөдөлгөөн байдаг учраас орон нутгийн иргэдэд дотоодын шилжилт хөдөлгөөнд хэрхэн аюулгүй оролцох талаар мэдлэг, ойлголтуудыг сайтар олгох. Чингэхдээ шаардлагатай хүнсний болон бэлэн мөнгөн тусламжийг үзүүлэхийн зэрэгцээ малчдыг мэргэжлийн сургалт, жижиг бизнес хөгжүүлэх, даван туулах үр чадварыг хөгжүүлэх хөтөлбөрүүдэд хамрагдауулах.</p>	<p>Үндэсний хөгжлийн агентлаг</p> <ul style="list-style-type: none"> Засгийн газрын хэрэг эрхлэх газар <p>Сангийн яам</p> <p>Барилга хот байгуулалтын яам</p> <p>Онцгой Байдлын Ерөнхий Газар</p>

Хугацаа	Бодлогын ерөнхий чиглэл	Тусгайлан бодлогын зөвлөмж	Хариуцсан агентлаг болон байгууллага
	Урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө болон холбогдох эрх зүйн бичиг баримтад дотоодын шилжилт хөдөлгөөнийг тусгах	<ol style="list-style-type: none"> Дараах бодлогын баримт бичгүүдэд дотоодын шилжилт хөдөлгөөний талаарх асуудлуудыг тусгах, шинэчлэх: <ol style="list-style-type: none"> ТХЗ 2030 Алсын хараа-2050 (Улаанбаатар хот ба дагуул хотын төлөвлөлт) Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого 2016–2025 Улаанбаатар хотын мастер төлөвлөгөө 2020 Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө 2016–2020 Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль Дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөрүүд дотоодын шилжилт хөдөлгөөний асуудлыг тусгаж өгөх Улаанбаатар болон аймаг, сумын түвшинд орон нутгийн хөгжлийн төлөвлөлтийн бичиг баримтад дотоодын шилжилт хөдөлгөөний асуудлыг тусгаж өгөх 	<ul style="list-style-type: none"> Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Монгол улсын засгийн газрын хэрэг эрхлэх газар
	Дахин судалгаа хийж, гол оролцогч талуудтай зөвлөгөө хэлэлцүүлэг явуулах	<ol style="list-style-type: none"> Шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын бодлогын үр нөлөөллийн талаар илүү цогц, дэлгэрэнгүй эконометрикийн шинжилгээг эдийн засгийн хямрал, байгалийн гамшигт нөхцөл байдал нөлөөлүүдийг тооцохгүйгээр гүйцэтгэх. 2020 онд хийгдсэн хүн ам, орон сууцны тооллого, бүртгэл болон захиргааны тоо мэдээллийг ашиглан дотоодын шилжилт хөдөлгөөний урсгал мэдээллийг нарийвчлан тооцох. Улаанбаатар хотоос уугуул нутагтаа буцаж нүүсэн иргэдийн талаарх судалгааг гүйцэтгэх. Үүнд: буцах шилжилт хөдөлгөөн хийсэн шалтгаан, сэдэл, амжилтад хүрсэн хүчин зүйлүүдийг, дасан зохицоход дэмжих хөтөлбөр, бодлогын арга хэрэгслүүдийг судлах, санал болгох. Шилжилт хөдөлгөөний урсгалыг хэрхэн зөв зохистой зохицуулж байсан талаар Монгол улстай адил төстэй улс орнуудын харьцуулсан судалгааг гүйцэтгэх, тэдгээрийн сайн туршлагуудыг нэвтрүүлэх. Бодлогын зөвлөмжүүдийг сайжруулан хэлэлцэж, хэрэгжих боломжтой байдал, ач холбогдлоор нь эрэмбэлэх, үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, гол оролцогч талуудын дунд зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулах. 	<ul style="list-style-type: none"> Үндэсний статистикийн хороо, Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар статистикийн газар; Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар ХНХЯ, Үндэсний хөгжлийн агентлаг, олон улсын байгууллагууд болон ТИНК танк байгууллагууд



НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Дотоодын шилжилт хөдөлгөөн

Тухайн улс орны хилийн хүрээн доторх засаг захиргааны нэгж хооронд явагдах хүн амын суурьшлын өөрчлөлт, хөдөлгөөнийг хэлнэ. Энэхүү шилжин суурьших хөдөлгөөн нь түр болон бүрмөсөн байж болно. Шилжих хөдөлгөөний үндсэн үзүүлэлт нь шилжин ирэгчдийн тоо, шилжин явагчдын тоо болно. (ОУШХБ, 2020а)

Албан бус шилжилт хөдөлгөөн

Уугуул, дамжин өнгөрөх болон шилжин суурьших газарт нэвтрэх болон гарахад мөрдөгдөх олон улсын гэрээ хэлэлцээр, хууль, дүрэм журмаас гадуур явагдаж буй хүний хөдөлгөөнийг ойлгоно. Хэдийгээр албан бус шилжилт хөдөлгөөний талаарх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нэр томьёо байхгүй боловч ердийн шилжилт хөдөлгөөний сувгаас гадуур явагдаж байгаа хөдөлгөөн гэж ойлговол зохилтой. Албан бус сувгаар шилжин хөдөлгөөнд оролцож байгаа шилжигч гэдэгт дүрвэгсэд, хүний наймаанд өртсөн хүмүүс болон хараа хяналтгүй хүүхдүүд багтдаг. Хэдийгээр хүмүүс албан бус шилжин суурьших арга замуудыг сонгож байгаа ч тэднийг дамжин өнгөрүүлж, хүлээн авч буй орнууд олон улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай нөхцөлд аливаа хамгаалалтыг үзүүлэх үүрэггүй гэсэн үг биш билээ. Тухайлбал зөрчил мөргөлдөөн, хүчирхийлэл зэргээс зайлсхийн орогнол хайж байгаа хүмүүст олон улсын хамгаалалтыг үзүүлдэг. (ОУШХБ, 2020а)

Бүртгэл

Монгол улсын иргэний бүртгэлийн тухай хуулийн дагуу хувь хүний оршин суугаа хаягийг иргэний бүртгэлийн мэдээллийн санд бүртгэх үйл явцыг хэлнэ. (Монгол улсын их хурал, 2018)

Шилжин суурьшигч

Олон улсын хууль тогтоомжийн дагуу албан ёсны тодорхойлолт байхгүй боловч үүнд өөрийн байнгын амьдардаг орон нутгаас өөр газар, орон нутагт шилжин суурьшиж буй хүмүүсийг ерөнхийд нь илэрхийлэх бөгөөд тухайн шилжилт нь улс орон дотроо эсхүл хил дамжин, түр болон бүрмөсөн хугацаатайгаар байж болно. Энэхүү нэр томьёонд ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнд оролцож буй хууль ёсны шилжин суурьшигч этгээд, хууль бусаар хил давсан цагаач иргэд, гадаад улс оронд суралцаж буй оюутан болон бусад олон улсын хууль, тогтоомжид заагаагүй шилжигчдийн олон бүлгийг хамаатуулж ойлгоно. (ОУШХБ, 2020а)

